


МОНГОЛ УЛС  
СЭЛЭНГЭ АЙМАГ



# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

/2007-2021 он/



Сүхбаатар хот  
2007 он

# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН 2021 ОН ХҮРТЛЭХ ХӨТӨЛБӨР

## ГАРЧИГ

### Удиртгал

#### Нэг. Эдийн засгийн бодлого

- 1.1. *Эдийн засгийн хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн*
- 1.2. *Аж үйлдвэрийн хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн*
- 1.3. *Хөдөө аж ахуйн хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн*
  - 1.3.1. *Газар тариалан ба ургамлын аж ахуй.*
  - 1.3.2. *Хөдөө аж ахуй механикжуулалт.*
  - 1.3.3. *Мал аж ахуйн салбар.*
- 1.4. *ЖДУ, өрхийн аж ахуйн хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн.*
- 1.5. *Аялал жуулчлалын хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн.*
- 1.6. *Худалдаа үйлчилгээ, хэрэглээний хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн.*
- 1.7. *Дэд бүтэц.*
  - 1.7.1. *Зам, тээврийн хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн*
    - 1.7.1.1. *Төмөр замын тээврийн хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн*
    - 1.7.2. *Эрчим хүчний салбарын хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн*
    - 1.7.3. *Мэдээлэл, харилцаа холбооны хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн*
  - 1.7.4. *Барилга, хот байгуулалтын хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн*
- 1.8. *Банк санхүү, үнэт цаас, даатгалын байгууллагын хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн*

#### Хоёр. Нийгмийн бодлого

- 2.1. *Хүн амын өсөлт, хүний хөгжлийг хангах талаар*
- 2.2. *Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн*

**2.3. Боловсролын хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн**

**2.4. Эрүүл мэндийн салбарын хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн**

**2.5. Биеийн тамир, спортын хөгжил, хэрэгжүүлэх стратеги хүрэх үр дүн**

**2.6. Соёл урлагийн хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн**

**Гурав. Байгаль орчны ашиглалт, хамгаалалтын бодлого**

**3.1. Агаарын бохирдлыг багасгах талаар хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн**

**3.2. Газрын нөөцийн хамгаалал, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн**

**3.3. Усны нөөцийн хамгаалал, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн**

**3.4. Ойн нөөцийн хамгаалал, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн**

**3.5. Биологийн төрөл зүйлийн хамгаалал, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн**

**3.6. Байгалийн гамшгаас сэргийлэх, хохирлыг бууруулах талаар**

**Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нээлттэй засаглалын бодлого**

**4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нээлттэй засаглалын бодлого, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн**

**4.2. Гадаад харилцааны хөгжлийн үндсэн чиглэл, хүрэх үр дүн**

**4.3. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын үндсэн чиглэл**

**4.4. Эдийн засгийн өсөлтийг хангах үндсэн арга, хэрэгсэл**

**4.5. Олон нийтийн оролцоо**

**Тав. Хөтөлбөрийн санхүүжилт, үр дүн, хяналт шинжилгээ, үнэлгээ**

**5.1. Эдийн засаг, нийгмийн эцсийн үр дүн**

**5.2. Шаардагдах хөрөнгө, санхүүжүүлэх эх үүсвэр**

**5.3. Хөтөлбөрийн эдийн засгийн гол үр дүн**

**5.4. Хөтөлбөрийн хяналт шинжилгээ үнэлгээ**

**Ашигласан материалууд.**

## УДИРТГАЛ

Даян дэлхийн хэмжээнд өргөн хүртээл болж байгаа даяарчлалын бодлого, хандлагаар аливаа улс, аймаг, сум, баг, аж ахуйн нэгж, хувь хүний хөгжил дэвшлийн түвшин тодорхойлогдох болсон эрин үеийн нөхцөлд бид амьдарч, аж төрж байгаа болохоор хөгжлийн бодлогоор түүнтэй алхаагаа нийлүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Даяарчлалыг эсэргүүцдэг улс үндэстэн, үзэл баримтлал, онол номлол байдаг боловч хэн нэгэн хүний хүсэл зоргоор бус, хүн төрөлхтний соёл иргэншлийн хөгжил дэвшлийн зүй тогтлын дагуу энэ шинэ хандлага аяндаа буй болсон болохоор түүнийг сүүдэртэй талаас нь ажиглаж тандах, эсэргүүцэн шүүмжлэх бус, гэрэл гэгээтэй, оюунлиг талаас нь харж хүлээн авч Монгол улсын хөгжлийн 2008-2021 он хүртлэх хөгжлийн стратегийг цогц бодлогын хүрээнд аймаг, сумаа хөгжүүлэх асуудлыг боловсруулах нь бидний эрхэм зорилт болж байна. Үүний тулд бид, өчигдөрөө шинжлэх ухаанчаар судалж, өнөөдрөө шинэ хандлагаар дүгнэн, маргаашаа шинээр төсөөлөх нь даяарчлалын их түрлэгтэй хөл нийлүүлэн алхах үндсэн арга зам юм.

Улс төр, нийгэм, эдийн засгийн өнөөгийн тогтолцоог 1990-ээд оны эхэн үетэй харьцуулбал улс төр нийгмийн тогтолцоо үндсээрээ өөрчлөгдөж, эдийн засаг либеральчлагдаж харьцангуй эрх чөлөөтэй болсон боловч эдийн засгийн хөгжлийн хурдац бодож төлөвлөснөөс удаан байгаагийн учир нь засаглалын ажлын арга барилд байна уу, аль эсвэл бидний мэдээгүй аж ахуйчлалын өөр механизмд байна уу, ерөөсөө хүний хүчин зүйл нөлөөлөөд байна уу гэдгийг сайтар бодох шаардлагатай болсон тийм үед бид тулж ирсэн байна.

Манай аймаг бол Монгол улсын байгаль цаг уур, биологийн ресурс, хөрс шороо, газар тариалан, мал аж ахуй, түүх соёлыг судлахад олон үеийн эрдэмтэдийн анхаарал сонирхолыг татсаар ирсэн боловч ийм өвөрмөц онцлогтоо тохирсон тогтвортой хөгжлийн зохистой бүтэц бүхий эдийн засагтай болж чадаагүй өдий хүрсэн нь чухам юутай холбоотой вэ гэдгийг дүгнэж, цэгнэх цаг нэгэнт болжээ.

Энэ шаардлагын улмаас тус аймгийн өнгөрсөн хугацааны ажлын үр дүн, явцад шинжлэх ухааны үндэстэй дүгнэлт хийж үзээд аймаг орон нутгийнхаа хөгжлийг төр засаглалын 4 жилийн хугацаанд хэрэгжих мөрийн хөтөлбөрөөр бус, бага, дунд, урт хугацааны хөгжлийн байдал төлөвийг тооцож, ирээдүйгээ илүү итгэлтэй харсан стратегийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байгаа тул Сэлэнгэ аймгийн 2021 он хүртлэх хөгжлийн хөтөлбөр боловсруулах шийдвэрийг Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээс гаргасан билээ.

Үүний дагуу аймаг орон нутгийнхаа өнөөгийн хөгжлийн чиг хандлага, авч хэрэгжүүлсэн бодлого зохицуулалтын арга хэмжээ, хүрсэн үр дүнд үндэслэн сум байгууллага, иргэдийн санал, эрдэмтэд, судлаачдын, зөвлөмж, аймгийн бодлогод тулгуурлан "Сэлэнгэ аймгийн хөгжлийн 2021 он хүртлэх хөтөлбөр"-ийг боловсруулсан юм. Энэхүү хөтөлбөр нь Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, аймгийн иргэдийн хурлаас баталсан засаг захиргаа нутаг дэвсгэрийн бүсүүдийн дунд хугацааны стратеги (2010 он хүртэл), Монгол улсын бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль, Төвийн бүсийн хөгжлийн хөтөлбөр болон шинэ тогтолцоонд шилжиж эхэлсэн үеэс өнөөг хүртэл хэрэгжүүлж ирсэн хөгжлийн бодлогын бусад баримт бичгүүдийн үзэл санаа, хэрэгжилтийн явц, үр дүн, залгамж чанар нь манай хөтөлбөрт тусгалаа олсон бөгөөд энэхүү хөтөлбөрийг боловсруулах үзэл баримтлалын шинжлэх ухаан, төр эрх зүйн үндэслэл болсон юм.

Аймгийн нийт нутаг дэвсгэр 4115.3 мянган га, 17 сум, 49 баг хороо, Сүхбаатар, Зүүнхараа, Хөтөл зэрэг орон нутгийн 3 хот, 4000 хүн амтай 5 тосгонтой 2007 оны 1-р сарын 1-ний байдлаар 91,9 мянган байнгын оршин сууж аж төрдөг хүн амтай боллоо.

Сэлэнгэ аймаг 1931 онд "Тариалангийн" гэсэн тодотгол нэртэйгээр байгуулагдаж төв нь Алтанбулаг нэртэй байсан ба 1934 онд Сэлэнгэ аймаг гэж нэрлэгдэх болсон. Тус аймаг улсын бүх газар нутгийн 2,7-хон хувийг эзэлдэг боловч улсын ойн нөөцийн 10

гаруй, урсгал усны 55 шахам хувь нь манай аймагт ноогддог. Хүн амын нягтрашилтаар улсдаа дээгүүрт ордог. 2005 онд дэлхийн дунджаар нэг хүнд 2.7 га, Монгол Улсын дунджаар 61 га газар ногдож байхад Сэлэнгэ аймагт энэ үзүүлэлт 44.7 га байна.

2005 оны байдлаар 1000 хүнд ногдох төрөлт 19.3, нас баралт 4.7, цэвэр өсөлт 14.6 байгаа нь 2000 оныхоос төрөлт 29.4 хувь, цэвэр өсөлт мөн 33.5 хувиар буурчээ. Шилжих хөдөлгөөн сүүлийн жилүүдэд их байгаа нь хүн амын жилийн дундаж өсөлт бууралтын механик шалтгаан болж байна. Сүүлийн 5 жилд нийт 10,1 мянган хүн шилжин явжээ. Иймд хүн амын гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөнийг сааруулж, өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх бодлого баримтлах шаардлагатай байна. Аймгийн хэмжээнд ажилгүйдлийн түвшин 4.1 хувь, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрх нийт өрхийн 20 гаруй хувийг эзэлж байна.

Тус аймгийн хөдөлмөрийн насны хүн амын 34,5 хувь нь хөдөлмөр эрхлээгүйн улмаас ажилгүйдэл дагасан ядуурал буурахгүй байгаад сум, багийн засаг дарга нар онцлон анхаарч, үр өгөөжтэй, алсын хараатай, бодитой ажил зохион байгуулах шаардлагатай байгаа бөгөөд, баг, сумдын ажил дүгнэхдээ ажлын байр, өрхийн дундаж орлого хэрхэн нэмэгдэснийг хамгийн гол үзүүлэлт болгох нь зүйтэй юм. Энэ чиглэлээр ямар сумын, аль багийн засаг дарга юу хийсэн, хэн хэнийг ажлын байраар хангасан, хэний орлого яаж нэмэгдэснийг ямар нэгэн илтгэх хуудас, тайлан, ам мэдээгээр бус, мэдээллийн сангийн тусламжтайгаар Аймгийн Засаг даргын тамгын газарт хянах бүрэн боломжтой болоод байна.

Цаашид аймгийн хөгжлийн дэд бүтэц, экологийн давуу тал, бусад нөөц боломжийг ашиглан өрхийн үйлдвэрлэлийг төрийн, төрийн бус бүх шатны байгууллага анхаарлынхаа төвд байлгаж, зайлшгүй хэрэгжүүлэх жинхэнэ ажил болгож жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг бүх талаар дэмжин ажлын шинэ байрыг олноор бий болгох, эдийн засгийн өсөлт, тэргүүлэх салбаруудын хөгжил, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй нягт уялдсан хөдөлмөр эрхлэлтийн оновчтой бодлогыг аймгийн хэмжээгээр боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Сэлэнгэ аймагт соёл, боловсрол, эрүүл мэндийн салбарын хүрээний тулгамдсан асуудлууд ч цөөнгүй байна. Хүм амыг өвчилсөн хойно нь бус, өвчлөхөөс нь өмнө эмчийн урьдчилсан үзлэгт бүрэн хамруулах замаар хүн амынхаа эрүүл мэндийг сайжруулах бодлогын шинжтэй ажлын зарим эхлэл байгаа боловч орчин үеийн шаардлагыг хангаж чадахгүй байна.

Хөгжил гэдэг нь эцсийн дүнгээрээ хүний хөгжлийн түвшингээр хэмжигддэг үзүүлэлт болохоор хүнээ хөгжүүлэх тухай асуудал төр, захиргааны бүх шатны байгууллагын анхаарлын төвд байвал зохих амин чухал асуудал юм. “Хүн болох багаасаа”, “Буруу хүмүүжсэн хүүхэд бухын хүзүүнээс хатуу” гэж эцэг өвгөд маань сургасаар ирсэн нь хүний хөгжлийн зүй тогтлын талаар монголчуудын олон зууны амьдралаар батлагдсан сонгодог гүн ухааны цогц сургаал юм.

Хүүхдийн хүмүүжлийг эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгч нар бие биендээ найдаж, өөр хоорондоо түлхэлцдэг гаж зуршил түгээмэл шинжтэй болжээ. Суралцагсад 7 хоногийн 168 цагийн 60-ыг буюу 35 хувийг сургуулийн орчинд, үлдсэн 65 хувийг гэрийн орчинд өнгөрөөдөг хэдүй боловч ухаарлын хамгийн идэвхтэй мэдээллийг сургуулийн орчноос авдаг тул багш сурган хүмүүжүүлэгчдийн үүрэг, хариуцлага тун их юм. Иймд хүүхдийн биеэ авч явах ухамсар, эх орноо хайрлах сэтгэл, нийгмийн харилцааны ёс зүй зэрэг хүний хөгжлийн түлхүүр болсон үнэ цэнтэй бүхнийг багаас нь ухааруулж төлөвшүүлэх талаар эцэг эх, боловсролын байгууллагуудын хамтын чармайлтаар эрс шийдэмгийн алхам хийх шаардлагатай байна. Энэ нь зөвхөн нэг аймгийн явцуу хүрээний асуудал бус, улс орны ирээдүйн хувь заяатай шууд холбоо бүхий стартегийн бодлого юм.

Тус аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд зарим нэг нааштай өөрчлөлтүүд гарч байгаа боловч ирээдүйгээ итгэлтэй харж, урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд шийдвэрлэх шаардлагатай томоохон асуудлууд цөөнгүй байна. Тухайлбал, манай аймаг нь эдийн засаг, экологийн туйлын тааламжтай нөхцөлд байдаг боловч 1 хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ нь бүсийнхээ бусад аймгуудаас харьцангуй бага байгааг анхаарахгүй байж болохгүй байна.

Хөгжлийн алсыг харсан, зохистой бодлого боловсруулж, хэрэгжүүлсэн нөхцөлд аймгийн эдийн засагт аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх боломж их байна.

Ойрын жилүүдэд ашигт малтмал олборлолтыг эрчимжүүлж, “үйлдвэрлэлээс хэрэглэгчийн ширээнд” гэсэн бодлогоор эрчимжсэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дээр суурилсан тогтвортой, өндөр хурдацтай, даацтай өсөлт бүхий эдийн засгийн зохистой хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн цогцолбор бүтэцийг бий болгох стартегийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Статистикийн судалгаанаас үзэхэд өнгөрсөн оны байдлаар 9,4 мянга мапчин өрхийн 21,5 мянган хүнд 774,1 мянган мал тоологджээ. Нийт сүргийн дотор тэмээ 0.05, адуу, 5.3, үхэр 10.9, хонь 43,9, ямаа 39,9 хувийг эзэлж байна. Ямааны аж ахуй эрхлэх нь эдийн засгийн хувьд ашигтай мэт дүр зураг одоохондоо ажиглагдаж байгаа боловч ямаан сүргийн тоо ийнхүү огцом өссөнөөр нүүдлийн мал аж ахуйн олон зууны уламжлалт зохистой бүтэц, улмаар тус аймгийн нутаг дэвсгэр дээрх ургамлын нөмрөг бэлчээр үндсээрээ өөрчлөгдөж, бэлчээр талхагдах явцыг хурдасгах гол хүчин зүйлүүдийн нэг болж байгаад сэтгэл зовнихгүй байхын аргагүй байна. Иймд ноолуурын гарц сайтай ямаан сүргийн тоог нэмэгдүүлэх селекцийн урамшилт бодлого явуулах замаар нийт мал сүргийн уламжлалт зохистой бүтцийг сэргээх эдийн засгийн оновчтой бодлого боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүний дээр 4,5 сая га талбайд геологийн хайгуул судалгаа хийж, алт олборлох зэрэг механик нөлөөллийн улмаас олон төрлийн ургамал сүйдэж, малын билчээр, тэжээлийн нөөц хязгаарлагдах аюул хаалга тогшиж эхэллээ.

Тус аймаг дэд бүтцийн давуу байдлаа бүрэн ашиглаж эрчим хүч, зам тээвэр, харилцаа холбооны хангамжийг нэмэгдүүлж хөдөөгийн хөгжлийг сайжруулах үндсийн үндэс болсон өрхийн аж ахуйг төрийн бодлогын түвшинд дэмжиж хөгжүүлэх замаар ажилгүйдлийг бууруулах боломж нөхцөл бүрдүүлэхэд төрийн, төрийн бус бүх шатны байгууллага онцлон анхаарч, үр өгөөжтэй, бүтээлч ажил зохион байгуулах шаардлагатай байна.

Холбооны үйлчилгээнд өндөр хурдны сүлжээт тоон системийг бүрэн нэвтрүүлэх, хөдөлгөөнт холбоог ашиглан баг, хот айл, малчдыг холбоожуулах, мэдээллийн технологийг айл өрхөд хүргэх, холбоо мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох, хиймэл дагуулын болон бага багтаамжийн радио релейн шугам, хөдөлгөөнт холбоог ашиглан баг, хот айл, малчдыг холбоожуулах шаардлагатай байна.

Улаан-Овоогийн нүүрс, Төмөртэй-Баянголын төмрийн хүдрийн, Хараа, Ерөө голуудын сав газрын алтны үндсэн ба шороон орд газрыг ашиглах зэрэг ашигт малтмал, эрдэс баялгийн арвин нөөц бүхий зарим орд илэрцүүд нь олборлох, боловсруулах үйлдвэрийн таатай нөхцөлийг бүрдүүлж байна. Сэлэнгэ аймагт буй байгалийн сонин тогтоцтой газар нутаг, түүх соёлын дурсгалт газруудад археологийн хайгуул судалгааг сайтар явуулж, баталгаажуулан дэлхийд алдаршуулах замаар түүх соёлын аялал жуулчлалыг олон улсын хэмжээнд хөгжүүлэх өргөн боломжийг дээд зэргээр ашиглах шаардлагатай байна.

Байгалийн бусад нөөцийн олборлолт, ашиглалт, хамгааллын холбогдолтой шийдвэрлэвэл зохих асуудлууд ч цөөнгүй байна. Сүүлийн жилүүдэд малын тоо толгой өсөж, худаг ус тойрсон бага хэмжээний газар олон тооны мал төвлөрч бэлчээрийн талхагдлыг ихэсгэж, нийт нутгийн хэмжээгээр бэлчээрийн даац хүрэлцэхгүй болох байдал ажиглагдаж байна.

Мод сөөг ургамлыг зөвшөөрөлгүйгээр огтолж ашиглах явдал ихсэж аймгийн төв, суурин газрын ойролцоох бургас, сөөг ургамлын нөөц эрс багасчээ. Үүнээс үүдээд элсний нүүдлийг зогсоох, цөлжилтөөс хамгаалах явдал байгаль хамгааллын тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Тус аймагт байгаа бүх төрлийн нөөц боломж, давуу талыг орчин үеийн технологийн өндөр түвшинд оновчтой ашиглах замаар хөдөө аж ахуй, хөнгөн, хүнсний аж үйлдвэрийг аялал жуулчлалын салбартай нягт хослох замаар Сэлэнгэ аймгийн эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, эдийн засгийн өндөр ашигтай бүтцийг бий болгон эрчимтэй хөгжүүлэх шаардлагатай байна.

Манай аймаг нь газар нутгийн байршил, стратегийн гол бүс нутгийн хувьд гурил, гурилан бүтээгдэхүүний гол түүхий эд болох улаан буудайн нутагшсан сортуудыг бий болгож, үйлдвэрлэлийг урамшуулах замаар газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулж, өөрийн түүхий эдээр эх орны хэрэгцээг найдвартай хангах нь нэг талаар Сэлэнгэчүүдийн нэр төрийн хэрэг, нөгөө талаар улс орны хувьд стратегийн ач холбогдолтой юм. Ийм учраас үүнд чиглэсэн алсын хараатай бодлого зохицуулалтыг **Засгийн газрын дэмжлэгтэйгээр** иж бүрэн шийдвэрлэх асуудлыг энд зориуд авч үзсэн болно.

Тариалангийн үйлдвэрлэлд усалгаатай тариалан, хөрс хамгаалах техник, технологийн шинэчлэлийг тууштай үргэлжлүүлэн, үр тариа, төмс, хүнсний ногооны элит үрийн аж ахуйг түлхүү хурдацтай хөгжүүлэх замаар 2010 гэхэд улаан буудайн үйлдвэрлэлийн хэмжээг 1990 оны түвшинд хүргэж, олон наст өвсний үр, царгас, вандуй, төмс, арвай, сагаг зэрэг экологийн цэвэр бүтээгдэхүүнийг үлдвэрлэх, экспортлох шаардлагатай байна.


Тус аймгийн 2021 он хүртлэх хөгжлийн хөтөлбөрт дэвшүүлсэн тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг томъёолохдоо Орхон-Сэлэнгэ, Хараа, Ерөөгийн сав нутгийн ойт хээрийн бүс нутгийн онцлог, аймгийн дотоод, гадаад нөхцөл байдалд нарийвчилсан дүн шинжилгээ хийж, хөгжлийн давуу болон сул талуудыг тодруулан хөтөлбөрт харгалзсан юм.

**Сэлэнгэ аймгийн ирээдүйн хөгжлийн алсын хараа нь орчин үеийн технологид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээг үе шаттай нэрэгжүүлэх замаар хүний хөгжлийг дээдэлж, байгаль орчныхоо онцлогт нийцсэн, зах зээлд өрсөлдөх боломжтой, оновчтой бүтэц бүхий, өөрийгөө тэтгэдэг эдийн засагтай аймаг болгоход оршино.**

Тухайн асуудалд энэ байр сууринаас хандаж боловсруулсан хөгжлийн хөтөлбөр нь:

1. Эдийн засгийн бодлого;
2. Нийгмийн бодлого;
3. Байгалийн орчны ашиглалт, хамгаалал,
4. Засаглалын бодлого

5. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ гэсэн өөр хоорондоо нягт уялдаа бүхий 5 бүлгээс бүрдэж байгаа юм.



Энэ нь байгаль орчинд халгүй өөрийгөө тэтгэх эдийн засгийг хөгжүүлж хүн ардынхаа нийгмийн хөгжлийн хамт сайн засаглалын бодлогоор дээр томъёолсон Сэлэнгэ аймгийн хөгжлийн алсын хараа буюу стратегийн зорилтыг хэрэгжүүлэх юм.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг цаг хугацаа, хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийн хувьд нарийвчлан тодорхойлох, мөн хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэн, хяналт - шинжилгээ тогтмол хийж байхын тулд боловсруулсан **"Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт - шинжилгээ, үнэлгээ"**, макро үзүүлэлтүүдийн прогноз, дотоодын нийт бүтээгдэхүүний динамик прогноз, шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжүүр үзүүлэлтийн урьдчилсан төсөөллийг тусгалаа.

Сэлэнгэ аймгийн хөгжлийн хэтийн төлөвийг **2007-2012, 2013-2021 он гэсэн 2 үе** шатаар авч үзвэл дараах дүр зураг харагдаж байна. Үүнд:

**Хөтөлбөрийн нэгдүгээр үе шат (2007-2012 он)-ны эцэст** эдийн засгийн даац бүхий тогтвортой өсөлтийг хангах тааламжтай нөхцөл бүрдэж дотоодын нийт бүтээгдэхүүнийг жилд дунджаар 18,0 хувиас доошгүйгээр өсгөхийн зэрэгцээ экспортын үйлдвэрлэл өргөжиж, аймгийн эдийн засагт аж үйлдвэр, аялал жуулчлал үйлчилгээний салбар зонхилох байр суурь эзэлж, орчин үеийн шинжлэх ухаан техник, технологийн дэвшил, мэдлэг, мэдээллийн технологид суурилсан эдийн засгийн тогтвортой хөгжлийн үндэс суурь тавигдана.

Эрэлт хэрэглээ нь байнга өсөн нэмэгдэж байгаа улаан буудай, мах, сүү, хүнсний ногооны экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн экспортын чиг баримжаатай эрчимжсэн фермерийн аж ахуйнууд, мал амьтны гаралтай түүхий эд, газар тариалангийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүд байгуулагдаж, хүн амын хүнсний хангамж сайжирна.

Хөрсний элэгдэл эвдрэл, бэлчээрийн талхагдал багасаж, хог хаягдлын менежментийг боловсронгуй болно.

Аймгийн хүн амын амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн тоо болон ажилгүйдлийн түвшин 2006 оны түвшингээс 2 дахин буурна.

Боловсролын тогтолцоо шинэчлэгдэж, сургалтын чанар, материаллаг бааз, менежмент сайжирч, ерөнхий боловсролын сургуулиуд 11 жилийн тогтолцоонд бүрэн шилжиж, 12 жилийн тогтолцооны эхлэлийг бүрдүүлнэ.

Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа боловсронгуй болж, оношлогоо, эмчилгээний чадавхи сайжран, үйлчлүүлэгчдэд ээлтэй үйлчилгээний таатай орчин бүрдэж, хүртээмж, чанар нь сайжирна.

Аймгийн зам тээвэр, эрчим хүчний, сүлжээ оновчтой өргөжиж, хүн амын өсөн нэмэгдэж буй хэрэгцээг бүрэн хангах үндэс суурь тавигдана.

Газар хөдлөл, гал түймэр, усны үер, мал амьтны гоц халдварт өвчин зэрэг гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх ажил сайжирч, аюулд өртсөн тохиолдолд хохирлыг харьцангуй богино хугацаанд арилгах чадавхи бүрдэнэ.

Хөгжил гэдэг нь оюун ухаан, бие бялдрын өв тэгш хөгжилтэй хүний хөгжлийн түвшингээр тодорхойлогдоно гэж үзвэл орчин цагийн Сэлэнгэчүүдийн хөгжлийн хэмжүүр болж байна.

Сэлэнгэчүүдийнхээ оюуны энэ их чадавхийг эргэлтэнд оруулж, оюуны хөрөнгө оруулалтын шавхагдашгүй сан болгохын тулд чадах бүхнээ хийх нь бидний эрхэм зорилт байх ёстой. Ийм учраас энэхүү хөгжлийн хөтөлбөрийг шинжлэх ухааны түвшинд боловсруулж хэрэгжүүлэхэд та бүхний санал бодлоор баяжуулан, Сэлэнгэчүүдийнхээ оюуны чадавхийг эргэлтэнд оруулах замаар хөгжлийн хөрөнгө оруулалтын сан болгох боломжийг бүрдүүлэх зорилт тавьж байгаа юм.

“Бие бялдар оюун ухааны өв тэгш хөгжилтэй хүн бол хөгжлийн үндэс” гэдэг бодлогыг байнгын эрхэм зорилт болгож, 21-р зууны хөгжлийн жолоог найдвартай залах оюуны өндөр чадавхитай мэргэжилтнүүдийг бэлтгэх шаардлага тус аймгийн Соёл, боловсрол, эрүүлийг хамгаалах, шинжлэх ухааны бусад салбарынхны өмнө тавигдаж байна.

Монголын олон ястан үндэстэн эв найртай амьдарч нутагшин ээнэгшсэн Монгол улсын хоймор Сэлэнгэ сайхан нутгийнхаа түүх соёлын дурсгалт зүйлс, өв санг судалж тодруулан сурталчлах замаар түүх-соёлын олон улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх бас нэг сайхан боломж байна.

**Хөтөлбөрийн хоёрдугаар үе шат (2013-2020 он)** Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлт 20,0 хувиас доошгүйгээр тогтвортой өсч, экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэн, аймгийн эдийн засгийн бүтэц сайжирч, хувьсан өөрчлөгдөж байгаа байгал цаг уурын нөхцөлд дасан зохицсон эрчимжсэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дээр суурилсан орчин үеийн аж үйлдвэр-үйлчилгээ гэсэн загварт бүрэн шилжиж, эдийн засгийн салбарын зохистой бүтэц улам боловсронгуй болно. Энэ үе шатанд хүн амын ажилгүйдэл буурч, ядуурал өр багассан байна. Мөн ус, хөрсний бохирдол, эвдрэл, бэлчээрийн талхагдал эрс буурч, хүн ам төрж өссөн нутагтаа ая тухтай амьдрах таатай орчин бүрдэнэ.



Иймд энэхүү хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, төсөөлж байгаа үр дүндээ хүрэхийн тулд бид юу хийх ёстой вэ гэдэгт анхаарлаа хандуульяа. Үүнд:

### **Нэг.Эдийн засгийн бодлого**

Сэлэнгэ аймаг нь Хөдөө аж ахуйн чиглэлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ давамгайлсан, байгалийн нөөц баялагт тулгуурласан жижиг дунд үйлдвэр, өрхийн аж ахуйн үйлдвэрлэл, уул уурхайн үйлдвэрлэл бүхий эдийн засгийн хөгжлийн стратегийг сонгож байна.

Аймгийн эдийн засгийн хөгжлийн бодлогын гол зорилт нь 2007-2012 онд Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтын хүрээнд хийгдэж буй Үндэсний Хөгжлийн цогц бодлого, Монгол улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх дунд болон урт хугацааны үндсэн чиглэлийг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн эдийн засгийн өсөлтийг жилд дундажаар 15 хувьд, нэг хүнд ногдох ДНБ-ийг 1.0 мянган ам. долларт хүргэж, мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурийг тавих, 2013-2021 онд эдийн засгийн өсөлтийг дундажаар 20 хувьд хүргэх мэдлэгт суурилсан эдийн засгийг төлөвшүүлэн хөгжүүлж, нэг хүнд ногдох ДНБ-ийг 3.0 мянган ам. доллар болгож эдийн засгийн чадавхи, нөөц боломжийг бүрдүүлэхэд оршино. Хөдөлмөрийн бүтээмж, хөрөнгө оруулалтын үр ашгийг тасралтгүй дээшлүүлэх замаар эдийн засгийн эрчимтэй өсөлтийг бий болгоно. Эрчимжсэн мал аж ахуй, усалгаатай газар тариаланг нэмэгдүүлж, өрхийн аж ахуйн эзлэх байр суурь, ашигт малтмалын олборлолтыг 2007-2012 онд нэмэгдүүлж, 2013-2021 онд хөдөө аж ахуйн салбарт нэгжээс гарах бүтээгдэхүүний гарц, өрхийн аж ахуйд бүтээгдсэн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, ашигт малтмалын олборлолтыг сааруулж, бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

#### **1.1.Эдийн засгийн салбарын хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн**

##### **Хөгжлийн Нэгдүгээр үе шат (2007-2012 он)**

**Тэргүүлэх зорилт 1.** Аймгийн эдийн засгийн салбарын бүтцэд эрчимжсэн газар тариалан ба ургамлын аж ахуй, мал аж ахуй давамгайлан аймгийн ДНБ-ний жилийн дундаж өсөлтийг 15.0 хувьд хүргэнэ.

##### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Хувийн хэвшлийн салбарт хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн нэр төрөл, тоо хэмжээ болон аймгийн нийт үйлдвэрлэх бүтээгдэхүүнийг статистик мэдээнд оруулах
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн өсөлтийг тогтвортой хангах, материал техник санхүүгийн боломжийг тогтвортой төвшинд барих
- Мал аж ахуй, газар тариалангийн түүхий эдэд түшиглэсэн боловсруулах үйлдвэрлэлийн салбарт гадаадын зээл тусламжийг түлхүү хуваарилуулан ашиглах талаар төр, Засгийн газартай нягт хамтран ажиллах
- Хүн амын хоол хүнс, өргөн хэрэглээний бараа, түүхий эдийн бөөний худалдааны сүлжээг өргөтгөн хөгжүүлэх
- Аймаг сумдад хөдөө аж ахуйн хөгжлийг дэмжих сан байгуулж, банк, санхүүгийн уян хатан оновчтой тогтолцоо бүрдүүлэх
- Аймгийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөв боловсруулж санхүүжилтийн механизмийг бий болгож түүнийг мөрдөх журамд бүрэн шилжих

**Хүрэх үр дүн:** Аймгийн эдийн засагт хөдөө аж ахуй ба үйлчилгээний салбар хөгжиж тэргүүлэх байр суурьтай болох үндэс суурь тавигдана.

**Тэргүүлэх зорилт 2.** Аймгийн ДНБ-ний үйлдвэрлэлд аж үйлдвэрийн салбарын хувийн жинг нэмэгдүүлнэ.

##### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Эдийн засгийн өндөр ач холбогдолтой ашигт малтмалын олборлох болон боловсруулах үйлдвэрүүдийг Ерөө ба Сэлэнгэ, Хараа-Орхоны бүсэд байгуулах

- Газрын хэвлийн баялагаас төмрийн хүдэр, нүүрс, алт, барилгын материалын чиглэлээр ашиглах үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх
- Шинэ техник, технологийг алт олборлох ба хүнсний үйлдвэрт өргөн нэвтрүүлэх замаар бүтээгдэхүүний гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлж, хар металлургийн үйлдвэрийн экспортын бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд гаргах.
- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үйлдвэрлэл, технологийн парк байгуулах.
- Эрчим хүч, зам тээвэр, харилцаа холбоо, мэдээллийн сүлжээгээр аймгийн бүсүүдийг бүрэн хангах зохион байгуулалтын арга хэмжээг авах
- Аялал жуулчлалын салбарыг эрчимтэй хөгжүүлж, эдийн засгийн өсөлтөд мэдэгдэхүйц нөлөө бүхий салбар болгох
- Зэлтэрийн хилийн боомт, гарцуудыг нээх, боомтын барилга байгууламжийн асуудлыг шийдвэрлэж хилийн бүсийн худалдааны таатай нөхцлийн бүрдүүлэх
- Аймгийн хэмжээнд нүүрсний нөөцийг нэмэгдүүлэх, экспортлох, түлшний модны хэрэглээг багасгах бодлого боловсруулан хэрэгжүүлэх
- Барилгын материалын бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэх

**Хүрэх үр дүн:** Аймгийн эдийн засагт аж үйлдвэрийн салбар давамгайлах нөхцөл бүрдэнэ.

**Тэргүүлэх зорилт 3:** Төсвийн урсгал зардлын бүтцийг оновчтой болгож аймгийн төсвийн зарлагын зохистой харьцааг хангаж, өөрөө өөрийгөө санхүүжүүлнэ.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Төсвийн ерөнхийлөн захирагч, менежер нарын санхүү, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх
- Төсвийн төлөвлөлтийг сайжруулж, үргүй зардлыг бууруулах
- Бүх сумдыг төрийн сангийн нэгдсэн сүлжээнд холбож төсвийн зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулах
- Татварын бааз суурийг өргөтгөх, татвар хураах үйл ажиллагааг сайжруулах замаар орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх
- Төвлөрлийг сааруулж орон нутгийн санхүүгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх

**Хүрэх үр дүн:** Аймаг бие даан хөгжих нөхцөл бүрдэж зардлаа орлогоороо бүрдүүлж аймгийн ДНБ-д төсвийн зарлагын эзлэх хувь хэмжээ буурсан байна.

**Хөгжлийн Хоёрдугаар үе шат (2013-2021 он)**

**Тэргүүлэх зорилт 1.** Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлтийг 20 хувьд хүргэж тогтвортой байлгах нөхцлийг бүрдүүлнэ.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Аймаг, орон нутгийн онцлогт нийцсэн бизнесийн орчинг сайжруулах.
- Үйлдвэрлэл, технологийн паркуудаар дамжуулан дэвшилтэт техник, технологийг тууштай нэвтрүүлэх
- Ашигт малтмалын орд газруудад түшиглэсэн олборлох, боловсруулах үйлдвэрүүдэд бүх талын дэмжлэг үзүүлэх
- МАА, газар тариалангийн түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж экологийн цэвэр бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх
- Аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн нэг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх
- Статистикийн албан ёсны мэдээллийг өрх, иргэн аж ахуйн нэгж бүрээр авч мэдээлэлийн үнэн зөв бодит байдлыг сайжруулах
- Татварын албыг орчин үеийн дэвшилтэт техник технологи бүхий тоног төхөөрөмжөөр хангах, материалаг баазыг бэхжүүлэх

**Хүрэх үр дүн:** Аймгийн ДНБ-ний бодит өсөлт тогтворжиж, мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурь бий болно.

**Тэргүүлэх зорилт 2.** Аймгийн аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлтийг улам нэмэгдүүлж, эдийн засгийн салбарын бүтцийг боловсронгуй болгоно.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг гүнзгийрүүлж олборлох, боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлалын салбарт тулгуурлан аймаг бие даан хөгжих нөхцлийг бүрдүүлэх
- Нүүрс, хөнгөн хүнсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх
- Хүн амын хүнс, өргөн хэрэглээний бараа, түүхий эдийн бөөний худалдааны сүлжээг өргөтгөн хөгжүүлэх
- Даатгалын үйлчилгээний хамрах хүрээг өргөтгөж, нэр төрлийг олшруулан, ялангуяа байгаль, цаг уурын эрсдэл ихтэй мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг даатгалд бүрэн хамруулах
- Барилгын материалын үйлдвэрлэлээр төвийн бүсийн хэрэгцээг бүрэн хангадаг болох

**Хүрэх үр дүн:** Аймгийн эдийн засгийн бүтцэд аж үйлдвэр, үйлчилгээний салбар тэргүүлэх байр суурьтай болж, экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрс нэмэгдэнэ.

**1.2.Аж үйлдвэрийн хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн**

**Өнөөгийн байдал:** Аймгийн аж үйлдвэр, дэд бүтцийн салбарын хөгжил нь газрын хэвлийн баялаг, модны нөөц дээр тулгуурласан уул уурхайн ба барилгын материалын үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн түүхий эд дээр суурилсан хүнс, ундааны ба хөнгөн үйлдвэрийн зарим салбараас хамааралтайгаар хөгжиж ирсэн байна. Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, борлуулалт ба ашгийн асуудлаар аймгийн эдийн засгийн хүчин чадал, бие даасан чадавхийг XXI зууны хөгжлийн стратегийг боловсруулахад нэгдүгээрт уул уурхайн үйлдвэр, хоёрт хүнсний үйлдвэр, гуравт барилгын материалын үйлдвэр гэж төрөлжүүлэн авч үзэж хэтийн хөгжлийг нь тодорхойлох шаардлагатай боллоо.

Сэлэнгэ аймгийн хөгжлийн 2021 он хүртлэх стратегийн хөтөлбөрийг боловсруулахдаа уул уурхайн үйлдвэрт нэлээд анхараал тавьж үзлээ.

2006 онд 53268.2 сая төгрөгийн үйлдвэрлэлт хийж 48718.7 сая төгрөгний борлуулалт хийсний дотор уул уурхай 38.5 %-ийг, хүнс ундааны үйлдвэрлэл 38.5%-ийг, барилгын материалын үйлдвэрлэл 17.4 %-ийг, бусад салбар нь 5.5%-ийг эзэлж байна. 2000 оноос энэ оныг хүртэл өсөлт, бууралттай байсан боловч ерөнхий динамик нь ижил байдлаар явж иржээ. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2006 онд 53268.2 сая төгрөг, үүнээс алт 20523.6, жижиг дунд үйлдвэр 263.2 сая төгрөг тус тус байлаа. Борлуулалт 48718.7 сая төгрөг байгаа байдал нь аймгийн аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн төвшинг цаашид бие даах боломжийг илэрхийлж чадаж байна.

Тус аймгийн нутаг дэвсгэрийн ашигт малтмалын нөөц нь тогтоогдсон хэсэгт барагцаалсан нөөцийг тооцсон судалгаагаар алтны шороон ордны 10 тонн, үндсэн ордны 90 тонн, төмрийн хүдрийн 433.7 сая тонн, нүүрсний 160 сая тонн, цементийн түүхий эд шохойн 250 сая тоннын нөөцтэй гэж үздэг.

Ойрын жилүүдэд ашигт малтмал олборлох, малын гаралтай түүхий эдийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, төмс, хүнсний ногоо, сүү, цагаан идээ боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн өндөр өсөлтийг хангах асар том цогцолборыг бий болгох шаардлагатай байна.

**1.2.1.Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн салбарын тэргүүлэх зорилт, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн**

**Хөгжлийн Нэгдүгээр үе шат (2007-2012 он)**

**Тэргүүлэх зорилт 1:** Төмөртэй, Баянгол, Гачуурт, Улаан-Овоогийн эрдэс баялагийн стратегийн орд газруудыг ашиглалтанд оруулах асуудлыг аймаг, бүс, сумын

бүх төвшинд дэмжих бодлогыг идэвхжүүлж эдийн засгийн салбарын бүтцийг сайжруулж санхүүгийн чадавхи, хуримтлалыг бүрдүүлнэ.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Алт олборлох бичил уурхайг нэн тодорхой бодлого, зохицуулалт, хөдөлмөр хамгааллын хяналтан дор байгуулж ажиллуулах замаар хөдөөгийн ядуурлыг арилгах
- Уул уурхайн газар ашиглалтын байдал, үйлдвэрлэл, олборлолт, борлуулалтын төвшин, аймаг орон нутагт үзүүлж байгаа үр ашгийг тодорхойлох ажлыг холбогдох яамд, агентлагтай хамтран зохион байгуулах.
- Эрдэс баялагийн олборлолтоос орж буй орлогыг төр, засаг төвлөрүүлэх нэрээр орон нутгийн иргэдэд хүргэхгүй байгаа эрх зүйн асуудалд зохицуулалт хийх саналыг УИХ дахь гишүүдийнхээ хамт боловсруулах асуудлаар зөвшилцөл хийх.
- Газрын хэвлийн эрдэс баялагийг олборлосны татвар, хураамжийг аймаг, орон нутагт ашигтай болгох хууль эрх зүйн санал боловсруулан УИХ ба Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх.
- Эдийн засгийн өсөлтөд тэргүүлэх ач холбогдолтой эрдэс түүхий эдийн ашиглалтыг Сэлэнгэ аймгийн Хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дотоодын хуримтлалыг бий болгох зорилгоор өсгөх.
- Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын ажил, уурхайн олборлох технологид орон нутгийн газар ашиглалтын бодлогод тохируулсан нэгдсэн журам стандартыг мөрдүүлнэ.
- Ашигт малтмалын орд газрыг ашиглахдаа бүс нутаг, сумдын хүн амын амжиргааны түвшинг дээшлүүлж, ажилгүйдлыг бууруулахад түлхүү анхаарах. / хавсралт зураг №1/
- Гурилын жижиг үйлдвэрийг бүс, сумаар тодорхой бодлого, төлөвлөгөөтэйгээр байгуулах, гурил, гурилан бүтээгдэхүүний жижиг, дунд үйлдвэрлэлийг үр тарианы том компаниудыг түшиглүүлэн байгуулах замаар хувь хүмүүсийн үйлдвэрлэлийг дэмжиж зохион байгуулалтанд оруулах.
- Жимс-жимсгэнийн ундааны цехүүдийг суурин газруудад өрхийн үйлдвэрлэлийн зохион байгуулалтанд оруулах
- Бугантын модны үйлдвэрийн суурь дээр мод үржүүлэг эрхэлсэн өрхийн аж ахуй байгуулж тарьц, суулгац ургуулах ойг нөхөн сэргээх ажилд оролцуулах.

**Хүрэх үр дүн:** Аймгийн эдийн засагт уул уурхайн салбарын оруулах хувь нэмэр өсөн нэмэгдэнэ. Хүнд үйлдвэрийн салбарын хөгжлийн үндэс суурь тавигдана. Уул уурхайн ашиглалтад өртөгдсөн талбайн нөхөн сэргээлт сайжирна.

**Тэргүүлэх зорилт 2.** Уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг ханган, байгаль орчныг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах бодлого баримтлана.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Эрдсийн баялагийн түүхий эдийн боловсруулалтын түвшинг дээшлүүлж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөжүүлэх.
- Тодорхой илэрцтэй, ирээдүйтэй газар нутагт 1:100000, 1:50000 масштабтай геологийн судалгаа, эрдэс баялгийн эрэл хайгуулын ажлыг хийхэд дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах .
- Эдэлбэр газрын экологи-эдийн засгийн үнэлгээг хөрсний үржил шим, бүтэцтэй нь уялдуулан хийж, экологийн хохирлын төлбөр, нөхөн төлбөр, хураамжийг газрын ренгийн ялгавраар тооцох, хариуцуулах, төлүүлэх орон нутгийн онцлогийг тусгасан механизмыг бий болгоно.
- Гар аргаар ашигт малтмал олборлож буй иргэдийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, олборлосон бүтээгдэхүүнийг нь статистик мэдээнд оруулах ажлыг зохион байгуулна.
- Хаягдал багатай, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж байгаа аж ахуйн нэгжийг урамшуулах хөшүүргийг бий болгон мөрдөнө.

**Хүрэх үр дүн:** Уул уурхайн олборлолт явагдсан газрын экологийн тэнцвэрт байдал хадгалагдаж бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалтын хэмжээ, тогтвортой

үйлдвэрлэл үйлчилгээний төвшингийн биет бүтээгдэхүүн ба мөнгөн дүнгийн орлого, ашиг, татвар төлөлтийн байдал сайжирна.

#### **Хөгжлийн Хоёрдугаар үе шат (2013-2021 он)**

**Тэргүүлэх зорилт:** Уул уурхай, ашигт малтмалын салбарт дэвшилтэт техник, технологийг эрчимтэй нэвтрүүлж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг нэмэгдүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Эрдэс түүхий эдийн нөөцийг иж бүрэн ашиглах хаягдалгүй, байгаль орчинд халгүй технологийг бүрэн нэвтрүүлэх
- Эрдэс түүхий эдийн олборлолтын хэмжээг зохистой түвшинд байлгаж, боловсруулалтын түвшинг ахиулж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг эрс нэмэгдүүлэх
- Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн бааз суурийг дагасан жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх

**Хүрэх үр дүн:** Уул уурхайн олборлох үйлдвэрлэлийн салбар хөгжлийн өндөр түвшинд хүрнэ.

#### **1.2.2.Боловсруулах аж үйлдвэрийн салбарын хөгжлийн тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн:**

#### **Хөгжлийн Нэгдүгээр үе шат (2007-2012 он)**

**Тэргүүлэх зорилт 1.**Боловсруулах аж үйлдвэрийг бий болгож өндөр технологийг нэвтрүүлэн дотоодын зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэнэ.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Орчин үеийн техник технологийг нэвтрүүлж зах зээлийн эрэлтэд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг боловсруулах аж үйлдвэрийн шинэ салбаруудыг хөгжүүлэх
- Оёмол, нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх
- Эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хүрээнд мэргэжилтэй ажилчин бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлэх
- Бүтээгдэхүүний чанарыг олон улсын стандартад нийцүүлэн тасралтгүй сайжруулах

**Хүрэх үр дүн:** Боловсруулах үйлдвэрлэл бий болж бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн өрсөлдөөн бий болно.

**Тэргүүлэх зорилт 2.** Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрлэлийг мал аж ахуйн бүсчлэлийн тэргүүлэх чиглэлийн дагуу хөгжүүлж, зах зээлд өрсөлдөх чадварыг нь дээшлүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрлэлийг эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд чиглүүлж хөгжүүлэх
- Үйлдвэрлэлийн техник, технологийг сайжруулах, бүтээгдэхүүний загварыг шинэчлэх замаар зах зээлд өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх
- Гадаад зах зээлд ноос, ноолууран бүтээгдэхүүнээ борлуулах талаар төрөөс баримталж буй бодлогыг хэрэгжүүлэх
- Түүхий эд бэлтгэлийг стандартын шаардлагад нийцүүлэн сайжруулах

**Хүрэх үр дүн:** Боловсруулах аж үйлдвэрт өндөр технологи нэвтэрч, үйлдвэрлэл өсч, бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар дээшлэнэ. Ажлын байр нэмэгдэнэ.

#### **Хөгжлийн Хоёрдугаар үе шат (2013-2021 он)**

**Тэргүүлэх зорилт:** Боловсруулах аж үйлдвэрийн салбарт оюуны багтаамжтай, өндөр технологид суурилсан үйлдвэрлэлийн эзлэх байр суурийг бэхжүүлж өсгөнө.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Мал, ургамлын гаралтай түүхий эдийг биотехнологийн аргаар боловсруулах

- Хүн, малын өвчин эмгэгийг оношлох чадавхи бий болгож, сэргийлэх эм, бэлдмэлийг орон нутагтаа үйлдвэрлэж бусад аймаг сумдад нийлүүлэх
- Экспортын баримжаатай, оюуны багтаамжтай, өрсөлдөх чадвартай, бага оворын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх
- Мал аж ахуй, газар тариалангийн түүхий эдийг өндөр технологи хэрэглэн бүрэн боловсруулж, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн дотоодын зах зээлд өрсөлдөх
- Байгаль орчинд сөрөг нөлөөгүй, шинэ дэвшилтэт техник, технологи бүхий “Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр”, “Арьс шир боловсруулах үйлдвэр”, “Мод боловсруулах үйлдвэр”-ийг байгуулж ажиллуулна.

**Хүрэх үр дүн:** Чанартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөж мал аж ахуйн гаралтай түүхий эдийг бүрэн боловсруулдаг болж боловсруулах үйлдвэрийн хөгжил дээд шатандаа хүрнэ.

### **1.3.Хөдөө аж ахуйн хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн**

Сэлэнгэ аймаг ба Орхон-Сэлэнгийн сав нутгийн хүрээнд хамрагдаж байгаа Төв аймгийн хойт хэсгийн ойт хээрийн бүслүүрийн 8 сум, Булган аймгийн 3 сумын нутаг нь Орхон аймгийн хамт хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн гол бүс нутаг юм. Энэ бүс нутагт хөдөө аж ахуйн салбар Монгол улсын бусад аль ч бүс нутагтай зүйрлэх аргагүй өргөн цар хүрээтэй хөгжсөн юм. Орхон-Сэлэнгийн сав нутагт Монгол улсын аж үйлдвэр хөгжсөн том хотууд Сүхбаатар, Дархан, Эрдэнэт, Зүүнхараа ба Улаанбаатар оршдог. Бүхэлд нь авч үзэхэд хөдөө аж ахуй ба аж үйлдвэр, дэд бүтэц, ихээхэн өргөн хүрээтэй нягт уялдсан аж ахуйчлалын олон хэв шинжийг багтаасан ландшафт-экологийн том цөм нутаг. Энэ утгаар бүс нутгийг нэгдмэл ойлголт ба хандлагаар авч үзэхээс өөр аргагүй байна. Бүс нутгийн хөдөө аж ахуйг дотор нь хоёр том салбар болгон авч үзэх нь түүний хөгжлийн стратегийг томъёолоход зохистой гэж үзлээ.

Хөгжлийн стратегийн хөтөлбөрийн асуудалд хандахдаа:

1. Газар тариалан, ургамлын аж ахуй ба механикжуулалт.
2. Мал аж ахуйг гахай, шувууны аж ахуйн салбартай нь хамт авч үзлээ.

#### **1.3.1.Газар тариалан ба ургамлын аж ахуй**

**Өнөөгийн байдал:** Сэлэнгэ аймаг нь 1931 онд “Тариалангийн” тодотголтой аймаг болон байгуулагдаж ургамлын аж ахуй ба мал аж ахуйг эрхэлсэн газар тариалангийн өлгий бүс нутаг болж хөгжсөн түүхтэй.

1959 оноос 1990 оныг хүртэл Монголд атар газар эзэмшиж 30 жилийн турш газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлсэн хугацаанд газар тариалан ба ургамлын аж ахуйн хөгжлийг тариалсан талбайн улсын ерөнхий хэмжээний дотор Сэлэнгэ аймаг онцгой байр суурь эзэлж байсан.

Атар газар эзэмшсэний хоёр дахь жилд Сэлэнгэ аймаг улсын тариалсан талбайн 35.5 хувийг, 1990 онд тариалсан талбайн 23.7 хувийг эзэлж байсан бол 2005 оны байдлаар улсын хэмжээний тариалсан нийт талбайн 56.1 хувийг Сэлэнгэ аймаг дангаараа эзэлж байна.

Сэлэнгэ аймгийн 2021 он хүртэлх хөгжлийн хөтөлбөрт тариалангийн салбарт онцгой анхаарал тавьж төрийн өмч ба хувийн өмчийн зохист хослол, хоршилтоор газар тариаланг хөгжүүлэх асуудлыг стратеги хөтөлбөрийн гол бодлого болгох нь зүйтэй гэж үзлээ.

Тариалангийн аж ахуйг шаардлагатай арга хэмжээний тэргүүн зэргийн улсын бодлого болгох нь манай аймгийн энэ салбарт баримтлах гол бодлого байна.


Ургамлын аж ахуйн хувьд хөтөлбөрийн дотор тариалангийн үйлдвэрлэл ба тэжээл үйлдвэрлэлийн чиглэлээр эрс өөрчлөлтийг хийж бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээг авах хэрэгтэй.

Аймгийн хэмжээний эргэлтийн 316619 га талбайг одоогийн байдлаар 1295 субъект эзэмшиж, тэдгээрийн мэдэлд 253726 га талбай ашиглагдаж байна. Дундажаар газар эзэмшигч 1 субъектэд 196 га ноогдож байна.

Эдгээр эзэмшигч нар 2003 онд эзэмшлийн талбайныхаа 36.2 хувьд тариалалт хийж, 32.8 хувийг уриншилжээ. Энэ дарааллаар 2004 онд 32.9 хувь ба 27.4 хувь, 2005

онд 32.2 хувь ба 28.4 хувь байгаагаас үзэхэд газар эзэмшигчдийн хувьд талбайнхаа 63.5 хувийг ашиглаж байна.

Аймгийн хөдөө аж ахуйн газар ашиглалтын эрчимжилт ба үр дүн.



Газар эзэмшигчдийн бүрэлдэхүүний харьцааг харахад нийт эргэлтийн талбайн 64.2 хувь нь 385 аж ахуйн нэгж байгууллагын мэдэлд, 16.0 хувь нь 901 иргэдийн мэдэлд байна. Үүнээс үзэхэд давуу эрхээр гэдэг нэрээр тариалангийн талбайг асар олон контур дугаарын хүрээтэй нэгжийн эзэмшилд олгосон байна.

Энэ байдал нь тариалангийн нэгдсэн системийг боловсруулж түүнийг мөрдөн ажиллана гэхэд **нэгд**: Баримтлах бодлогыг хэрэгжүүлэх боломжгүй болгож байна, **хоёрт**: технологийн горимыг алдагдуулж үүнээс үүдэж 1 га-ийн ургац буурч, хураах нийт ургац багасах явдлыг нөхцөлдүүлжээ. **гуравт**: хүчин чадал ихтэй трактор, комбайн, үрлэгч ба бусад дүүжин техникийг ашиглах зардлыг олонхи субъект дааж чадахгүй, **дөрөвт**: эрчим хүчний ба хөдөлмөрийн зардлыг өсгөх нөхцлийг бүрдүүлэх зэрэг олон тооны сөрөг үр дагаврыг бий болгов. Үүнээс үүдэж Сэлэнгэ аймгийн хэмжээгээр авч үзэхэд үр тариа тариалсан талбай 1990 оны үзүүлэлтээс 2.1 дахин багасч 2005 оны дүнгээр эргэлтийн талбай нийлбэрээрээ 80.9 мянган га болтлоо буурчээ. Хэдийгээр энэ нь нийгэм, улс төрийн тогтолцоо, эдийн засаг хөрөнгө мөнгөний бодлого зохицуулалтын байдал зэрэг олон хүчин нөхцөлтэй хамаатай боловч газар эзэмшигчдийн үйл ажиллагаатай ихээхэн холбоотой байна.

#### Хөгжлийн Нэгдүгээр үе шат (2007-2012 он)

**Тэргүүлэх зорилт**: Экологийн дасан зохицсон ургамлын аж ахуйг хөгжүүлэх, тариалангийн өвсөн талбайт таримлын сэлгээт системийг өргөнөөр нэвтрүүлэх, ургамлын аж ахуйн олон салбарт бүтээмжит бичил биетний технологи буюу ЭМ технологийг нэвтрүүлэх үйл өргөн ашиглах замаар үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн үйлдвэрлэлийг 1990 оны төвшинд хүргэнэ.

#### Хэрэгжүүлэх стратеги:

- Газар тариалангийн үйлдвэрлэлд газар ашиглалт, технологи шинэчлэлийн бодлого зохицуулалтын арга хэмжээг зохион байгуулах.
- Усалгаатай тариалангийн үйлдвэрлэлийг эрс нэмэгдүүлэх бодлого баримтлах.

- Дэлхийн зах зээлийн эрэлтэд нийцэх шинэ таримлын тариалалт, гадаад зах зээлийн бодлогыг боловсруулах, экспортын борлуулалтад орох алхам хийж, сагаг \гурвалжин будаа\ тариалах аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулах
- Газар ашиглалтын үр өгөөжийг сайжруулах, ашиглах үйл ажиллагааг зохицуулах төр-төрийн бус байгууллагын төлөөлөлтэй “аймаг, бүсийн газар эзэмшигчдийн холбоог” байгуулахыг дэмжих.
- Сэлэнгэ аймгийг газар тариалан ба ургамлын аж ахуйг тогтвортой эрхлэх Монгол улсын Стратегийн төв бүс нутаг болгох талаар санал боловсруулах
- Стратегийн ач холбогдолтой таримлууд болох улаан буудай, царгас, ерхөг, арвай, төмсний үрийн аж ахуйн асуудлыг хүнсний аюулгүй байдлын стратеги болгож онцгойлон үзэж зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
- Аймгийн бүс тус бүрт Сэлэнгийн улаан буудайн элит үрийн аж ахуй эрхлэх компанийг хувийн ба төрийн өмчийн оролцоотой байгуулах
- Улаан буудайн дээд үеийн үржүүлгийн үр үйлдвэрлэлээр төрөлжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх сонголт хийх.
- Царгасны үрийн аж ахуйн үйлдвэрлэлийн бригадыг Ерөө, Хүдэр суманд байгуулах.
- Саман ерхөгний үрийн аж ахуйн бригадыг Сайхан, Мандал, Хушаат суманд байгуулах.
- Төмсний элит ба сортын үрийн үйлдвэрлэлийг асуудлыг бүрэн шийдвэрлэх
- Аймгийн хэмжээнд үйлдвэрлэл явуулаагүй 2-оос дээш жил болсон газрыг эзэмших субъектын эрхийг цуцлах, тендерээр шинэ эзэмшигчид олгох
- Газар эзэмшигч нэгж аж ахуй, хувь хүн иргэдээр газар ашиглалт ба тариалангийн үйлдвэрлэлийн талбайн түүхийн дэвтрийг бий болгож хөтлүүлэх
- Хөрсний үржил шимийг хадгалах, хамгаалах ба сайжруулах гэрээг хийж аймаг, бүс, сумын газрын албатай паспортжуулалтад оруулах замаар төрийн хяналтыг тогтворжуулах

**Хүрэх үр дүн:** Газар тариалангийн үйлдвэрлэл тогтвортой өсч, хүн амын хүнсний бүтээгдэхүүний хангамж сайжирна. Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн чадавхи нэмэгдэнэ.

#### **Хөгжлийн Хоёрдугаар үе шат (2013-2021 он)**

**Тэргүүлэх зорилт:** Тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулж салбарын эдийн засгийн таатай орчинг бий болгоно.

#### **Хэрэгжүүлэх стратеги**

- Тариалангийн үйлдвэрлэлд технологийн шинэчлэлийг үргэлжлүүлэх
- Тариалах талбайн эргэлтэнд талбайг таримлын олон төрөл бүхий системийг нэвтрүүлэх өргөтгөх:
- Усалгаатай тариалангийн талбайг 12000 га-д хүргэж , баталгаатай ургац авах нөхцлийг бүрдүүлэх. / хавсралт зураг №2/
- Бухаар тариалангийн үр тарианы таримлын га-ийн ургацыг 12-13 цн, үүнээс улаан буудайн га-гийн ургацыг 10.0 цн-ээс доошгүй тогтвортой төвшинд байлгах технологи, техник хангамжийн баазыг бий болгох.
- Зусах ба өвөлжих хөх тариа, арвай тариалах сэлгээг ЭТС-ийн нийт талбайн тавны нэг хувьд тогтвортой барих бодлогыг хэрэгжүүлэх.
- Өмнөх шатанд тариалж эхэлсэн шинэ таримал болох сагагыг (гурвалжин будааг) экспортын зориулалтаар тариалах талбайг өргөтгөх.
- Тэжээлийн олон наст ургамлын үрийн аж ахуйн хувийн хэвшлийн 2-3 фермерийн аж ахуйг газар эзэмшигч үйлдвэрлэгчийн сонирхол, экологийн зохист нутагт байгуулах.



- Хүлэмжийн аж ахуйг эрхэлж эрт ургацын ногооны төрлийг олшруулах, хангамжийг нэмэгдүүлэх, техник, тоног төхөөрөмжийг урт хугацааны бага хүүтэй санхүүгийн түрээсээр нийлүүлэх нөхцлийг бүрдүүлэх
- Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн томоохон фермерүүдийг бий болгоход дэмжлэг үзүүлэх.
- Стратегийн ба үйлдвэрлэлийн ач холбогдолтой хэрэгжүүлэх эдийн засаг, байгаль орчны экологийн асуудлын мастер ба цогц төлөвлөгөөг боловсруулах

**Хүрэх үр дүн:** Газар тариалангийн үйлдвэрлэл тогтвортой өсч хүн амын хүнсний хангамж сайжирна.

### **1.3.2.Хөдөө аж ахуй механикжуулалт**

**Өнөөгийн байдал:** 2007 оны байдлаар Сэлэнгэ аймгийн хэмжээнд бүх маркын трактор 1006 байгаагийн дотор гинжит трактор 384, дугуйт трактор 474 байна. Дугуйт тракторын бүрэлдэхүүнд Кубота ба Нью холланд маркын трактор 112 байгаа нь аймгийн машин-тракторын паркийн чирэх хөдөлгөөнт техникийн 11.0 хувийг шинэчлэсэн байна.

Үр тарианы комбайн 506, технологийн тусгай зориулалтын ачааны автомашин 48 байна. Газар тариалангийн технологийн үйл ажиллагаанд ашиглагдах дүүжин техник хэрэгсэл нийтдээ 2513, анжис 517, өргөн холбогч 294, үр тарианы үрлэгч 358, төмс суулгагч 48, хүнсний үр суулагч 21 байна. Харин төмс, хүнсний ногоо сийрүүлүүр 411, төмс хураагч техник 97 байна. Усалгааны бороожуулагч фрегат ДМ-454, ДДН-70 услагч 492, бага оворын услах агрегат 69 ш байна.

Хадланг бэлтгэх 6 төрлийн үндсэн техник бүгд 832 байна.

Үтрэмийн 7 төрлийн техник хэрэгсэл /будаа цэвэрлэгч, ачигч, үр сортлогч, механикжсан үртэм, жинлэх пүү зэрэг/-37, засварын газрын 9 төрлийн багаж төхөөрөмж бүгд 199 байна.

Одоогийн ашиглагдаж байгаа техникийн хангамж нь газар тариалан, ургамлын аж ахуйн үйл ажиллагааг эрхлэхэд бусад аймгаас илүү хангамжтай боловч үр тарианы 500 аж ахуйн нэгж ба хувиараа газар авсан 900 газар эзэмшигчид нэгэн зэрэг тариалалт ба хураалт хийх техникийн хангамж дутагдалтай байна. Засвар үйлчилгээний ажлыг жинхэнэ утгаар эрхэлсэн, жигд ажиллагаатай засварын газар цөөхөн байна. Харин мэргэжлийн механикжуулагч харьцангуй олон байна. Тухайлбал механикжуулагч ажилчид 1877 хүн байхад ХАА-н инженер 46, ХАА-н механикжуулагч 70 хүн байна.

Зарим машин техник хүрэлцээтэй байхад хөрс элдэншүүлэлтийн дүүжин агрегатын бүрдэл дутах байдал норматив үзүүлэлтээр илэрч байгаа доголдол илэрч байна. Машин-тракторын паркийн хангамж аймгийн бүсүүд ба бүсийн доторхи сумуудын хооронд ялгаа байгаагаас газар эзэмшигч нар өөрсдийн эзэмшилд авсан газраа бүрэн боловсруулж чадахгүйгээс тариалангийн газар ашиглалтгүй ихээр орхигдож байна.

**Тэргүүлэх зорилт:** Хөдөө аж ахуйн машин-техникийн хүчин чадлыг газар тариалан, ургамлын аж ахуйг хөгжүүлэх стратегийн цогц төлөвлөгөө ба хөтөлбөрт нийцүүлэн хангах арга хэмжээг, хөрөнгө оруулалт, санхүүгийн түрээс, зээлийн хөшүүргийг ашиглан шийдвэрлэх, газар эзэмшигч ААНБ болон иргэдийн хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөрс элдэншүүлэх технологийн горимыг мөрдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Газар эзэмшигч ААНБ ба иргэд нэг бүрийн газар тариалангийн ажил эрхлэх техник хэрэгслийн бүртгэл, үзлэгийг тариалалт ба ургац хураалтын үеийн бодит байдлаар хангамжийн үнэлэлт өгөх, дүгнэлт гаргах
- Аймгийн бүс тус бүрийн төвд машин-трактор, дүүжин агрегатын засвар үйлчилгээний паркыг байгуулах
- Бүс тус бүрийн газар тариалангийн ЭТС-ийн тарималын төрөлжилтөөс хамааран техникийн иж бүрдэлтэй техник-технологийн үйлчилгээний дундын өмчтэй компанийг газар эзэмшигчдийн хувьцаа хөрөнгийн хоршилтоор байгуулах,

- Тракторч, комбайнч ба засвар үйлчилгээний мэргэжилтэй техникийн дунд боловсролтой ажилчдыг бэлтгэх сургалтын анги, танхимыг Шаамар, Сант сумдын МСҮТ-ийн бааз суурь дээр өргөтгөн нээх
- Газар тариалан, тэжээл үйлдвэрлэлийн машин техникийн нөөцийг алдагдуулахгүй байх үүднээс хуучин бүх маркийн трактор, агрегатын бие хэсгийг ОХУ руу гаргаж худалдахыг бүрэн зогсоох арга хэмжээг авах
- Хөдөө аж ахуйн техникийн корпорацийн зураг төслөөр бүсийн хэмжээний техникийн хангамжийг сайжруулахад туслах зориулалтын 30 тракторын засвар-үйлчилгээний паркыг байгуулах асуудлыг бүсийн төлөөллийн оролцоотой хэлэлцэж үзэх ажлыг хариуцан гүйцэтгүүлэх.

**Хүрэх үр дүн:** ХАА-н машин техникийн хангамж, ашиглалт нэмэгдэж, техник-технологийн нэвтрүүлэлт сайжирч нэгжээс авах ургацын хэмжээ нэмэгдэнэ.

### **1.3.3. Мал аж ахуйн салбарын хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн**

**Өнөөгийн байдал:** Сэлэнгэ аймаг малын тоогоороо Монгол улсад хамгийн цөөн малтай, хамгийн их талбайд тариа, ногоо тариалдаг аймаг байлаа. Нутаг ус нь газар тариалан, ургамлын аж ахуй эрхлэх нэн тохиромжтой учраас мал аж ахуйг хязгаарлагдмал тооны дотор ардууд нь барьж голдуу өндөр ашиг шимтэй малыг цөөн толгойгоор маллаж иржээ.

1971 онд манай аймаг 352.1 мян толгой малтай байсны дотор цэвэр үүлдрийн үхэр 1.4 мянга, цэвэр үүлдрийн хонь 28.9 мянган толгой, эрлийз үхэр 5.1, эрлийз хонь 84.5 мянган толгой байснаараа Монголдоо ашиг шим ихтэй үүлдэрлэг мал аж ахуй эрхэлж, улсдаа тэргүүлж байв. Мал сүргийн зэрэгцээ суурин тосгон олонтой байсны хувьд 4104 гахай, үүнээс 544 мэгж, 8.4 мянган тахиа шувуутай, үүний 5.1 мянган өндөглөгч байжээ. 1990 онд цэвэр үүлдрийн үхрийн тоо 21.0 мянга, цэвэр үүлдрийн хонь 96.2-109.3 мянган толгойд хүрч байсан үзүүлэлт 2005 оны эцсээр ихэд хорогдож цэвэр үүлдрийн ба эрлийз үхэр, хонины тоо толгой нийлсэн дүнгээр 116.0 мянган толгой байна.

Ашиг шим ихтэй цэвэр үүлдрийн малын тоо толгой зах зээлийн эдийн засгийн тогтолцооны 15-18 жилд сүргийн бүтцийн талаасаа ихээхэн өөрчлөлтөнд орж нүүдэллэн ирэгсэдийн мал олноор нэмэгдсэнтэй холбогдож 2005 оны жилийн эцсийн тооллогоор 627.5 мянган толгой болж 1.8 дахин нэмэгдээд байна. Хот суурин олонтой дэд бүтэц, уул уурхайн үйлдвэр, газар тариалан өргөн хөгжсөн бага нутагтай манай аймагт бэлчээрийн даац хэд дахин хэтрээд, ашиг шим ихтэй үүлдрийн ба эрлийз мал сүрэг нь асар их хорогдсон ийм үед энэхүү асуудал хөндөгдөж байна. Орхон, Хангай, Ерөө, Баяд үүлдрийн нарийвтар ба нарийн ноост хонины аж ахуй эрчимтэй хөгжиж, зорилго бодлоготой үржил селекцийн ажил хийгдсэнээр 110.0 мянган толгой сайн үүлдрийн мал сүрэгтэй болж Дархан хот дахь нэхий эдлэлийн үйлдвэрийн түүхий эдийг хангаж чадах хэмжээнд хүрсэн байлаа. 1990 оноос өмнө манай аймагт ямааны тоо толгой хязгаарлагдмал байснаа үүнээс хойш ихээхэн өсч 300.0 гаруй мянган толгой болсон нь байгалийн бэлчээрт сөрөг нөлөө үзүүлж эхлээд байна. Энэ байдал даамжирч гүнзгийрвэл Сэлэнгэ аймгийн гол мөрний савыг дагасан ба хуурай хөндийн бэлчээр талхагдлын дээд зэрэгт хүртэл доройтож урьдын 5-6 цн ургацтай байсан бэлчээрээ эргүүлэн сэргээхэд хүндрэл бэрхшээлтэй болох магадлал ихтэй байна. Аймгийн мал сүргийн бүтцийн харьцаа уламжлал ба шинжлэх ухаан талаас харахад алдагджээ.

2007 оны эхний байдлаар аймгийн хэмжээнд 13231 ам бүл бүхий 3110 малчин өрхийн 7023 малчин 774.4 мянган малыг маллан амьдарч байна. Малын тоо толгойг төрлөөр нь авч үзвэл тэмээ 0.1, адуу 5.1 үхэр 11.0, хонь 43.9, ямаа 39.9 хувийг тус тус эзлэж байна

Мах, сүүний чиглэлийн өндөр ашиг шимт Казахын цагаан толгойт, Сэлэнгэ, Халимаг, Симменталь үүлдрийн үхэр Орхон, Хангай, Ерөө, Баяд үүлдрийн хонь зэрэг өндөр ашиг шимт мал өсгөн үржүүлж байгаа нь нийт үхрийн 47.7, хонины 29.6 хувийг өндөр ашиг шимт цэвэр үүлдрийн болон эрлийз мал эзэлж байна.

Оны эхний нэг малаас 1715 грамм ноос, 246 грамм ноолуур, 453 литр сүү ашиглаж, 100 эхээс 35 ботго, 74 унага, 87 тугал, 93 хурга, 98 ишиг бойжуулж байна.

Мал аж ахуйн салбар нь аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 26.5 хувийг үйлдвэрлэж байна.

Сүүлийн жилүүдэд малчид малдаа хөрөнгө оруулалт хийх сонирхол дээшилж, мах, сүүний үхэр, мах-ноосны хонь, гахай шувуу, зөгийн аж ахуйн чиглэлээр суурин, хагас суурин фермерийн аж ахуйн эрхлэгчдийн тоо 63 болж өслөө.

Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах үүднээс өнгөрсөн жилүүдэд улсын төсөв, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар болон иргэд аж ахуйн нэгжийн хөрөнгөөр 100 орчим худгийг сэргээн засварлаж, 50 гаруй худаг шинээр гаргаж, 350 гаруй мянган га бэлчээр усжуулж, бэлчээр усжуулалтын түвшин 57.4 хувьд хүрлээ. / хавсралт зураг №3/

1990-ээд оны сүүлчээс сүргийн бүтцэд ихээхэн өөрчлөлт орж гадны аймгаас мал бүхий иргэд олон тоогоор нүүдэллэн ирсэн, өндөр ашиг шимт мал зах зээлийн шуурганд өртөж тоо толгой нь цөөрч ашиг шим нь буурч ирсэн нь зах зээлийн тогтолцооны үеийн сөрөг үр дагаварын нэг байлаа.

### **Хөгжлийн Нэгдүгээр үе шат (2007-2012 он)**

**Тэргүүлэх зорилт 1:** Мал аж ахуйг эрчимжүүлэх замаар малын тоо толгойг тогтвортой хэмжээнд барьж ашиг шим өндөртэй сайн үүлдрийн болон нутгийн шилмэл малыг тэжээл үйлдвэрлэлтэй хослуулан түлхүү хөгжүүлж, суурин ба хагас суурин хэлбэрээр мал аж ахуйг төрөлжүүлэн тэжээлийн үйлдвэрлэлтэй нь хамтатган хөгжүүлэх. Бэлчээрийн ургац, тэжээлийн нөөцийн хэмжээнд тохирсон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх орчинг бий болгох

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Баруун аймгуудаас нүүдэллэн ирж буй мал аж ахуйтай айл, иргэдийн нүүдэл, суурьшлыг зохицуулах бодлогын арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх:
- Үхэр, хонины аж ахуйн цэвэр үүлдрийн цөм сүрэг ба эрлийз малын 2-3-р үеийн сүргийг өсгөх, маллах, ашиг шимийг нэмэгдүүлэхэд ашиглах бодлогоор бүс ба зарим суманд цөм сүргийн үржлийн фермерийн аж ахуйн нэгжийг төр ба хувийн хоршсон хөрөнгөөр байгуулах.
- **Мал аж ахуйн салбарт сайн үүлдрийн ба эрлийз мал сүргийн тоог нийт малэзлэх хувийн жинг 70 хувь хүртэл нэмэгдүүлж ямаан сүргийн тоо толгойг хязгаарлах эрх зүйн орчинг бий болгох.**
- Аймгийн ба бүс тус бүрийн мал сүргийн эргэлтийн төлөвлөгөөний саналын төслийг үе шатаар шинэчлэн боловсруулж мал аж ахуйн хөгжлийн стратегийн цогц хөтөлбөрийн боловсруулах. / хавсралт зураг №4/
- Эрчимжсэн суурин ба хагас суурин аж ахуйн малын үүлдэрлэг чанар ба ашиг шимийг дээшүүлэх бодлого, зохицуулалтын арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх зохион байгуулалт, менежментийн үйл ажиллагааг тодорхойлох
- **Үхрийн аж ахуйн салбарт** эрчимжсэн суурин аж ахуйг хөгжүүлэх чиглэлийг баримтлан мах-сүүний ба махны үхрийг өсгөх ажлыг өмчийн бүх хэлбэрээр эрхлэх бодлого чиглэлийг аймаг, бүсийн төвшинд тодорхойлох,  
Үүний тулд: а/ **Ерөөгийн** бүсэд мах, мах- сүүний үхрийн аж ахуй, Ерөө үүлдрийн нарийвтар ноост хонины аж ахуйг, махны үхрийн фермерүүдийн төвлөрөлтэй аж ахуйг Жавхлант суманд эрхлэх:  
б/ **Хараагийн** бүсэд сүү- мах, мах- сүүний үүлдрийн аж ахуйг хот, том суурин тосгоныг түшиглэн хөгжүүлэх,  
в/ **Сэлэнгийн** бүсэд мах-сүүний чиглэлийг  
г/ **Орхоны** бүсэд махны үхрийн аж ахуйг хөгжүүлэх.
- Үхрийн аж ахуйн үүлдрийн сонголт ба төрөлжилтөд семминталь, семминтальжсан сибирийн үүлдэр, Казахын цагаан толгойт, Сэлэнгэ, Халимаг, Талын улаан, Хар тарлан үүлдэр болон нутгийн шилмэл омгыг сонгон үржүүлэх.
- Махны үхрийн аж ахуйд бордооны эрчимжсэн технологи нэвтрүүлж, 18 сартайд нь 270 кг амьдын жинд хүргэж маханд борлуулах.

- Сүү-махны ба сүүний үнээнээс саамын 300 хоногт саах сүүний хэмжээг 2500 литрт хүргэж, энэ төвшинг тогтвортой байлган арчилгаа, маллагаа, тэжээлийн бааз бий болгож, хөдөлмөр зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэхэд анхаарах.
- **Хонины аж ахуйн салбарт** нарийн ба нарийвтар ноост хонины аж ахуйг бэлчээрийн хосолмол ашиг шимт нутгийн шилмэл омгийн малтай хослон эрхлэх ерөнхий чиглэл баримтлана.
- Үүлдрийн сонголтод Орхон, Ерөө, Хангай, Баяд үүлдэр ба нутгийн ширүүвтэр ноост шилмэл омгын хонийг анхааран үзэх бодлогыг барьж, төрөлжүүлэн өсгөх фермерийн аж ахуйн хөгжлийг дэмжинэ.
- Ноосны гарцыг нарийвтар ноост хонинд дундажаар 5.0 кг-аас доошгүй, нарийвтар ноост хонинд хонинд 3.5-4.5 кг, ширүүвтэр ноост нутгийн шилмэл ба эрлийзжсэн хонинд 2.0-2.0 кг-д хүргэх,
- Хонины махан ашиг шимийг бүх үүлдрийн дундажаар 25-30 кг гулууз мах авах хэмжээнд хүргэх,
- Арьсыг дээлийн нэхий, үслэг эдлэлийн нэхий бэлтгэх стандартад нийцүүлэн бэлтгэх нөхцлийг бүрдүүлэх
- Хонины ноос, арьс нэхийн үйлдвэрлэлийг эрхлэх аж ахуйн нэгж байгууллага, хувиараа үйлдвэрлэгч ба фермерүүдийн бүтээгдэхүүн нийлүүлэлтийн үнийг нэмэгдүүлэх, орлогын татварыг бууруулах, зээлийг хөнгөлөлтэй хүүтэйгээр урт хугацаатай олгох бодлого баримталж, банк – санхүүгийн дэмжлэг үзүүлэх:
- Бэлчээрийн улирлын суурин маллагаатай мал аж ахуйн чиглэл барьсан аж ахуйн нэгж байгууллага, иргэд малчдын аж ахуйчлалын бүсийг газар тариаланг эрчимжүүлэн эрхлэх нутаг дэвсгэрээс тусгаарлан байршуулах газар ашиглалтын менежментийн бодлогыг боловсруулах, нутаг бэлчээр эзэмшүүлэх газар зохион байгуулалт хийх
- Цөм сүрэг ба үржлийн хээлтүүлэгчийг өсгөх, бойжуулах, зохиомол хээлтүүлэгт гүн хөлдөөсөн үрийг ашиглах үйлчилгээг эрхлэх зэрэг ажлыг шилдэг туршлагатай малчидын өрхийн аж ахуйн чадварлаг фермерүүдэд төрөлжүүлэн эрхлэх материаллаг нөхцлийг бүрдүүлэх, банк, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг эрх зүйн орчин, эдийн засгийн болон санхүүгийн талаар төрийн ба хувийн өмчийн хосломол хэв шинжит аж ахуйн хэлбэрийг бий болгох
- Эрчимжсэн суурин мал аж ахуйг эрхлэх, тэжээлийн баазыг бий болгох зорилгоор тариалангийн газар эзэмшүүлэх, таримал тэжээл ба бүдүүн тэжээл өвс бэлтгэхэд техник хэрэгсэл авахад лизингийн зээл олгох.
- Өрх, хот айлын ба фермерийн бэлтгэх тэжээлийн хэмжээг малын дунджилсан норматив үзүүлэлтийг бүс, сум, өрх-хот-айл, фермерийн хэмжээнд үйлдвэрлэл эрхлэхээр газар эзэмшүүлэх
- Малчин өрхийн аж ахуй, хот айл ба фермерийн эзэд бэлчээр, хадлангийн эдлэн газрынхаа хөрсний үржил шимийг хадгалж бэлтгэх өвс тэжээлийн ургацыг нэмэгдүүлэхэд экологийн цэвэр бууцан бордоог ашиглах ажлыг хэвшүүлэх технологийг нэвтрүүлэх, байнгын ажил үйлчилгээ болгох зорилгоор Буриад улсын туршлагыг өргөн ашиглах
- Мал аж ахуйн хөгжлийн стратегийн цогц хөтөлбөрийг малын сүргийн бүтэцийн тооцоонд өөрчлөлт хийх, шинэчилсэн хувилбарын тооцоог бүс, сум тус бүрээр бүсчилэн боловсруулах.

**Гахай, шувууны аж ахуйн салбарт:** Аймгийн бүсүүдийн 2001-2006 оны үйлдвэрлэлийн 6 жилийн дундажийг 2012 он гэхэд 40% -өөс доошгүй хувиар, 2020 он гэхэд 2 дахин нэиэгдүүлэх бодлого барина.

Гахай, шувуу, зөгий, туулай үржүүлэх чиглэлээр өрхийн болон фермерийн аж ахуйг эрхлэх бүхий л санал санаачлагыг бүх талаар хөхүүлэн дэмжинэ.

**Хүрэх үр дүн:** Эрчимжсэн суурин маллагаатай шинэ хэлбэрийн хувийн хэвшлийн мал аж ахуйн суурь тавигдаж мах, сүүний үйлдвэрлэл сайжирна.

**Мал эмнэлэгийн өнөөгийн байдал:** Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөр, Засаг даргын 2004-2008 оны үйл ажиллаганы хөтөлбөрт тусгагдсан зорилтын хүрээнд Мал эмнэлэг нь аймгийн хэмжээний 774.4 мянган толгой малд халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах МЭАЦ-ийн магадлан шинжилгээ, ариутгал халдваргүйжүүлэлтийг хэрэгжүүлж ажиллаж байна.

Манай аймагт боом, үхэр хонь, гахайн цусан халдварт, дуут хавдар, адууны халдварт цус багадах, бруцеллёз, сүрьеэ, ям, шүлхий, адууны томуу, галзуу, гахайн мялзан, ёлом зэрэг өвчнүүд гарч байсан болон голомтууд байсаар байна.

Сүүлийн 10 жилд сүрьеэ, ям, гахайн мялзан, ёлом лейкоз өвчнүүд огт гараагүй, адууны халдварт цус багадах өвчний халдварлалт 0.1хувь хүртэл, бруцеллёз өвчин 0.2 хувь хүртэл буурсан дүгнэлт байгаа хэдий ч малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах хууль жигд хэрэгжихгүй, махны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж экспортлоход саад болсоор байна.

**Тэргүүлэх зорилт 2:** Мал, амьтныг эрүүлжүүлэх ажлыг сайжруулж, гоц халдварт өвчинтэй тэмцэх арга механизмыг боловсронгуй болгоно.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, нян судлал, ийлдэс судлал, ариун цэврийн магадлан шинжилгээний ажлыг боловсронгуй болгож, мал эмнэлгийн лабораторыг олон улсын магадлан итгэмжлэлд хамруулах.
- Улсын хилийн боомтуудад мал эмнэлгийн хорио цээрийн найдвартай хамгаалалт бий болгож, мал амьтны халдварт өвчин, ялангуяа гоц халдварт өвчин улсын хилээр нэвтрэхээс сэргийлэх, нэвтрэн орж ирсэн нөхцөлд тэдгээртэй тэмцэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг бүх шатанд сайжруулж, мал эмнэлгийн багаж хэрэгсэл, эм бэлдмэлийн хангамжийг сайжруулна.
- Мал эмнэлэг үржлийн нэгжүүдийн тоог нэмэгдүүлэх замаар өрсөлдөөнийг бий болгож, чанар хүртээмжийг сайжруулах арга хэмжээ авах.
- Мал эмнэлэг үржлийн нэгжүүдийн материаллаг бааз, эмийн нөөц хангамжийг сайжруулах, боловсон хүчнийг чадавхижуулах.
- Аймгийн мал эмнэлгийн шинжилгээний лабораторийн материаллаг бааз тоног төхөөрөмжийн хангамж, хүрэлцээ, оношлогооны чадавхийг дээшлүүлэх.
- Орон нутгийн чанартай гардаг өвчнийг оношлох, эмчлэх шинжилгээ судалгааны ажлын арга зүйг боловсруулж хэрэгжүүлэх.
- Эрүүл үржлийн шилмэл хээлтэгч, хээлтүүлэгч мал бойжуулж бэлтгэн нийлүүлэх
- Шилмэл малын бүртгэл мэдээллийн санг баяжуулж, үзэсгэлэн худалдааг бүс, аймаг, сумын түвшинд зохион байгуулах.
- Өндөр ашиг шимт сайн чанарын үрээр зохиомол хээлтүүлгийн ажлыг явуулж, нутгийн байгаль цаг уурт дасан зохицсон цөм сүргийг бий болгох.

**Хүрэх үр дүн:** Мал сүрэг эрүүлжиж, гоц халдварт өвчний гаралт, түүний сөрөг нөлөөлөл буурна. 2012 гэхэд үхэр шувууны сүрьеэ, адууны ям өвчнөөр, 2015 он гэхэд адууны халдварт цус багадах, лейкоз өвчнөөр тайван аймаг болно. 2020 он гэхэд халдварт өвчний голомтгүй болно.

#### **Хөгжлийн Хоёрдугаар үе шат (2012-2021 он):**

**Тэргүүлэх зорилт:** Аймгийн МАА-н салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж эрчимжсэн МАА-г хөгжүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Малчдын үйлдвэрлэл, борлуулалт, фермерийн үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих
- Мал аж ахуйн үйлдвэрлэлийн мэдээллийн оновчтой тогтолцоог бий болгох
- Бэлчээр ашиглалтын менежментийг улам боловсронгуй болгох
- Төв суурин газрын дэргэд мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх эрчимжсэн фермерийн болон хагас суурин аж ахуйг олноор байгуулж ажиллуулах
- Махны чиглэлийн үүлдэр, омог, гойд ашиг шимтэй нутгийн шилмэл малыг биотехнологийн аргаар үржүүлэхэд онцгойлон анхаарч, мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх хувилбарыг судлан хэрэгжүүлэх

- Малын тэжээл үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг борлуулах оновчтой тогтолцоог бүрдүүлэх
- Ган, зудаас хамгаалах тэжээлийн нөөцийг бий болгож, улмаар өвс тэжээл экспортлох нөхцлийг умард хилийн дагуу бүрдүүлэх
- Байгалийн гэнэтийн аюулаас сэргийлэх, хохирлыг бууруулах зорилгоор малыг даатгалд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах
- Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг эцсийн бүтээгдэхүүн болгох үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх
- Махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр хэрэгцээнийхээ 80 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүний 70 хувь, гурил гурилан бүтээгдэхүүний 60 хувийг хангах
- Хүнс хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд мэдлэг олгох, мэдээлэл түгээх, дамжуулах, шинэ технологи эзэмшүүлэх, зуучлах үүрэг бүхий хөдөө аж ахуйн нэвтрүүлэх үйлчилгээг төрийн байгууллагын эрх зүйн орчинд байгуулах
- Сумын мал эмнэлгүүдийн лабораторийн материаллаг бааз, багаж тоног төхөөрөмжийн хангамж, оношлогооны чадавхийг сайжруулах

**Хүрэх үр дүн:** Хот суурин газрын орчим эрчимжсэн фермерийн аж ахуйн тогтолцоо бий болж, малчдын амьдрал ахуй, хөдөлмөр зохион байгуулалтанд чанарын дэвшил гарна. Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өснө.

#### **1.4.Жижиг, дунд үйлдвэр, өрхийн аж ахуйн хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн**

##### **1.4.1.Жижиг дунд үйлдвэрийн хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн**

**Өнөөгийн байдал:** 2006 оны байдлаар Жижиг дунд үйлдвэрүүд аймгийн хэмжээнд гурил гурилан бүтээгдэхүүний 40, ундаа зайрмагны 20, мод модон эдлэлийн 12, барилгын материалын 8, худалдаа, нийтийн хоолны 508 нэгж, цех ажиллаж нийт дүнгээр 263.9 сая төгрөгний бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 264.5 сая төгрөгний борлуулалт хийж байна.

Аймгийн хэмжээнд Жижиг дунд үйлдвэр, өрхийн аж ахуй хөгжүүлэх замаар ажилгүйдэл ядуурлыг бууруулах бодлого баримтлан жил бүр аймаг, сумын “ Бренд “ бүтээгдэхүүнийг тодруулан сурталчилах үзэсгэлэн худалдааг тогтмол зохион байгуулж хэвшин, улсын хэмжээнд зохион байгуулагддаг арга хэмжээнүүдэд тогтмол идэвхитэй оролцон, тэдний үйл ажиллагааг болон зах зээлийг нь өсгөх, түншийн холбоо тогтоох, бүтээгдэхүүнээ сурталчилахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

##### **Хөгжлийн Нэгдүгээр үе шат (2007-2012 он)**

**Тэргүүлэх зорилт 1.** Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжиж хөгжлийг түргэсгэх өргөжүүлэх таатай орчинг бүрдүүлж шинэ шатанд гаргана.

##### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг боловсруулах.
- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх талаар орон нутгийн онцлогыг тусгасан санал боловсруулж Засгийн газарт өргөн барих
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх банк ба банкны бус санхүүгийн уян хатан бодлогыг хэрэгжүүлэх
- Экспортын баримжаатай жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжих
- Орон нутгийн түүхий эд дээр жижиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж хэрэгжүүлэх

**Тэргүүлэх зорилт 2.** Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд төрөөс үзүүлэх дэмжлэгийг түргэн шуурхай болгоно..

##### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг шаардлагатай мэдээллээр хангах ажлыг тогтмолжуулах
- Төвийн бүсийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн бизнес төвүүдийг байгуулж ажиллуулах
- Улсын болон орон нутгийн төсвийн захиалгаар бараа, үйлчилгээ худалдан авахад жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг оролцуулах

- Иргэдийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд тогтоосон заавал мөрдөх стандартаас бусад стандарт, тусгай зөвшөөрөл, журмыг зөвлөмжийн шинж чанартай болгох арга хэмжээ авах
- Жижиг дунд үйлвэрлэл хөгжих бааз суурийг өрхийн аж ахуй эрхлэх замаар бий болгох

**Хүрэх үр дүн:** Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн таатай орчин бүрдэж, албан секторт хамрагдах жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо болон ажлын байрны тоо нэмэгдэж, татварын бааз суурь өргөжнө.

#### **Хөгжлийн Хоёрдугаар үе шат (2013-2021 он)**

**Тэргүүлэх зорилт:** Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг хурдасгаж сөрөг нөлөөллийг бууруулж хялбаршуулна.

##### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор холбогдох хууль, тогтоомжинд нэмэлт, өөрчлөлт оруулах санал санаачилгыг гаргах
- Жижиг, дунд үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийг шинэчилэн тодорхойлж хэрэгжүүлэх
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн техникийн болон мэргэжлийн ур чадварыг сайжруулах
- Төрөөс олгогдож буй тусгай зөвшөөрлийг нэг цэгийн үйлчилгээнд шилжүүлж давхардалыг арилгах
- Том үйлдвэрүүдийн хэрэглээний жижиг хангамжийн үйлдвэрлэлийг гэрээгээр гүйцэтгэх
- Тээвэр, санхүүгийн зуучийн гэх мэт салбар дундын үйлчилгээг хөгжүүлэх
- Бизнесийн үйлчилгээ (нябо бүртгэл, үл хөдлөх хөрөнгийн менежмент, г.м. бусад)-г өргөтгөн хөгжүүлэх

**Хүрэх үр дүн:** Өндөр түвшинд хүрсэн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ олноор бий болно. Ажлын байр нэмэгдэнэ. Үйлчилгээний эдийн засагт эзлэх байр суурь өргөжнө.

#### **1.4.2. Өрхийн аж ахуйн хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн.**

**Өнөөгийн байдал:** Тус аймагт ажилгүйдэл, ядуурлаас гарах арга зам нь Өрхийн аж ахуй эрхлэх, түүнийг хөгжүүлэх мөн гэж үзэж тус аймаг нь өрхийн аж ахуйг хөгжүүлэх замаар ажилгүйдлийг бууруулах, ядуурлаас гарах бодлого чиглэлээ тодорхойлон хоёр дахь жилийнхээ нүүрийг үзэж байна. Энэ хугацаанд Жижиг дунд үйлдвэр, өрхийн аж ахуйг эрхлэх боломж зөвлөлгөөнийг хийж гарсан боломжоо сум бүрт хэрэгжүүлэхээр үүрэг даалгавар өгөн биелэлтийг Аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн ажилласны үр дүнд өнөөдрийн байдлаар нийт өрхийн 68.2 хувь нь ямар нэг хэмжээгээр өрхийн аж ахуй эрхлэж байна.

Голлох салбараар нь авч үзвэл мал аж ахуйн салбарт 22.2 хувь, газар тариалангийн салбарт 32.8 хувь, үйлдвэрлэл үйлчилгээний салбарт 21.5 хувь нь тус тус ноогдож байна. Мөн энэ хүрээнд мэргэжлийн чиг баримжаа, ур чадвар олгох болон аж ахуй эрхлэх сургалтанд 20874 хүнийг хамруулсан байна.

”Нэг суурин –Нэг бүтээгдэхүүн “ хөдөлгөөн өрнүүлж, шилдэг бүтээгдэхүүн шалгаруулах үйл ажиллагааг тогтмолжуулан, аймгийн хэмжээний өрх, хүн амын талаар мэдээллийн цахим санг бүрдүүлж, амьжиргааны түвшин, өрх, өрхийн гишүүдийн бүртгэлийг бий болгон өрхийн хэмжээнд үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний талаархи статистик мэдээлэлтэй боллоо.

Цаашид өрхийн аж ахуйг улам хөгжүүлэх, өргөжүүлэх шаардлага гарч байгаа бөгөөд энэхүү хөтөлбөрийн үр дүнд тус аймаг өрх бүр нь өрхийн үйлдвэрлэгч болох юм.

#### **Хөгжлийн Нэгдүгээр үе шат (2007-2012 он)**

**Тэргүүлэх зорилт 1.**Өрхийн аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэх таатай орчинг бий болгож, ажилгүйдлийг бууруулж иргэдийн амьжиргааны чадавхийг дээшлүүлнэ.

##### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Өрхийн аж ахуйг эрхлэхэд төрийн зүгээс бүх талын дэмжлэг үзүүлэх

- Жижиг зээлийн үйлчилгээ буюу бичил санхүү, зээлийн зуулчлалын үйлчилгээг өрхийн үйлдвэрлэл руу чиглүүлэх бодлого хэрэгжүүлэх
- Газар тариалан, мал аж ахуй эрхлэгчийг эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бага оврын орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах, энэ чиглэлийн лизингийн үйлчилгээний орон нутгийн салбарыг бий болгох
- Өрхийн үйлдвэрлэлд тулгуурлан сумдад албан бус тарималын үр үйлдвэрлэгчдийг бий болгож хэрэгцээг хангах бодлого хэрэгжүүлэх
- Тариалангийн газартай иргэдэд бодлогоор технологи нэвтрүүлэх, техник, тоног төхөөрөмжийн үйлчилгээ бүхий төлбөртэй үйлчилгээний нэгжүүдийг байгуулах
- Барилгын модон материалыг орлох тоосго, блокны жижиг оврын үйлдвэрийн тоног төхөөрөмжөөр хангах
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааг зохион байгуулж, эрэлтэд тулгуурласан төрөл бүрийн сургалтын арга хэлбэрийг сонгож, бүсийн сургалтын төвүүдийг бий болгож үйл ажиллагааг нь тогтмолжуулах
- Ой бүхий сумдын иргэдийг тарьц, суулгац ургуулах, ургуулсан тарьцаа худалдах, ойжуулалтын ажлын төсөлд хамрагдах санаачилгад дэмжлэг үзүүлж, амьжиргааны төвшинг дээшлүүлэх, байгаль орчноо хамгаалах төлөвлөлийг бий болгох
- Байгалийн дагалт баялаг ашиглах /самар, жимс/ тэдгээрийг боловсруулалтанд оруулж лаазлах, савлах бага оврын тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулах
- Айл хотлоороо амьдран суугаа газар нутгийнхаа ойн санг тодорхой хугацаатай хамтын эзэмшилээр эзэмшүүлж зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах
- Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулан нэг цэгийн үйлчилгээг бий болгож айл өрхүүдэд газрыг нь эзэмшүүлэх, өмчлүүлэх асуудлыг нэг мөр шийдвэрлэх
- Гар аргаар алт олборлогч иргэдийн нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэх таатай нөхцлийг бүрдүүлэх
- Хуучин ашиглагдаж байсан суваг шуудууг сэргээн, иргэдэд газрыг нь эзэмшүүлж эрхийг нь баталгаажуулах
- “Сэлэнгэ-жимс, жимсгэнэ” аймгийн хөтөлбөрийн хүрээнд иргэд, аж ахуйн нэгж, улсын төсөв, гадаадын зээлийн хөрөнгөөр бүс нутгийн онцлогт тохирсон, сортын тарьц, суулгац, жимс, жимсгэнэ үржүүлэх, эх цэцэрлэг үржүүлгийн газар байгуулахыг дэмжих
- Иргэдэд төсөл хөтөлбөр, зээл тусламжинд хамруулах зорилгоор бизнес төлөвлөгөө боловсруулах сургалтыг нэгдсэн графикайн дагуу сум болгонд зохион байгуулах
- Хөдөө аж ахуйн сургалт нэвтрүүлэлтийн /экстейншний/ үйлчилгээг өргөжүүлж, бүс нутгийн төвүүдэд салбар байгуулан, үйлчилгээний нөхцөл боломжоор хангах, мэргэшсэн ажилтнуудыг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх

**Хүрэх үр дүн:** Өрхийн аж ахуйг эрхлэх замаар жил бүр 150-аас доошгүй өрхийг орлогын эх үүсвэртэй болгоно.

**Тэргүүлэх зорилт 2:** Өрхийн аж ахуй эрхлэхэд банк санхүү, төрийн байгууллагуудаас учирч буй саад тотгорыг арилгана.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Урт хугацаатай бага хүүтэй зээлийн бүтээгдэхүүнийг бий болгох талаар бодлого зохицуулалтын арга хэмжээ авах
- Төмс хүнсний ногооны зээлийг тарилтын улирал эхлэхээс өмнө олгодог механизмийг бий болгох
- Газар олголтыг чирэгдэлгүй хурдан шуурхай болгох, нэг цэгийн үйлчилгээг сум бүрт хуваарийн дагуу ажиллуулах
- Бага оврын техник, тоног төхөөрөмжийг урт хугацаагаар лизингээр олгох



- Гар аргаар алт олборлогч иргэдийн нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэх таатай нөхцлийг бүрдүүлэх
- Төрийн байгууллагаас олгогдож буй бичиг баримтыг хялбаршуулах журам гаргах  
**Хүрэх үр дүн** :Өрхийн аж ахуй эрхлэх, амьдралаа өөд нь татах хүсэл сонирхолтой иргэн бүрийн өмнө адил тэгш боломж нээгдэнэ.

### **Хөгжлийн Хоёрдугаар үе шат (2013-2021 он)**

**Тэргүүлэх зорилт 1.** Өрхийн аж ахуй эрхлэгч нь өөрийгөө тэтгэх чадвараа нэмэгдүүлж, зах зээлийн бие даасан харилцаанд оролцон үйлдвэрлэлээ өргөжүүлэн аж ахуйн нэгж, пүүс, компанийн зохион байгуулалтанд орох нөхцөл бололцоог бүрдүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Тогтвортой үйл ажиллагаатай өрхийн аж ахуйнуудад банк, санхүүгийн байгууллагуудтай харилцахад төрийн зүгээс дэмжлэг үзүүлэн, иргэдийн үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийг нь баталгаажуулах үйлчилгээг хурдан шуурхай болгох
- Туулай, загас, зөгийн аж ахуйг эрчимтэй хөгжүүлж, үржлийн болон төлөөр хангах загвар аж ахуйнуудыг бий болгоход дэмжлэг үзүүлэх
- Сүү, төмс, хүнсний ногоо, мах боловсруулах, шахмал түлш, мал бордох, зорины аж ахуй эрхлэх, жимс, жимсгэнэ тариалах, модны тарьц суулгац ургуулах, ноос боловсруулах, модон эдлэл, оёдлын үйлдвэрлэл эрхлэх аж ахуйг хөгжүүлэх
- Гар аргаар алт олборлогч иргэдийн нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэх таатай нөхцлийг бүрдүүлэх

**Хүрэх үр дүн:** Өрхийн аж ахуйг эрхлэгчдийн тоо, үйлдвэрлэх бүтээгдэхүүний тоо, чанарын бүтцэд өөрчлөлт орж ажилгүйдэлгүй болсон байна. Хүн амын амьжиргааны түвшин дээшилнэ. Чинээлэг фермерийн эзэд бий болсон байна.

**Тэргүүлэх зорилт 2:**Өрхийн аж ахуй эрхлэгчид болон банк санхүү, төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулна.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Банкны салбаруудыг сумдад олноор байгуулан тэдэнтэй өрсөлдөхүйц дотоодын банк бус санхүүгийн байгууллагыг бэхжүүлэх
- Аймгийн өрхийн аж ахуйд бүтээгдсэн хүнсний бүтээгдэхүүнийг нийслэл, бусад аймгуудад борлуулах боломж бүрдүүлэх
- Гар аргаар алт олборлогч иргэдийн ажлын байрыг баталгаажуулах
- Өрхийн аж ахуй эрхлэгчид хорших, хамтрах замаар жижиг дунд үйлдвэр байгуулах, цаашлаад аж ахуйн нэгжийн зохион байгуулалтанд орж, үйлдвэрлэлээ өргөжүүлэх нөхцөл бүрдүүлэх

**Хүрэх үр дүн:** Өрхийн аж ахуй эрхлэгчид аймаг орны эдийн засагт тодорхойлогч байр суурь эзэлж, ажилгүйдлийг бууруулах бодит хүчин болсон байна.

### **1.5.Аялал жуулчлалын хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн**

**Өнөөгийн байдал:** “Сэлэнгэ аймаг аялал жуулчлалыг хөгжүүлэх” Аймгийн нээлтэй байдлын хөтөлбөр”-ийг боловсруулж 2 үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд амралтын болон аялал жуулчлалын 14 аж ахуйн нэгж, 400-гаад жуулчид хүлээн авах чадал бүхий 41 зочид буудал үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд 2006 онд Зүүнхараагийн СББХК, Хөтөлийн цемент шохой комбинатын сувиллын газруудад 42.0 сая төгрөгийн, хуучны “ Хонд “ амралтын газрыг “ Бишрэлт - трейд “ ХХК 100.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж үйл ажиллагааг нь сэргээн өргөтгөл тохижилтын ажил хийгдэж, Баруунбүрэн суманд “Сэлэнгэ өргөө “ жуулчны бааз, Мандал суманд “ Ноён тур “ жуулчны бааз, Алтанбулаг суманд “ Алтан од “ жуулчны бааз, Сүхбаатар суманд “ Хан оргил “ амралтын газрууд тус тус шинээр нээгдэн үйл ажиллагаа эрхэлж байна.

Аймгийн хэмжээний аялал жуулчлалын нөөцийн судалгаа хийж байгалийн үзэсгэлэнт болон түүхийн дурсгалт газруудын судалгааг 17 сум тус бүрээр гарган

нэгтгэж байгалийн үзэсгэлэнт газар 43, түүх соёлын дурсгалт газар 84, эмчилгээ, сувилгааны рашаан, эмийн ховор ургамалтай газар 11 байгааг тус тус тогтоогоод байна.

Байгалийн үзэсгэлэнт болон, түүхийн дурсгалт газраар аялан спорт агнуур, Сэлэнгэ мөрөн болон Орхон голоор дамжин Сүхбаатар орчмын Орхон- Сэлэнгийн бэлчир орох усан замын аялалыг зохион байгуулах, төмөр замын аялал хийх бүрэн боломжтой юм. 2006 онд дотоодын 20000 гаруй, гадаадын 5000 орчим жуулчид манай аймгийн байгалийн үзэсгэлэнт газруудаар аялан жуулчлал хийснээс үзэхэд жилээс жилд амрагч жуулчдын тоо өсөн нэмэгдэж байна.

Унаган төрхөөрөө буй байгалийн үзэсгэлэнт газрууд, агнуурын нөөцтэй ан амьтад, олон ястан, үндэстний түүх, соёл, ахуй амьдралын өвөрмөц хэв маяг, ёс заншлын харилцан шүтэлцээг судлах, сурталчлах чиглэлээр хөгжүүлсэн гол нөөц дээрээ түшиглэж аялал жуулчлалын салбарыг аймгийнхаа бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцүүлэн олон чиглэлээр эрчимтэй хөгжүүлэх өргөн боломжийг бүрэн ашиглах зорилгоор дараахь бодлого зорилтыг дэвшүүлж байна.

### **Хөгжлийн Нэгдүгээр үе шат (2007-2012 он)**

**Тэргүүлэх зорилт 1.** Жуулчдын тээвэрлэлтийн болон жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлж, түүх соёлын дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газруудыг улсын болон бүс нутгийн аялал жуулчлалын нэгдсэн сүлжээнд хамруулна. / хавсралт зураг №5/  
**Хэрэгжүүлэх стратеги:**

- Аялал жуулчлалын голлох шинэ чиглэлүүдийг нээх.
- Аялал жуулчлалын гол бүс нутгуудын харилцаа холбоо, эрчим хүчний хангамжийг сайжруулах ажлыг бусад салбарын хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлэх.
- Зэрэглэл өндөртэй зочид буудал, жуулчны бааз байгуулах зэрэг аялал жуулчлалын салбарт оруулах хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих.
- Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар, Зүүнбүрэн, Цагаан-нуур, Баруунбүрэн сумдыг түүх, соёлын, Ерөө, Хүдэр, Жавхлант, Түшиг сумдыг ан агнуур, Сант, Орхон, Хушаат, Сайхан сумдыг байгалын үзэсгэлэнт газрын,- Мандал, Баянгол, Орхонтуул сумдыг өвлийн спортын аялал жуулчлалын чиглэлээр тус тус төрөлжүүлэн хөгжүүлэх
- Аймгийн нэгдсэн музейг “Түүх-соёлын аялал жуулчлалын цогцолбор” хэлбэрээр 2008 оноос өөрчлөн зохион байгуулж, монголчуудын олон үеийнхний түүхийн дурсгалт газруудыг шинжлэх ухааны түвшинд судалж баталгаажуулан жил бүр 8-10 мянган хүнд үйлчлэх, бүсийн төвийн сумдад нэг ээлжинд 100-аас доошгүй жуулчин хүлээн авах хүчин чадалтай өндөр зэрэглэлийн зочид буудал, олон үндэстний өвөрмөц зоогийн газар байгуулж, монголын үндэсний соёл урлаг, хөдөлгөөний аюулгүй байдал, зорчигчдын хэрэгцээ шаардлага, ая тухыг бүх талаар хангасан тээвэр, холбоо, эмнэлэг, худалдаагаар саадгүй үйлчлэх зэрэг цогцолбор арга хэмжээ авах.
- Улсын аялал жуулчлалын нэгдсэн сүлжээнд 5 - 6 жуулчны баазыг хамруулах

**Хүрэх үр дүн.** Аялал жуулчлалын салбар түргэн хурдацтай хөгжих үндэс тавигдаж , эдийн засагт тус салбарын эзлэх байр суурь нэмэгдэн, хөтөлбөрийн I үеийн эцэст жилд дундажаар гадаадын 5-7 мянга, дотоодын 10 - 20 мянган жуулчид хүлээн авч, 80-100 мянган доллараар орон нутгийн жил бүрийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх бөгөөд, хөтөлбөрийн II үеийн эцэст энэ үзүүлэлт 2 дахин нэмэгдэж, Сэлэнгэ аймгийг дэлхийн хэмжээнд сурталчлах замаар аялал жуулчлалын олон улсын төв болтол хөгжүүлэх баттай суурь тавигдана.

**Тэргүүлэх зорилт 2.** Бүсийн төвүүдэд аялал жуулчлалын төвүүдийг бий болгон, аялагч, жуулчдын сонирхлыг татсан аяллын төрлүүдийг хөгжүүлнэ.

### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Аялал жуулчлалын улирлын хамаарлыг багасган, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулах
- Өвлийн болон гол мөрний аялал жуулчлалыг хөгжүүлэх

- Орхон Сэлэнгийн бэлчир орчим өвлийн спортын төв, Асмалжин, Ерөөгийн халуун рашааныг түшиглэсэн жилийн турш жуулчин хүлээн авах бололцоотой амралт, сувиллын газруудыг байгуулж ажиллуулах
- Олон улсын аялал жуулчлалын нэгдсэн сүлжээнд 2-3 жуулчны баазыг хамруулах
- Аялал жуулчлалын салбарын бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагуудыг бий болгох

**Хүрэх үр дүн:** Байгаль орчинд хал багатай, жуулчдын сонирхлыг татсан, аяллын шинэ төрлүүд бий болно.

#### **Хөгжлийн Хоёрдугаар үе шат (2013-2021 он)**

**Тэргүүлэх зорилт:** Аялал жуулчлалын салбарын хөгжлийн түвшинг дээшлүүлж, үйлчилгээний чанарыг сайжруулна.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Жуулчны аюулгүй байдлыг хангаж, үйлчилгээний чанарыг сайжруулах
- Аялал жуулчлалын бүх төрлийн үйлчилгээг стандартын дагуу болгож, хяналтыг сайжруулах
- Аялал жуулчлал, олон улсын харилцаа, гадаад хэлний өндөр мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх
- Аялал жуулчлалын салбарын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох
- Аймгийн төвд өндөр зэрэглэлийн зочид буудал, жуулчны баазын цогцолбор байгуулах зэрэг аялал жуулчлалын салбарт оруулах хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих

**Хүрэх үр дүн:** 2021 онд жуулчдын тоо одоогийнхоос 2.2 дахин нэмэгдэн, жуулчдын ая тухтай аялах нөхцөл бүрдэж, аялал жуулчлалын салбар аймгийн эдийн засгийн чухал салбарын нэг болно.

#### **1.6.Худалдаа үйлчилгээ, хэрэглээний хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн**

**Өнөөгийн байдал:** Сэлэнгэ аймгийн хүн амын худалдаа үйлчилгээ, хэрэглээний бүтцэд сүүлийн жилүүдэд эерэг өөрчлөлт гарч байгаа боловч хэрэглээний нэр төрөл харьцангуй цөөн, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага зохих түвшинд хангагдахгүй байна.

Аймгийн төвийн чинээлэг иргэд болон алслагдсан сум, түүнчлэн хөдөөгийн ядуу, нэн ядуу иргэдийн хооронд хэрэглээний нэр төрөл, чанарын ялгаа ихээхэн зөрүүтэй байна. Төв суурин газрын хүн амын хүнсний хэрэглээнд гурил, будаа, саахар, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, өндөг зонхилж байхад хөдөөгийнхний хэрэглээ мах, сүү, гурил, будаанаас төдийлэн хэтэрч чадахгүй байна. Ялангуяа ядуу, нэн ядуу өрхийн хэрэглээний түвшин үлэмж дор байна.

Үйлдвэрлэл, үйлчилгээнд ч техник технологийн хоцрогдлоос үүдсэн үрэлгэн, зохисгүй хэрэглээ зонхилсоор байна. Цэвэр, бохир усны шугам, цэвэрлэх байгууламжтай сумын төв бага байна.

Иймд хүн амын чинээлэг болон ядуу хэсгийн хэрэглээний түвшингийн зөрүүг багасгаж нэр төрөл, чанарт нь ахиц гаргах, үйлдвэрлэлийн хэрэглээг өөрчлөн хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлдэг зохисгүй хэрэглээг халж, ухаалаг, чанартай, хэрэглээг бий болгон төлөвшүүлэх шаардлагатай байна

#### **Хөгжлийн Нэгдүгээр үе шат (2007-2012 он)**

**Тэргүүлэх зорилт 1.** Аймгийн хэмжээнд хүнсний барааны хангамж, хэрэглээний бүтцийг өөрчлөн сайжруулж, хүнсний болон ахуйн шинэ зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Өргөн хэрэглээний барааны бөөний худалдааны сүлжээ түүхий эдийн зах, үйлчилгээний цогцолборуудыг хөгжүүлэх
- "Ногоон хувьсгал", "Цагаан хувьсгал", Хүнсний хангамж, аюулгүй байдал ба хоол тэжээл" үндэсний хөтөлбөрүүдийг аймгийн хэмжээнд эрчимтэй хэрэгжүүлэх
- Аймгийн хүн амын хоол хүнсний физиологийн нормыг нас хүйсний онцлогт нийцүүлэн шинэчлэн тогтоож мөрдөх
- Баяжуулсан болон зориулалтын хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл,

үйлчилгээг нэмэгдүүлэх

- Түүхий эдийн нөөцдөө тулгуурлан экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэх
- Хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний 50 хүртэл хувийг цөцгийн тосны 40 хувийг аймгийн дотоодын үйлдвэрлэлээр хангах
- Сумдын төв, өрхийн аж ахуйд тахиа, шувуу, гахайн аж ахуйг хөгжүүлэн өндөг, тахиа, гахайн махны хангамжийг сайжруулах
- Хүн амын эмзэг хэсэгт хамрагдаж байгаа хүүхэд, жирэмсэн ба хөхүүл эхчүүдийг иоджуулсан давс, бичил бодисоор баяжуулсан гурилаар хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах
- Хүн амыг хүнсний зохистой хэрэглээг бий болгох, хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр төрөлжсөн болон сэдэвчилсэн сургалтууд тогтмол зохион байгуулах
- Хүн амд иоджуулсан давс, эрдэс витаминаар баяжуулсан хүнс хэрэглэж сургах сургалтууд тогтмол зохион байгуулах
- Хүн амын эрүүл мэндэд харш архи, тамхи болон стандартын бус бүтээгдэхүүний хэрэглээг бууруулах зорилгоор энэ талын сургалт сурталчилгааг өргөтгөх

**Хүрэх үр дүн:** 2006 оны түвшинтэй харьцуулахад төмс, хүнсний хангамж **100** хувь. жимс жимсгэний хангамж **50** хувь. загас бүтээгдэхүүний **30** хувь, цөцгийн тосны хангамж **70** хувь ессөн байна

**Тэргүүлэх зорилт 2.** Аймгийн төвийн гэр хорооллын хүн амын усан хангамжийн түвшинг дээшлүүлж, усны зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Аймаг сумын төвд цэвэр бохир усны системийн техник технологийг шинэчлэх зорилгоор аймгийн төвд цэвэр ус дамжуулах шугамыг нэмэгдүүлэх, гэр хорооллын усан хангамжийг сайжруулах
- Эрдэсжилт өндөр болон хатуулаг ихтэй усны чанарт хяналт—шинжилгээ хийх, ус цэвэршүүлэх тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах
- Стандартын шаардлага хангадаггүй ахуйн хэрэглээний усны эх үүсвэртэй төв, суурин газар, цэргийн ангид ус цэвэршүүлэх техник технологи нэвтрүүлэх
- Хөдөө орон нутагт гүний худгийг сэргээн засварлаж, дундын эзэмшлийн гэрээ байгуулах замаар эзэнтэй болгож, хүн амын цэвэр усны хүртээмжийг сайжруулах
- Найрлагын хувьд стандартын шаардлага хангасан цэвэр ус, рашаан савлах жижиг, дунд үйлдвэр байгуулахыг бүх талаар дэмжих
- Дэвшилтэт техник, технологи бүхий жижиг, дунд үйлдвэрүүдийг аймаг, сумын төвд байгуулах замаар үйлдвэрлэлийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх
- Усыг зохистой хэрэглэх, хадгалж хамгаалах талаар мэдээлэл, сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулах

**Хүрэх үр дүн:** Хүн амын усан хангамжийн болон ундны усны эрүүл ахуйн стандартын шаардлага хангах түвшин мэдэгдэхүйц дээшлэнэ.

**Тэргүүлэх зорилт 3.** Байгаль орчинд халгүй, дэвшилтэт технологийг тууштай нэвтрүүлэх замаар үйлдвэрлэлийн зохистой хэрэглээг бий болгох үндэс суурийг тавина.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Дэвшилтэт техник.технологи бүхий жижиг, дунд үйлдвэрүүдийг аймаг сумын төвд байгуулах замаар үйлдвэрлэлийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх
- Ундны усны баталгаат эх үүсвэрийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах
- Үйлдвэрлэлийн хог хаягдлыг хоргүйжүүлэх, халдваргүйжүүлэх хортой хаягдлыг устгах зориулалт бүхий үйлдвэрлэлийг шинээр бий болгон хөгжүүлэх
- Хог хаягдал, бохир ус зайлуулах, устгах, ялган боловсруулах, цэвэршүүлэх төсөл шалгаруулан аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлэх; үйлдвэрлэлийн болон хүн амын хэрэглээний явцад гарсан хог хаягдлыг бууруулах, дахин боловсруулж ашиглах

- Орчныг бохирдуулагч нь илүү төлбөр төлөх зарчмыг тууштай хэрэгжүүлэх  
**Хүрэх үр дүн:** Орчин үеийн технологид суурилсан жижиг, дунд үйлдвэрлэл хөгжин үйлдвэрлэлийн хэрэглээ шинэчлэгдэх үндэс суурь тавигдсан байна.

### **Хөгжлийн Хоёрдугаар үе шат (2013-2021 он)**

**Тэргүүлэх зорилт 1.** Аймгийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлж, хэрэглээний бүтцийг нийгмийн эрүүл мэндийн шаардлагад нийцүүлж боловсруулдаг болгоно.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх замаар аж ахуйн нэгж, өрхийн үйлдвэрлэлийг дэмжиж, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, цөцгийн тосны үйлдвэрлэлийг есгөн, дотоодын зах зээлд загас, загасан бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтмол нэмэгдүүлэх
- Хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг 100 хүртэл хувиар өсгөх арга хэмжээ авах
- Аж ахуйн нэгж өрхийн үйлдвэрлэлийг дэмжин хүнсний шинэ бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах
- Хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний барааны чанар, стандарт, эрүүл ахуйн үзүүлэлтийг өндөр нарийвчлалтай баталгаажуулдаг тогтолцоог бий болгох
- Бага насны хүүхэд, жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, ахмад настны болон тусгай хоол хэрэглэдэг бүлгийн хүмүүсийн хоол тэжээлийг үйлдвэрлэх, хадгалах, түгээх үйлчилгээний сүлжээг бий болгох
- Аймаг, сумын төвүүдэд бичил бодисоор баяжуулсан хоолны зохистой хэрэглээг төлөвшүүлэх, сургалтуудыг зохион байгуулах

**Хүрэх үр дүн:** 2006 оны түвшинтэй харьцуулахад төмс, хүнсний ногооны хангамж 100хувь, жимс, жимсгэний хангамж 75 хувь, загас, загасан бүтээгдэхүүний 50 хувь, цөцгийн тосны хангамж 100 хувь хүртэл өссөн байна..

**Тэргүүлэх зорилт 2.** Төв суурин газрын хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан цэвэр усаар хангах ажлыг сайжруулж, усан хангамжийн түвшинг дээшлүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Аймгийн төв, суурин газрын хүн амын ундны ба ахуйн хэрэглээний усны эх үүсвэрт ариун цэвэр, эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож, тохижуулах ажлыг сайжруулах
- Аймаг сумдын ундны усны зарим шинэ эх үүсвэрийг судлан тогтоож, сумдын ундны усны худгуудад цэнгэгжүүлэх тоног төхөөрөмж суурилуулан, усны чанар, хангамжийг сайжруулах
- Эрүүл ахуйн шаардлага хангасан цэвэр ус савлан хот, хөдөөгийн иргэдийн эрэлт хэрэгцээг хангах ажлыг өргөтгөх
- Усыг ариг гамтай хэрэглэх талаархи мэдээлэл, сурталчилгааг тогтмолжуулах

**Хүрэх үр дүн:** Хүн амыг ариун цэвэр, эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан цэвэр усаар хангах боломж өргөжиж, хүн амын хэрэглээг бүрэн хангах нөхцөл бүрдэнэ.

**Тэргүүлэх зорилт 3.** Байгаль орчинд халгүй, дэвшилтэт технологийг тууштай нэвтрүүлэх замаар үйлдвэрлэлд зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Түлшний мод хэрэглэхийг багасган байгалийн хий болон бусад төрлийн түлш хэрэглэх, барилга, модон эдлэлийн үйлдвэрлэлд өөр төрлийн материал орлуулан ашиглахад чиглэсэн дэвшилтэт технологийг дэмжин урамшуулах
- Баяжуулсан хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, хангамжийг сайжруулах чиглэл бүхий үйлдвэрүүдийг түлхүү дэмжих
- Байгаль орчинд халгүй, дэвшилтэт техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилгоор энэ талын хяналтыг хүчтэй болгох арга хэмжээ авах

**Хүрэх үр дүн:** 2020 онд үйлдвэрлэлийн хэрэглээний бүтэц, чанарт өөрчлөлт гарч, хүн амын эрүүл мэндэд хоргүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөл сайжирсан байна.

## **1.7. Дэд бүтэц**

### **1 7.1. Зам тээврийн хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн**

**Авто замын өнөөгийн байдал:** Сэлэнгэ аймагт улсын болон орон нутгийн чанартай 1101.4 км автозам ашиглагдаж байгаагаас улсын чанартай Алтанбулаг-Улаанбаатар чиглэлд 220 км, Дархан-Эрдэнэт чиглэлд 120 км нийт 340 км нь асфальтонбетон зам ашиглагдаж байна.

Сэлэнгэ, Ерөө, Хараа, Орхон, Шарын гол зэрэг том жижиг гол, гуу жалган дээгүүр тавьсан 100м-с дээш урттай 4 асфальтонбетон гүүр, 100 м-ээс доош урттай 25 жижиг гүүрийг дээрхи авто зам дамжин өнгөрдөг.

Аймгийн нутаг дэвсгэр дэх улс орон нутгийн замын сүлжээнд Сүхбаатар, Мандал, Сайхан сумдын төвийн 6.2 км асфальтонбетон зам, Шаамар, сумын төвийг 2.3 км хөнгөвчилсөн асфальтобетон хучилттай зам, Алтанбулаг-Улаанбаатарын чиглэлийн төв замаас баруун тийш Түшиг сум, зүүн тийш Бугант, Дулаанхаан тосгон, Төмөртэй уурхай хүртэлх 347 км хайрган хучилттай зам багтдаг. Бусад зам нь ердийн хөрсөн зам байдаг.

Дээрх замуудын дайрч өнгөрдөг Сэлэнгэ мөрөн, Орхон, Ерөө, Түнхэл, Хүдэр, Түшиг, Хараа, Ивэн, Шүрэн зэрэг гол түүний салаа зэрэг газруудад барьсан орон нутгийн чанартай 100м дээш урттай 7, 100 м доош урттай 29 гүүр байдаг.

Үүнээс 7 нь төмөр бетон, 1 нь төмөр бусад нь модон гүүрүүд юм. Орон нутгийн чанартай зам, гүүрүүдэд орон нутгийн замын сан, төсвийн хөрөнгөөр барилга, засвар арчлалт хамгаалалтын ажлыг хийдэг. Мөн Орхон, Ерөө голууд дээр 3 бирвааз ажиллаж байна.

Гэвч зам, замын байгууламжийн барилга, засвар арчлалтын ажлын хэмжээ, үнэлгээ өндөр, хөрөнгийн эх үүсвэрийн хомс байдал, материалын үнэ их зэрэг нь байнга засварлаж арчлах боломжийг тэр бүр бүрдүүлж чаддаггүй мөн аймгийн нутаг дэвсгэр дэх олон гол мөрний ус үерлэх үед дээрх зам гүүрүүд нь их хэмжээгээр эвдэрч гэмтдэг.

Сүүлийн жилүүдэд Сүхбаатар сумын хойд тойргийн 2.1 км хатуу хучилттай зам, Мандал сумын төв доторхи замыг шинээр тус тус барьж байгуулж байнгын ашиглалтанд оруулсан мөн Германы KFW банкны зээлээр 2006-2008 он хүртэл хэрэгжүүлэх “Бүс нутгийн тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд 166.7 сая төгрөгийн хөрөнгөөр Ерөө, Цагааннуур, Хушаат, Баянгол-Мандал чиглэлийн 43 км хайрган хучилттай зам, 5 модон гүүр 60 гаруй ус зайлуулах хоолой бариулахаар болсон.

Монгол Улсын авто замын хуулийг үндэслэн аймгийн Засаг даргын захирамжаар аймгийн болон тус аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж иргэдээс орон нутгийн авто зам, замын байгууламжийг ашигласны төлбөр хураамж авах журам төлбөрийн хэмжээг тогтоон мөрдүүлж байна. Аймгийн Засаг даргын захирамжаар 2003 онд батлагдсан “Орон нутгийн замын санг бүрдүүлэх, зарцуулах журам”-ыг хэрэгжүүлж зөвхөн 2006 онд гэхэд орон нутгийн замын санд 126.924.0 мян төгрөгийн орлого оруулж сумдад 108.0 сая төгрөгийн замын засвар, гэрэлтүүлгийн ажлыг санхүүжүүлсэн байна.

Аймгийн авто тээврийн төвлөрсөн байгууллагууд бүрэн хувьчлагдаж одоогийн байдлаар нийтийн тээврийн үйлчилгээг Шуудан холбооны алба, аймгаас тендерт шалгарсан компани хамтран орон нутагт тусгай зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэж байна. Эдгээрт Хөтөл-Дархан, Дархан-Сүхбаатар, Сүхбаатар Шаамар, Сүхбаатар-Зүүнбүрэн, Сүхбаатар-Цагааннуур, Сүхбаатар-Алтанбулаг, Хүдэр-Дархан, Ерөө-Дархан гэсэн чиглэлд нийт 185 автомашинаар үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн Сүхбаатар хотын төвд автобусны 4 чиглэлд микроавтобус, таксийн үйлчилгээ ажиллаж байна.

Ачаа тээвэрлэлтийн асуудлыг одоогийн байдлаар зохион байгуулалтийн тогтсон арга хэлбэргүй иргэд, байгууллага хоорондын тохиролцсон хэлцлээр хувийн хэвшлийн жолооч нар гүйцэтгэж байна.

Авто тээврийн харилцааг зохицуулах төрийн бодлогыг тодорхойлсон авто тээврийн хуулийг батлан мөрдүүлснээр эрх зүйн орчин бүрдсэн ч тус аймаг орон нутагт тээврийн бодлого зохицуулалт өнөөгийн эрэлт шаардлагад тэр бүр нийцэж чадахгүй байна.

Тээврийн хэрэгслийн хяналт шалгалт өнөөгийн шаардлагаас хоцорч байна. Иймд авто тээврийг бодлого чиглэлтэйгээр хөгжүүлэх, авто тээвэр эрхлэх сонирхол бүхий аж ахуйн нэгж, байгууллага иргэдэд тавих шаардлагыг өндөржүүлж Монгол Улсын Авто тээврийн тухай хуулийг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Харин Алтанбулаг Худалдааны чөлөөт бүсийн үйл ажиллагаа эхлэхээр Алтанбулаг, Сүхбаатарын районд онгоцны буудал барих асуудлыг Алтанбулагийн чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөнд тусгагдсан болно.

Мөн хуучин уламжлалыг сэргээж Сэлэнгэ, Орхон гол дээр аялал жуулчлалын зориулалтаар усан зам тээврийг явуулах боломж бий.

### **Хөгжлийн Нэгдүгээр үе шат (2007-2012 он)**

**Тэргүүлэх зорилт 1:** Орон нутгийн замын хөгжлийн бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгон сайжруулж мөрдөнө. / хавсралт зураг №6/

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Сэлэнгэ аймгийн Автозамыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх.
- Автозам, замын байгууламжийг бүртгэлийн санг шинэчлэх.
- 0401 чиглэлийн замаас Хүдэр Ерөө хүртэлхи 180 км хайрган зам, Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг сумдын чиглэлийн 134 км хайрган замын шинэчлэлт, барилга засварын ажлыг гүйцэтгэх.
- Баянгол сумаас Мандал сумын хүртэл 36км хайрган замыг асфальтонбетон хучилттай болгох.
- Бусад сум тосгодын төвийн нийт 50 км сайжруулсан хайрган замын засвар шинэчлэлтийн ажлыг хийх.
- Хүдэр сумын Шандын 6 м, Харзны 6м, Зүүнбүрэн сумын Сэлэнгэ мөрний салааны 6, 6, 8 м-ын урттай 5-н модон гүүрүүдийг төмөр бетон хоолой болон жижиг төмөр бетон гүүр болгох.
- Хүдэр-Бугант тосгоны 25 км зам гүүрийг засах шинэчлэх
- Баруунхараагийн төв замаас Бороо гоулд хүртэлх 45 км замыг асфальтонбетон болгох
- 4-н замаас Төмөртэй хүртэлх 100 км замыг асфальтонбетон болгох
- Ерөө, Хүдэр гол дээрх модон гүүрүүдийг төмөр бетон болгох.
- Хот маягын суурин болох Сүхбаатар, Зүүнхараа, Хөтөл хотуудын доторх замуудыг асфальтобетон хучилттай болгох.
- Хушаат сум руу Орхон гол дээгүүр гүүр барих.
- Ердийн хөрсөн замуудыг шат дараалалтайгаар сайжруулан хайрган хучилттай болгох цаашдаа асфальтобетон болгох замын сүлжээний хангамжийг сайжруулах.

**Хүрэх үр дүн:** Аймгийн хэмжээний зам, замын байгууламжийн чанар сайжирч, эдийн засгийн хөгжлийн шаардлагад нийцсэн байна.

**Тэргүүлэх зорилт 2:** Аймгийн орон нутаг иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн авто тээврийн үйлчилгээг өргөтгөх, тээврийн шинэ төрлийн үйлчилгээ бий болгох бодлого, зохицуулалтыг сайжруулна.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллах сонирхолтой аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн дунд тээврийн үйлчилгээг сайжруулах төслийг сонгон шалгаруулах замаар авто тээврийн хуулийн дагуу шаардлага хангасан харилцагчдад тусгай зөвшөөрөл олгож өрсөлдөөний үндсэн дээр ажиллуулах.
- Сүхбаатар, Зүүнхараа хотод нийтийн тээврийн үйлчилгээний зогсоол, талбай, буудлуудыг стандартын дагуу барьж байгуулан, тохижуулах.
- Ойрын сумдад дуудлагаар үйлчлэх таксийн үйлчилгээ бий болгох.
- Орон нутагт болон ОХУ-аас тээгдэж буй ачаа тээвэрлэлтийг нэгдсэн зохион байгуулалтанд оруулж хот хооронд, дамжин өнгөрөх, хот орчмын тээврийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж үүднээс улс, орон нутгийн замуудын гол

уулзваруудад диспетчерийн хяналтыг авто тээврийн шалган байцаах товчоог байгуулах.

- Авто тээвэр механизмын прокатын үйлчилгээг бий болгох, авто машин сэлбэгийн худалдааг өргөтгөх.
- Авто тээврийн ашиглалт хөдөлгөөний аюулгүй байдлын талаар сургалт, сурталчилгаа явуулах, жолооч бэлтгэж буй сургуулиудын сургалтын чанарыг дээшлүүлэх шалгалтыг тогтмол хийж жолоочийн мэргэжлийн ур чадварын түвшинг дээшлүүлэх.
- Аймгийн төвийн замын уулзваруудыг орчин үеийн гэрлэн дохиожуулах.
- Аймгийн төвд болон Алтанбулаг сумын хилийн орчимд тохилог орчин үеийн шаардлагад нийцсэн авто тээвэр, нийтийн зорчигч үйлчилгээний авто вокзалыг бий болгох.
- Хүн тээврийн аюулгүй байдлыг хангахад онцгой анхаарч авто тээврийн хэрэгслэлээр хүний амь нас, эрүүл мэнд болон хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй нөхцлийг багасгах, энэ чиглэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэнд тавих мэргэжлийн байгууллагуудын хяналтыг эрс сайжруулах.
- Аялал жуулчлалын хүрээ өргөжиж байгаатай холбогдуулан тэдэнд үйлчлэх ажлыг соёлч, шуурхай байлгаж үйлчилж буй тээврийн хэрэгслийн стандартыг ямагт хангаж ажиллах.

**Хүрэх үр дүн:** Тээврийн үйлчилгээний бодлого төлөвлөлт тодорхой болж ажил үйлчилгээ өргөжин чанарын ахиц бий боллоо.

### **Хөгжлийн Хоёрдугаар үе шат (2013-2021 он)**

**Тэргүүлэх зорилт 1.** Авто, замын сүлжээг өргөтгөн хөгжүүлж сумдыг аймгийн төвтэй хатуу хучилттай болон сайжруулсан шороон авто замаар бүрэн холбоно.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Зарим сум, суурин газрыг улсын чанартай төв замтай асфальтонбетон хучилттай замаар дэс дараатай холбоно.
- Шаамар-Улаан овоогийн нүүрсний уурхай хүртэл 145 км замыг асфальтон болгоно.
- Авто замыг засвар үйлчилгээг эрхлэх орон нутгийн мэдлийн байгууллагыг бий болгох.
- Зам, гүүрийн барилгын техник хэрэгслийн бүрэн шинчэлэх.
- Замын барилга, байгууламжинд ашиглах хайрга, элсний карьеруудын нэгдмэл мэдээллийн сантай болох.
- Аймгийн таван тосгоныг хатуу хучилттай замтай богах ажлыг эхлүүлнэ.
- Аливаа аж ахуйн нэгжүүдийн болон орон сууцны барилга байгууламжийг барихад орчны бүсдээ стандартын шаардлага хангасан хатуу хучилттай зам талбай барих ажлыг зохион байгуулах.

**Хүрэх үр дүн:** Аймгийн хэмжээний зам барилгын байгууллагуудын чадавхи, бүтээмж, ашигт ажиллагаа бүрэн сайжирсан байна.

**Тэргүүлэх зорилт 2:** Авто болон усан тээврийн үйл ажиллагааг боловсронгуй болгоно.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Бүх сумдыг өөр хоорондоо, аймгийн төвтэй холбосон тээврийн сүлжээг бий болгох.
- Хүн тээврийн аюулгүй байдлыг хангасан, ачаа, зорчигч тээврийн орчин үеийн байгууллагыг бий болгох.
- Усан замын тээврийн зогсоолыг орчин үеийн шаардлагад нийцүүлэн барих, ачаа буулгах төвийг барих.

**Хүрэх үр дүн:** Тээврийн үйлчилгээний орчин үеийн сүлжээ бүрдэнэ

#### **1.7.1.1. Төмөр замын тээврийн хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн**

**Төмөр замын тээвэр өнөөгийн байдал:** Сэлэнгэ аймгийн 6 сумын нутгаар Монгол-ОХУ-ын хувь нийлүүлсэн Улаанбаатар төмөр замын гол шугам дамжин өнгөрч эдийн засгийн дотоод гадаад харилцааны тээврийн гол үүрэг бүхий нийгмийн чанартай үйлчилгээг гүйцэтгэж байна.



Шилжилтийн үеийн өнгөрсөн жилүүд, эдийн засаг, бизнесийн өнөөгийн нөхцөлд төмөр зам хямралыг хохирол багатай даван туулах, зах зээлийн шууд хараат байдлаас аль болох ангижрах, хэвийн тогтвортой үйл ажиллагаагаа бэхжүүлэхэд ихээхэн анхаарч хөрөнгө оруулалтын бодлогоо зам, холбооны байгууламж, хөдлөх бүрэлдэхүүний аж ахуйнуудын засварын баазыг өргөжүүлэх, сэлбэг материалын хангамжийг сайжруулахад чиглүүлж ажиллаж байна.

Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай Монгол улсын хууль, Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар Төмөр Зам” нийгэмлэгийн дүрмийг үндэслэн салбарын үйл ажиллагааг нэгдсэн технологи, шуурхай удирдлагаар хангах, удирдлагын ажил үүргийн зааг ялгааг ажил үйлчилгээний чиглэл, хамрах хүрээг харгалзан удирдлагын шатлалыг төгөлдөржүүлэх, хяналт шалгалтыг оновчтой зохион байгуулах зорилгоор үүрэг хариуцлагын дараахи хуваариар ажилладаг.

### **Төмөртэй-Улаан-Овоогийн чиглэл**

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутагт байгаа Улаан-Овоогийн нүүрсний орд газрыг ашиглах хайгуул судалгааны ажил 1980-аад оноос Эрдэнэт үйлдвэрийн оролцоотойгоор хийгдсэн бөгөөд уурхайг ашиглах асуудал Засгийн газрын хэмжээнд хэлэлцэгдэж БНХАУ-ын СЕИТ компани ашиглахаар Санхүү эдийн засгийн яамтай тогтвортой байдлын гэрээг 2003 онд байгуулаад байна. Хойд бүс нутгийн нүүрсний хэрэгцээг хангах, нүүрсний олборлолтын хэмжээнээс шалтгаалан тээврийн ажлыг зөвхөн төмөр замаар гүйцэтгэх нөхцөл үүсээд байна. Энэ хэсэгт тавигдах төмөр замын урт 170км бөгөөд Зэлтэр гол, Сэлэнгэ мөрөн дээгүүр гүүр тавих шаардлагатай. Энэ уурхайг ашигласнаар Ерөөгөөс 100-аад км зайтай байгаа Төмөртэйн орд газрыг ашиглах нүүрсний хэрэгцээг хангах боломж бүрдэх юм.

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байгаа Төмөртэйн төмөрлөгийн орд газрыг ашиглах замаар Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрийн түүхий эдийг хангах, цаашдаа боловсруулсан төмрийн хүдрийг экспортлох чиглэлийг засгийн газраас барьж байна. Тус орд газрыг хамтран ашиглах асуудлыг БНХАУ-ын талаас тавьж хайгуул судалгааны эхний ээлжийн ажлуудыг хийж байна. Ерөөгөөс–Төмөртэй хүрэх зай 100 км бөгөөд зам трасын хувьд харьцангуй бартаажилт багатай юм.

Хүн амын нутагшилт хөгжлийн ерөнхий төслийн хүрээнд эрчим хүчний нэгдсэн хөтөлбөр, холбоо мэдээллийн үндсэн сүлжээ, төмөр замын сүлжээний чиглэлүүдийг харилцан уялдаатай авч үзсэнээр Монгол улсын хөгжил дэд бүтэц дээр суурилна гэсэн дүгнэлтэд хүргэсэн юм.

Дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн ч манай аймгийн ирээдүйн хөгжилд төмөр замын тээвэр тэргүүлэх үүрэг гүйцэтгэсэн хэвээр байх болно..

**Тэргүүлэх зорилт:** Орон нутгийн төмөр замд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж найдвартай ажиллагааг хангана.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Ерөө-Төмөртэй хүртэл 100 км, Шаамар-Зэлтэрийн 140 км салаа зам тавих
- Эрхэт Баянгол сумын дунд ачаа эргэлт нэмэгдвэл Номгон өртөөг бий болгох.
- Сүхбаатар өртөөний дэргэд ялгалтын парк бүхий шинэ парк байгуулах.
- Хоёр дахь гол зам байгуулах асуудлыг шийдвэрлэх.
- Сүхбаатар, Зүүнхараагийн төмөр замын вокзалыг шинэчлэх.
- Зүүнхараа өртөөнд вагон депод вагоны хос дугуйг эмхэтгэн нийлүүлэх шинэ цех барих.
- Жижиг зөрлөгүүдийг интернэтэд холбох ажил цаашид хийгдэж шилэн кабелийн сүлжээг өргөтгөх.
- Зүүнхараа өртөөнд 2009-2010 онд вагон будах цех байгуулах.

- Сүхбаатар өртөөнд ирж буй ачааны вагоны эвдрэл, зөрчлийг илрүүлдэг АСКО хянах автомат системтэй төхөөрөмжийг ОХУ-тай хамтран цахилгаан хяналтын хаалга байгуулах.

**Хүрэх үр дүн:** Сэлэнгэ аймагт төмөр замын сүлжээ өргөжиж найдвартай ажиллагааны түвшин нэмэгдсэн байна.

### 1.7.2. Эрчим хүчний салбарын хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

**Өнөөгийн байдал:** Сэлэнгэ аймагт цахилгаан эрчим хүч дамжуулах тусгай зөвшөөрөлтэй Төвийн Бүсийн Цахилгаан Дамжуулах Сүлжээ ХК-ний мэдлийн 110кВ-ын 11 дэд станц 334.7 км Цахилгаан дамжуулах агаарын шугам, “Мон тай майнз” ХХК, “Хустай Ерөө” ХХК-ний эзэмшлийн 110 кВ-ын 2 дэд станц 5.6 км шугамууд байдаг.

Аймгийн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангаж, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ ХК нь 1965 онд байгуулагдсан бөгөөд 2003 оны 11-р сард Монгол Улсын Засгийн Газрын 14 дүгээр тогтоол, Төрийн өмчийн хорооны 454 дүгээр тогтоолын дагуу зарласан нээлттэй уралдаант шалгаруулалтанд оролцож хувьчлагдсан компани юм.

ДСЦТС ХК нь 35 кВ, 10кВ, 6кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам (ЦДАШ) дэд станцуудыг эзэмшиж, техникийн ашиглалт, аюулгүй ажиллагаа хариуцан хэрэглэгчдийг стандартын шаардлага хангасан цахилгаан эрчим хүчээр найдвартай, тасралтгүй хангах үйл ажиллагааг эрхэлдэг.

Тус компанийн Хөтөл, Сүхбаатар, Зүүнхараа, Бугант салбаруудаас тэжээлтэй хувийн (хэрэглэгчийн) эзэмшлийн болон сүлжээний мэдлийн ЦДАШ, дэд станцуудын жагсаалт:

№	Салбарын нэр	6, 10 кВ-ын			35 кВ-ын		0.4 кВ-ын шугам км
		Д/станц ТП, РП	КШ км	ЦДАШ км	Д/ станц	ЦДАШ км	
1	Сүхбаатар салбар	131	22.1	390.6	4	101.4	74.2
2	Хөтөл салбар	44	2.67	190.7	3	95.1	9.4
3	Зүүнхараа салбар	39	6.8	178.9	1	39	53
4	Бугант салбар	29	5.5	90.2	2	65.2	16.5
5	Хушаат, Жавхлант	5	1.2	18	1	35	2.5
	Бүгд	248	38.3	868.4	11	33.5	155.6

Сүүлийн 5 жилд шинээр баригдсан шугам сүлжээ нь бүгд хувийн хөрөнгө оруулалттай хэрэглэгчийн эзэмшлийн тоноглолууд байна.

Аймгийн хэмжээнд дулаанаар хангах үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөлтэй 9 аж ахуйн нэгж 12 суманд дулаан үйлдвэрлэх, дамжуулах түгээх үйл ажиллагаа явуулж байна.

Сүхбаатар хот нь 22000 гаруй хүн амтай бөгөөд нийт хүн амын 60 гаруй хувь нь нийтийн эзэмшлийн орон сууцанд амьдардаг бөгөөд, мөн 200 гаруй аж ахуйн нэгж, албан байгууллагууд орон нутгийн өмчит “Сэлэнгэ энерго” үйлдвэрийн газрын (Дулааны станц) дулаанаар хангагдаж байдаг юм.

Уг үйлдвэрийн газрын харъяа дулааны шугам сүлжээ нь 1958-1988 оны хооронд монтаж хийгдсэн газар доорхи дулааны шугамтай ба 2004-2006 оны хооронд өвлийн халаалтын улиралд нийт 120 гаруй удаа шугам хоолой цоорч усны алдагдал ихсэж, дулааны станцын горимд нөлөөлж хэрэглэгчдийг дулаанаар найдвартай хангах боломжийг байнга алдагдуулж байна.

#### **Хөгжлийн Нэгдүгээр үе шат (2007-2012 он)**

**Тэргүүлэх зорилт 1.** Аймгийн дулааны эрчим хүчний үйлчилгээний чанарыг сайжруулж хэрэглэгчдийг найдвартай дулаанаар хангана.

### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Сүхбаатар, Мандал, Сайхан сумдын төвд бага чадлын нам даралтын зуух ашиглуулахгүй байх талаар бодлого боловсруулах. \хүн амын төвлөрсөн хэсэгт нүүрсний дутуу шатсан хаягдлууд агаар орчныг бохирдуулж эрүүл, аюулгүй орчинд амьдрах боломжийг хязгаарлаж байгаа \
- Бүх сумдын газар доорхи дулаан, цэвэр бохирын шугам хоолойнууд 20-иос дээш жил солигдоогүй, металл хийцийн шинжилгээнд хамрагдаагүй ажиллаж байгаа тул 2013 он хүртэл хэсэгчлэн шинэчлэх. \зэвэрдэггүй, деформацлагдах чадвар сайн яндан, хоолойгоор солих\
- Сүхбаатар сумын дулааны шугам хоолойг шинэчлэх

**Тэргүүлэх зорилт 2.** Аймгийн цахилгаан эрчим хүчний үйлчилгээний чанарыг сайжруулж хэрэглэгчдийг найдвартай эрчим хүчээр хангана.

### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Зүүнбүрэн, Цагааннуур, Алтанбулаг, Мандал, Хушаат сумдад усалгаатай тариалан эрхлэх боломжийг бий болгосон 10, 35 кВ-ын шугам, дэд станц барих.
- ОХУ-аас 35 кВ-ын шугам татаж 2 талын тэжээлтэй болгож, шугамын дамжуулах хүчин чадлыг нэмэгдүүлэх
- Шинээр олборлолт хийгдэх томоохон алтын болон ашигт малтмалын ордууд руу 110, 35 кВ-ын шугам дэд станц барих.
- Түшиг сумын Улаан-овоо нүүрсний ордыг түшиглэн цахилгаан станцыг \КЭС конденсационная электро станция\ барьж өндөр хүчдлийн шугамаар эрчим хүчний нэгдсэн системд холбох судалгаа, төслийн зураглалыг боловсруулах.
- Сумдын 0.4 кВ-ын цахилгаан шугамыг мэргэжлийн байгууллагад шилжүүлэх
- Шаамар сумын Дэлгэрхангай багийн 35 кВ-ын цахилгаан шугамыг ашиглалтанд оруулах.
- Нар, салхины сэргээгдэх эрчим хүч, бусад дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар сум, суурингуудыг, цахилгаанаар бүрэн хангах .
- "100.000 мянган нарны гэрэл" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж малчин өрхийг цахилгааны эх үүсгүүрээр бүрэн хангах

**Тэргүүлэх зорилт 3.** Нүүрсний хийн бага оврын цахилгаан станцуудыг байгуулж, хөдөө орон нутгийн эрчим хүчний хангамжийг сайжруулна.

### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Нэн тэргүүнд сумдыг модны хэрэглээнээс татгалзуулж түлшний шинэ эх үүсвэрийг бий болгох.
- Нүүрснээс утаагүй түлш үйлдвэрлэх бага оврын үйлдвэрүүдийг байгуулах ажлыг эхлүүлэх
- Нүүрснээс шингэн түлш үйлдвэрлэх дунд, томоохон хүчин чадлын үйлдвэртэй болох асуудлыг боловсруулах
- Шингэрүүлсэн шатдаг хийн цэнэглэх дэд станц ХЦС, хийн цэнэглэх цэгийг хүн ам олноор төвлөрсөн сумдад эхний ээлжинд ашиглалтанд оруулах
- Иргэдэд хийн түлшийг зөв зохистой хэрэглээг төлөвшүүлэх.
- Шингэрүүлсэн шатдаг хийн хөдөлгүүртэй автомашин хэрэглэгчдийг дэмжих

**Хүрэх үр дүн:** Нүүрсний хэрэглээ нэмэгдэж түлшний модноос татгалзана. Нүүрс боловсруулах үйлдвэрүүдийг дагаж орчин үеийн дэд бүтэц бий болно.

### **Хөгжлийн Хоёрдугаар үе шат (2013-2021 он)**

**Тэргүүлэх зорилт 1.** Аймгийн дулааны эрчим хүчний нэгдсэн системийн үр ашгийг дээшлүүлж иргэдийн амьдралын таатай орчинг бүрдүүлнэ.

### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Сумдын дулааны эрчим хүчний хангамжийг бүрэн сайжруулах.
- Гэр хорооллын айл өрхүүдийг төвлөрсөн дулаан хангамжинд холбож эхлэх.

- Дулааны шугам сүлжээний газар доорхи барилга байгууламжийг хөгжилтэй орнуудын жишигт хүргэж түнэлэн байгууламжийг бий болгон дулааны алдагдалаас бүрэн сэргийлэх
- Дулааны эрчим хүчний удирдлага, зохион байгуулалтын бүтэцийг хамгийн оновчтой байдлаар бий болгох

**Хүрэх үр дүн:** Төв суурин газрын дулаан хангамжийн найдвартай ажиллагаа хангагдсан байна.

**Тэргүүлэх зорилт 2:** Аймгийн цахилгаан эрчим хүчний үйлчилгээг хялбаршууж эрчим хүчний найдвартай хямд төсөр үйлчилгээг бүрдүүлнэ.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Цахилгаан эрчим хүчний үйлчилгээг сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх
- Нар, салхины цахилгаан үүсгүүрээр хангаж алслагдсан бэлчээрт хэвийн амьдрах боломжтой болгох
- Төв суурин цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс алслагдсан айл өрхийг хангах эрчим хүчний үйлчилгээг дэмжих
- Улаан овоо, Цогтын голын нүүрсний орд газарт түлш, эрчим хүч, нүүрсний үйлдвэр байгуулах

**Хүрэх үр дүн:** Цахилгаан эрчим хүчний хэрэглээ өсөн нэмэгдэж зохистой хэрэглээ бий болно.

**1.7.3. Мэдээлэл, харилцаа холбооны хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн**

**Өнөөгийн байдал:** Мэдээлэл харилцаа холбооны салбар нь хүн амыг дэлхий дахины болон эх орныг өргөн мэдээлэлээр хангах үйлчилгээг иргэд, байгууллагад үзүүлдэг үйлчилгээний гол салбар юм.

Сэлэнгэ аймгийн холбооны газар нь Монгол Улсын ууган холбооны газрын нэг бөгөөд анх Ардын хувьсгал ялсан өдрөөс эхлэн Ар Хиат Маймаагын /Одоогын Алтанбулаг/ Да хүрээг холбосон дан утастай морзын аппарат тавин ажиллуулж үйл ажиллагаагаа эхэлсэн. Өнөөдрийн байдлаар нийт 95 ажиллагсадтайгаар аймгийн төв болон 15 суманд цахилгаан холбооны үйлчилгээг явуулж Сүхбаатар, Алтанбулаг, Хүдэр, Ерөө, Бугант сумдыг орчин үеийн техникийн дэвшил болох тоон системд бүрэн шилжүүлсэн, сумууд хагас автомат системээр ажиллаж байна. Тоон системд бүрэн шилжсэн газарт цахилгаан мэдээ, факс, интернет, суурин болон улс хоорондын телефон холбоогоор үйлчлүүлэх бүрэн боломжтой болж байна.

Аймгийн хэмжээнд Мобиком, Скайтел, Unitel-ийн хөдөлгөөнт холбооны сүлжээнүүд үйл ажиллагаа явуулж нийт сумдын 80 гаруй хувь нь энэ үйлчилгээнд хамрагдаад байна. Хөдөөд цахилгаан орон нутгийн АТС -ийн суваг болон Монгол шуудан компаний Сэлэнгэ салбараар дамжуулан хүргэж байгаа боловч шуудан хүргэлтийн үйл ажиллагаа сайн явагдаж байна.

Холбооны үйлчилгээнд өндөр хурдны сүлжээ тоон системийг бүрэн нэвтрүүлэх, хөдөлгөөнт холбоог ашиглан баг, хот айл, малчдыг холбоожуулах, мэдээллийн технологийг айл өрхөд хүргэх, холбоо мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох, хиймэг дагуулын болон бага багтаамжийн радио релейн шугам, хөдөлгөөнт холбоог ашиглан баг, хот айл, малчдыг холбоожуулах шаардлагатай байна.

**Хөгжлийн Нэгдүгээр үе шат (2007-2012 он)**

**Тэргүүлэх зорилт 1.** Цахилгаан холбооны суурь, сүлжээг шинэчилж сумдыг шилэн кабелийн сүлжээнд холбоно. / хавсралт зураг №7/

**Хэрэгжүүлэх стратеги:**

- "Цахим Монгол" хөтөлбөр", "Мэдээлэл холбооны технологийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө (2002)", "Хөдөөгийн цахилгаан холбоог 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө (2003)", "Шуудангийн салбарыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө (2003)"-г хэрэгжүүлэх
- Түшиг, Хүдэр, Хушаат сумдыг факсын үйлчилгээнд хамруулна.

- Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар сумдыг F-zon буюу утасгүй холбооны үйлчилгээнд хамруулах
- Аймгийн зарим сумдыг мэдээлэл дамжуулах шилэн кабелийн сүлжээнд холбох
- Аймаг, сумдын төвд мэдээлэл холбооны технологийн шинэ төрлийн үйлчилгээг, тухайлбал алсын зайн сургалт, теле-эмчилгээний өндөр хурдны үйлчилгээг тууштай нэвтрүүлэх
- Аймгийн төвд телевизийн дахин дамжуулах станцыг шинэчилж, нэвтрүүлгийн чанарыг сайжруулах

**Хүрэх үр дүн:** Аймгийн нийт иргэдийн мэдээлэл цаг алдалгүй авах нөхцөл бүрдэж мэдээллийн технологийн шинэчлэлийн ажил эхэлнэ.

**Тэргүүлэх зорилт 2.** Аймаг, сумын хооронд дамжуулах системийн тоон технологит бүрэн шилжүүлж, багийн холбооны ашиглалтыг сайжруулна.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Үүрэн телефон хэрэглэгчдийн хүрээг өргөтгөж бүх сум малчдыг хөдөлгөөнт холбоонд шилжүүлэх
- Интернетийн сүлжээг бүрдүүлж, компьютер, интернет хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх
- Улс орны хэмжээнд хэрэгжих нэгдсэн кодчлолын хүрээнд бүсийн мэдээллийн нэгдсэн систем бүрдүүлэх
- Сумын төвийн холбох байгууламж тэжээлийн системийг дэс дараатайгаар бүрэн шинэчилэх
- Багийн холбооны тоног төхөөрөмжийг шинэчилж ашиглалтыг сайжруулах
- Аймгийн төвийн АТС-ийн багтаамжийг нэмэгдүүлэх
- Сумдын төвийг дэс дараатайгаар АТС-ийг нэмэгдүүлж нэгдсэн сүлжээнд холбох
- Түшиг, Хүдэр, Зүүнбүрэн, Жавхлант, Орхонтуул сумд, Бугант, Түнхэл тосгодыг үе шаттайгаар хөдөлгөөнт холбооны системд холбох
- Бүх малчид, сумын төв суурин газрууд 4-с доошгүй сувгийн нэвтрүүлэг үзэх боломжтой болгох
- Бүх шатны төрийн байгууллагуудыг интернетийн сүлжээнд холбох

**Хүрэх үр дүн:** Мэдээлэл, харилцаа холбооны орчин үеийн сүлжээний үндэс суурь тавигдсан байна.

**Хөгжлийн Хоёрдугаар үе шат (2013-2021 он)**

**Тэргүүлэх зорилт 1.** Холбооны үйлчилгээнд тоон системийг бүрэн нэвтрүүлж, хиймэл дагуулын болон бага багтаамжийн радио релейний шугам, хөдөлгөөнт холбоо ашиглан баг, хот айл, малчдыг холбоожуулна.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Орон нутгийн мэдээлэл, холбоо сүлжээний технологийн шинэчлэлтийг дуусгах
- Аймгийн алслагдсан бүс нутгуудад утасгүй холбооны технологийг нэвтрүүлж бүрэн телефонжуулах
- Мэдээлэл харилцаа холбооны дэвшилтэт технологи болох бие биенээ харж утсаар ярих болгомжийг бүрдүүлэх
- Сумын төвүүдийг шилэн кабелийн сүлжээнд бүрэн холбох
- Үүрэн телефон хэрэглэх сонирхолтой хүн амын хэрэгцээг бүрэн хангах
- Интернетийн сүлжээг сум, багийн түвшинд өргөтгөж, компьютер, интернет хэрэглэгчдийн хэрэгцээг бүрэн хангах
- Орхонтуул, Түнхэл, Бугант, Хүдэр, Түшиг, Цагааннуур, Хушаат болон бусад сумдыг сансрын холбоонд хамруулах

**Хүрэх үр дүн:** Мэдээлэл, харилцаа холбооны орчин үеийн оновчтой сүлжээ бий болж, аймгийн бүх сумд утасгүй хөдөлгөөнт холбоонд шилжиж харилцаа мэдээллийн шинэ эрин ирнэ.

**Тэргүүлэх зорилт 2.** Мэдээлэл, холбооны технологийн салбарыг эрчимтэй хөгжүүлж, үйлдвэрлэл, үйлчилгээ, хүн амын ахуйн хэрэглээнд өргөн нэвтрүүлнэ.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Мэдээлэл холбооны технологийн үйлчилгээ, хэрэглэгээг эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих нэг гол хэрэгсэл болгон хөгжүүлэх
- Мэдээлэл холбооны технологийн салбарын үйлчилгээний стандартыг дундаж түвшинд хүргэх
- Мэдээлэл холбооны технологийн салбарын мэргэжилтнүүдийг сургалтанд хамруулах
- Мэдээлэл холбооны суурь сүлжээг дундаж түвшинд хүргэх

**Хүрэх үр дүн:** Мэдээлэл, холбооны технологийн салбар нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих чухал хэрэгсэл болно. Шуудан хүргэлтийн давтамж дундаж түвшинд хүрнэ.

#### **1.7.4.Барилга, хот байгуулалтын салбарын хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн**

**Өнөөгийн байдал:**Өнөөдрийн байдлаар Сэлэнгэ аймаг нь 3 хот, 14 сум, 5 тосгон болон сумын төвүүдэд нийт 91919 хүн ам, 23462 өрх амьдарч байгаа бөгөөд нийт өрхийн 22.3 хувь нь төвлөрсөн усан болон дулааны хангамж бүхий орон сууцанд амьдарч байна. Сэлэнгэ аймаг 1990 оноос барилга хот байгуулалтын салбарын бодлого алдагдаж хот төлөвлөлт, архитктурын богино болон дунд хугацааны төлөвлөлт хийгдээгүйн улмаас аймгийн төв, томоохон суурин газруудад хувийн орон сууц болон аж ахуйн нэгжийн барилга байгууламж газрын нэгдсэн төлөвлөлтөд тусгагдаагүй, зураг төсөлгүй баригдаж хотын өнгө үзэмж, эмх цэгц алдагдаж байна.

Үүнд аймгийн түвшинд барилга хот байгуулалтын төр захиргааны албан ёсны тогтолцоо байхгүй байгаа нь нөлөөлсөөр байна.

Засгийн газраас хэрэгжүүлж буй “40.000 айлын орон сууц” хөтөлбөрийн хүрээнд аймгийн төв Сүхбаатар суманд залуу гэр бүл болон бага дунд орлоготой айл өрх хамрагдах 40 айлын орон сууц, төрийн албан хаагчид хамрагдах 20 айлын орон сууц, мөн Ерөө, Баянгол суманд 8 айл, Хүдэр, Хушаат, Шаамар, Орхон, Сант, Баруунбүрэн сумдад 4 айлын орон сууц тус тус баригдахаар барилгын ажил эхлээд байна.

Энэхүү хөтөлбөрийн хугацаанд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “40.000 айлын орон сууц” төслийн хүрээнд аймгийн хэмжээнд төвлөрсөн усан болон дулааны хангамж бүхий 500 айлын орон сууц, орон нутгийн онцлогт тохирсон дулааны хэмнэлт бүхий хямд төсөр өртөгтэй 1500 айлын орон сууц барина. Дээрх зорилтын хүрээнд залуу гэр бүл бага дунд орлоготой айл өрхийн хэрэгцээ шаардлагад нийцсэн нийтийн 800 айлын орон сууц барьж ашиглалтанд оруулна.

#### **Хөгжлийн Нэгдүгээр үе шат (2007-2012 он)**

**Тэргүүлэх зорилт 1.** Хүн амын суурьшлын зохистой тогтолцоо бүрдүүлж, барилга хот байгуулалтын тогтолцоог бий болгоно.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Аймгийн барилга хот байгуулалтын асуудлыг эрхлэх чиг үүрэг бүхий Барилга хот байгуулалтын албыг бий болгож, үйл ажиллагаагаараа өөрийгөө санхүүжүүлдэг зарчмаар явуулах
- Хүн амын суурьшлын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх
- Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хот байгуулалтын бодлогоор дэмжих
- Орон нутгийн хот суурин газруудын инженерийн дэд бүтэц, газар ашиглалтыг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хийлгэж холбогдох арга хэмжээг авах
- Төв суурин газрын гэр хорооллын хөгжлийн хэтийн төлөвийг боловсруулж хэрэгжүүлэх
- Барилга, хот байгуулалтын салбарыг бэхжүүлж, хот байгуулалтын норм нормативыг дагаж мөрдөх
- Аймгийн барилга, хот байгуулалтын цахим мэдээллийн санг бий болгох
- Сумд, тосгоны экологийн орчинг сайжруулах, экосистемийг хамгаалах, ландшафтыг барилгажилттай зөв хослуулан ашиглах төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
- “40.000 айлын орон сууц” төслийн хүрээнд аймгийн хэмжээнд 1000 айлын орон сууц барих

**Тэргүүлэх зорилт 2.** Орчин үеийн чанарын шаардлагыг хангасан барилга, барилгын материалын үйлдвэрлэл, нийтийн аж ахуйн салбарыг бий болгон хөгжүүлнэ.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Барилга, барилгын материалын үйлдвэрлэл, нийтийн аж ахуйн салбарыг боловсронгуй болгох
- Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бүтээгдхүүнийг улсын норм норматив, стандартад нийцүүлэх
- Барилга, барилгын материалын салбарт орчин үеийн техник, өндөр технологийг тууштай нэвтрүүлэх
- Орон сууцны барилгыг шинэ нэр төрлийн материал, хийц бүтээцийг ашиглан, эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт техник технологиор бариулах
- Орон нутгийн түүхий эдийн нөөцөд түшиглэсэн барилгын материалын үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх
- “40.000 айлын орон сууц” хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд 1000 айлын орон сууц барих
- Орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг нь зах зээлийн нөхцөлд нийцүүлэн боловсронгуй болгох

**Тэргүүлэх зорилт 3.** Хүн амын орон сууцны хангамжийг эрс сайжруулна.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Орон сууц барих санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, иргэдийг орон сууцны урт хугацаатай зээлд хамруулах
- Орон сууц барих санг байгуулж ажиллуулах
- Гэр хорооллыг оршин суугчдынх нь оролцоотойгоор орон сууцны хороолол болгон хөгжүүлэх
- Бага орлоготой иргэдийг нийгмийн эмзэг хэсэгт зориулсан орон сууцанд хамруулах
- Хүн амын худалдан авах чадварт тохирсон орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх
- Орон сууцны шинэ хотхон, хорооллын дэд бүтцийг байгуулахад хувийн хэвшлийн оролцоог дэмжих

**Тэргүүлэх зорилт 4.** Хот суурингийн газар ашиглалтыг сайжруулж, эд хөрөнгийн бүртгэлийн тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгоно.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Барилга байгууламж тэдгээрийн ойролцоох газарт тавих төрийн хяналт, мэргэжлийн хяналт, олон нийтийн хяналтын үр дүнтэй тогтолцоог бий болгон ажиллуулах
- Газрын шинэтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах.
- Газрын мониторингийн сүлжээ бий болгож доройтолд орж эвдэрч талхлагдсан газрыг нөхөн сэргээж сайжруулах хөтөлбөр, төслүүдийг боловсруулан хэрэгжүүлэх
- Газрын мэдээллийн системийг бий болгон иргэд, хуулийн этгээд, төрийн байгууллагад шуурхай үйлчилэх
- Аливаа эд хөрөнгийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүрэн хамруулж, өмчийн бүртгэлийн системийг боловсронгуй болгон бэхжүүлэх

**Хүрэх үр дүн:** Орон нутагт барилгын материалын үйлдвэрүүд бий болж барилгын өртөг хямдарч, ажлын байр нэмэгднэ. Нийтийн аж ахуйн салбарын үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт боловсронгуй болно.. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэгдвэл зохих нийт эд хөрөнгийн 80-аас доошгүй хувийг эрхийн улсын бүртгэлд хамруулна.

**Хөгжлийн Хоёрдугаар үе шат (2013-2021 он)**

**Тэргүүлэх зорилт 1:** Хүн амын нутагшилт, суурьшилын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалтыг улам боловсронгуй болгож, хот, суурингийн оршин суугчдад таатай орчин бүрдүүлнэ.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Сумдын төв, суурин газруудыг эрчимтэй хөгжүүлэх
- Гэр хорооллыг цэвэр, бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбож, оршин суугчдын орон сууцны нөхцлийг сайжруулах
- Сүхбаатар-Алтанбулагийн Эдийн засаг, худалдааны чөлөөт бүсийг түшиглэн орчин үеийн хот бий болгох

**Тэргүүлэх зорилт 2.** Барилга угсралтын ажилд шинэ техник, өндөр технологийг тууштай нэвтрүүлж, барилгын шинэ нэр төрлийн материал хийцийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Олон давхар орон сууц болон томоохон үйлдвэрлэлийн барилга барих үндэсний чадавхи сайжруулах
- Барилгын материалын үйлдвэрлэлд шинэ техник, технологийг нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанарыг сайжруулж нэр төрлийг нь олшруулах

**Хүрэх үр дүн:** Сумдын төвүүд хөгжин, иргэд орон нутагтаа тогтвор суурьшилтай амьдрах нөхцөл бүрдэнэ. Барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэл тодорхой түвшинд хүрсэн байна.

**1.8.Банк, санхүү, үнэт цаас, даатгалын байгуулагын хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн**

**Өнөөгийн байдал:**Орон нутагт банкууд төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, аймгийн нийгэм эдийн засаг, санхүүгийн салбарын хөгжлийг дэмжихэд, улмаар банк санхүүгийн зуучлалыг өргөжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэж байна. Аймгийн хэмжээнд нийт 10 банкны салбар, биеэ даасан тооцооны төвд 228 ажилтан банкны ажил үйлчилгээ явуулж тэнцлийн дүн 17552.0 сая төгрөгт хүрч, өмнөх оныхоос 6945.5 сая төгрөгөөр нэмэгдлээ.

Банкны салбарууд харилцагч аж ахуйн нэгж, байгуулагауд, иргэдэд 28629.9 сая төгрөгийн зээл олгосноос салбарын бүтцээр авч үзвэл **10.7** хувийг ХАА, **51.9** хувийг худалдааны салбар, **2.9** хувийг үйлдвэрлэлийн, **34.4** хувийг бусад буюу орон сууц, ахуйн хэрэглээ, тээвэр, аялал жуулчлал, цалин тэтгэвэр тэтгэмжинд олгосон байна.

Банкуудад байршуулсан иргэдийн хадгаламж **5742.6** сая төгрөгт хүрсэн нь өмнөх оныхоос **2283.2** сая төгрөгөөр нэмэгдлээ.

Нийт зээлийн багц 15913.4 сая төгрөгт хүрч өмнөх оныхоос **6046.3** сая төгрөгөөр нэмэгдэж, зээлийн багцын хэмжээгээр ХААН, ЗООС, ХАС банкууд тэргүүлж байгаа бөгөөд нийт зээлийн багцын **86.8** хувийг бүрдүүлж байна

Банкууд дахь татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ нэмэгдэхийн хирээр тус мөнгөөр санхүүжигдэх зээлийн хэмжээ өссөөр байна. Зээлийн хэмжээ өсч байгаа нь банкны салбарын дэвшилттэй тал боловч **бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт** хөрөнгө оруулалт хийх, ялангуяа **дунд болон урт хугацаат зээлжүүлэлт дутмаг, зээлийн хүү үйлдвэрлэлийг дэмжихүйц хэмжээгээр буурахгүй** байна.

Монгол банк арилжааны банкуудын Монгол банкинд байршуулдаг заавал байлгах нөөцийн хэмжээг **5** хувиар бууруулсан нь зээлийг хүүг бууруулах боломжийг бий болгож байна.

Үнэт цаасны зах зээлийн үйлчилгээний орон нутаг дахь үйлчилгээний хүртээмж хөгжөөгүй, энэ талын иргэдийн мэдлэг олгох мэдээлэлийн орчинг бүрдүүлэх шаардлагатай байна.

Иргэдийн даатгалын байгуулагуудтай хамтран ажиллах таатай орчинг бий болгоход анхаарч, тэдгээрийн санхүүгийн найдвартай хамгаалалтыг иргэд, аж ахуйн нэгжүүдэд хүргэх нь энэ салбарт баримтлах аймгийн гол бодлого байх ёстой.

**Тэргүүлэх зорилт:** Аймагт банк санхүү, даатгалын үйлчилгээний оновчтэй тогтолцоог бий болгоно.

**Хэрэгжүүлэх стратегийн арга хэмжээ:**

- Бүх сум, суурин газаруудад арилжааны банкнуудын 2-3 салбаруудыг байгуулж өрсөлдөөнийг бий болгох
- Зах зээлийн нийтлэг зүй тогтол, түгээмэл зарчмуудын удирдлага болгон Сэлэнгэ аймгийн ард иргэд, аж ахуйн нэгжүүдийг үнэт цаас, санхүүгийн үйлчилгээний зах зээлийн идэвхитэй оролцогч болгох
- Аймагт үнэт цаас, банк санхүүгийн үйлчилгээ, даатгалын тогтвортой хөгжүүлэх тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх
- Аймагт ард иргэдийн үнэт цаас эзэмшигчдийн эрх ашгийн тууштай хамгаалах тогтолцоог бүрдүүлэх



- Үнэт цаасны хоёр дахь зах зээлд идэвхитэй үйл ажиллагаа явуулснаар гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, ашиг орлогоо нэмэгдүүлэх боломжтойг нийт ард иргэд, менежрүүдэд төлөвшүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах
- Банкны үйл ажиллагааг орон нутагт хөрөнгө оруулах, аймгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх чиглэлээр дэмжих
- Банкны байгууллагатай өрсөлдөхүйц орон нутгийн шинж чанартай санхүүгийн байгууллагуудыг бий болгох
- Одоо байгаа банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний өртгийг хямдруулж, хөрөнгө оруулах, хүн амын амжиргааг дээшлүүлэх чиглэлээр хөнгөлөлттэй үйлчилгээг бий болгоход дэмжлэг үзүүлэх
- Бүс нутгийн шинж чанартай гадаад болон дотоод төлбөр тооцоо, санхүүгийн болон түрээс, авлага барагдуулах зэргээр үйл ажиллагаа явуулах бичил санхүүгийн байгууллагуудыг байгуулж ажиллуулах, үр ашигтай ажиллахад нь дэмжлэг үзүүлэх
- Зах зээлийн зүй тогтоцын дагуу аж ахуйн нэгж, хувь хүний үйл ажиллагааны эрсдлийг даатгалын байгууллагуудтай хамтран ажиллах замаар бууруулах чиг хандлагыг төлөвшүүлэх.

**Хүрэх үр дүн:** Банк санхүүгийн оновчтой тогтолцоо бүрдэж иргэд банк, санхүү, үнэт цаас, даатгалын байгууллагуудын хамтын ажиллагаа өргөжинө.

#### **Гурав. Байгаль орчны ашиглалт, хамгаалалтын бодлого**

Хүн ам эрүүл, аюулгүй орчинд амьдрах, аймаг, сумын эдийн засаг, нийгмийн, байгалийн нөөцийн чадавхид нийцүүлэн тогтвортой хөгжүүлэх, өнөөгийн болон ирээдүйн үеийнхний эрэлт хэрэгцээ, шаардлагын үүднээс байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, үр өгөөжийг ард иргэдэд адил тэнцүү хүртээмжтэй хүргэх нөхцлийг хангана.

#### **Байгаль орчны салбарын бодлогын ойрын ба хэтийн үзэл баримтлал**

- Байгаль орчны тэнцлийг тогтвортой хадгалах, орчны бохирдол, доройтлыг хязгаарлан зогсоох, байгалийн нөөцийг иж бүрэн, үр өгөөжтэй ашиглах, нөхөн сэргээгдэх баялгийг өсгөн арвижуулах, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, түүнээс учирсан хохирлыг арилгах, аймаг орон нутгийнхаа чадавхийг бий болгох замаар эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглүүлэх ерөнхий бодлогыг баримтлах
- Байгалийн баялгийг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлэх
- Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах, арилгах, хүн амын амьдрах таатай орчныг бүрдүүлэх, стандартын түвшинг хянаж сөрөг нөлөөллийг арилгах

Тогтвортой хөгжлийн **шалгуурын үндэс нь** агаар мандал, газар, түүний хэвлийн баялаг, ус, ой, ан амьтан, ургамлын төрөл зүйлийг хамгаалах, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, цөлжилт, гангын нөлөөг бууруулах, шинээр үүсч буй химийн хорт бодис, цацраг идэвхит хаягдлыг багасгах, хог хаягдлын менежментийг сайжруулах зэрэг хүрээлэн буй орчныг хамгаалахад чиглэгдсэн **эдийн засаг, нийгэм, экологийн цогц арга хэмжээ** байна.

### **3.1. Агаарын бохирдлыг багасгах талаар хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн**

**Өнөөгийн байдал:** Дэлхийн дулааралтаас үүдэн Сэлэнгэ аймгийн уур амьсгал өөрчлөгдөж аймгийн агаарын жилийн дундаж температур сүүлийн 45 жилийн хугацаанд  $1.05^{\circ}\text{C}$  –аар дулаарч, хур тундасны нийлбэр багасгах хандагатай байна. Эрдэмтдийн хийсэн судалгаагаар уур амьсгалын өөрчлөлт нь хүний хүчин зүйлийн нөлөө, агаарын бохирдолоос шууд хамааралтай байна.

Аймгийн сумдын агаарт хийсэн хэмжилтээр азотын давхар исэл/ $\text{NO}$  /, хүхэрлэг хий / $\text{SO}$  / нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давж бохирдоогүй боловч хүн ам олонтой Баянгол, Мандал, Сүхбаатар, Хөтөл сумдад агаарын бохирдол харьцангуй их буюу жилээс жилд ихсэх хандлагатай байна.

#### **Хөгжлийн Нэгдүгээр үе шат (2007-2012 он)**

**Тэргүүлэх зорилт.** Агаарын төлөв байдал, уур амьсгалын өөрчлөлтөд тавих хяналт шинжилгээ, мэдээллийн сүлжээг өргөтгөн, агаарыг бохирдолоос урьдчилан сэргийлнэ.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Сэлэнгэ аймгийн цаг уурын бүсчлэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоож эдийн засгийн, ялгавартай бодлого хэрэгжүүлэх
- Аймгийн уур амьсгалын ирээдүйн төлөв байдал, түүний нөлөөлөх байдлын үнэлгээг тодорхой хугацааны давтамжтай хийж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Аймгийн уур амьсгалын үндсэн элементийн өөрчлөлтийг шинэчлэн тогтоох, Уур амьсгалын өөрчлөлтийн байгалийн бүс, бүслүүр хөрсний үржил шимд нөлөөлөх байдлын өөрчлөлтийн үнэлгээ хийх асуудлыг шийдвэрлэх
- Агаар, ус, хөрсний бохирдлын түвшин болон бохирдуулагч эх үүсвэрт байнгын хяналтын хэмжилт хийж, ус цаг уур, орчны шинжилгээний төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэх
- Авто тээврийн хэрэгслээс гарч буй угаарын хийн зөвшөөрөгдөх хэмжээ, стандарт мөрдөлтөд тавих мэргэжлийн хяналтын албадын хяналтын үйл ажиллагааг сайжруулж, хот суурингийн замыг цардах, ногоон байгууламжийг өргөтгөх замаар тоос дэгдэлтийг бууруулах
- Хил дамжсан агаарын бохирдолыг хамтран хянах, цаг алдалгүй мэдээлэл солилцох талаар хөрш орнуудын аймаг, хотуудтай хамтран ажиллах
- Агаар, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээний талаархи мэдээллийг сайжруулж, мэдээлэл ашиглах боломжийг нэмэгдүүлэх
- Хог хаягдал шатаах, бохир усыг ил задгай хаяхыг бүрмөсөн зогсоох арга хэмжээ авах
- Зүүнхараа, Хөтөл, Сүхбаатар хотууд, уул уурхайн томоохон үйлдвэр бүхий сумдын орчны бохирдлыг бууруулах эрх зүй, эдийн засаг, удирдлага зохион байгуулалтын нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх
- Түлшний шинэ технологи нэвтрүүлэх, модыг түлшний хэрэглээнээс хасах чиглэлээр тодорхой хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.
- Нүүрсний борлуулалтын цэгүүдийг сум болгонд байгуулах.
- Төвлөрсөн халаалтад ойрхон байршилтай ердийн галлагаатай орон сууцуудыг төвлөрсөн халаалтын системд холбох ажлыг эхлүүлэх
- Нам даралтын халаалтын зуухаар үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжүүдийг байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд бүрэн хамруулж, төвлөрсөн халаалтын сүлжээнд хамруулах
- Хог хаягдал ялган боловсруулах бага оврын үйлдвэр бүсийн төвдүүдэд байгуулна.
- Удаан задардаг органик бохирдуулагчын тооллого судалгаа хийх.

**Хүрэх үр дүн:** Агаар мандлыг цэвэр ариун байлгах талаар аж ахуйн нэгж, иргэдийн үүрэг хариуцлага нэмэгдэж, бохирдлоос урьдчилан сэргийлнэ.

**Хөгжлийн Хоёрдугаар үе шат (2013-2021 он)**

**Тэргүүлэх зорилт .** Агаарын төлөв байдал, уур амьсгалын өөрчлөлт хяналтын хүрээг өргөтгөж, мэдээллийн нэгдсэн сүлжээг боловсронгуй болгож бохирдлын түвшинг стандартад нийцүүлэн бууруулна.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Агаарын бохирдол, агаарын төлөв байдалд тавих хяналтыг сайжруулж нарны хэт ягаан туяаг хэмжих багаж, тоног төхөөрөмжийг суурилуулах асуудлыг судалж шийдвэрлэх
- Томоохон сум суурингуудад агаарын бохирдлыг хянах харуулын цэг нэмж байгуулах
- Эрчим хүчний системийг байгаль орчинд хал багатай тоног төхөөрөмжөөр шинэчлэх
- Үйлдвэрлэлийн хаягдлыг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон дахин боловсруулах техник, технологи нэвтрүүлэх
- Түлшний шинэ эх үүсгэвэр бий болгох, түүнийг тээвэрлэх, ашигтай хэрэглэх талаар дотоод, гадаадын туршлага, санаачилгыг дэмжих

- Аймгийн төвийн гэр хорооллын айл өрхийг зуун хувь бүрэн шаталттай зуух түлшээр хангах;
- Аймгийн төвийн нам даралтын зуух бүхий үйлдвэрлэл, үйлчилгээний цэгүүдийг төвлөрсөн халаалтын системд холбож дуусгах

**Хүрэх үр дүн:** Агаарын чанар, төлөв байдал, уур амьсгалын төлөв байдалд тавих хяналт сайжирч бохирдлын түвшин буурна.

### **3.2. Газрын нөөцийн ашиглалт, хамгаалалт**

**Өнөөгийн байдал:** Сэлэнгэ аймаг нь 4115,2 мянган га газар нутагтай.

Нийт нутаг дэвсгэрийн 50,6 % буюу 2084,6 мянган га нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 1,2 буюу 47,9 мянган га нь хот тосгон бусад суурины газар, 0,5% буюу 19,4 мянган га нь зам шугам сүлжээ бүхий газар, 39% буюу 1607,5 мянган га нь ойн сан бүхий газар, 0,5 % буюу 19,2 мянган га нь усан сан бүхий газар, 8,2 % буюу 336,6 мянган га нь улсын тусгай хэрэгцээний газарт хамаарч байна.

#### ХАА-н эдэлбэр газраас:

- Тариалангийн газар 14.7% буюу 305.5 мянган га бөгөөд 4069 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 258,7 мянган га, үүнээс 252,1 мянган га нь үр тарианы, 4,9 мянган га нь төмс, хүнсний ногоо тарих зориулалтаар эзэмшиж байна.
- Бэлчээрийн газар 79% буюу 1648,1 мянган га, түүнийг нийтийн эзэмшлээр мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ашиглаж байна.
- Хадлангийн газар 5,9% буюу 123,4 мянган га газар хадланд тохиромжтой газар гэж тайланд тусгагдсан боловч жил бүр гэрээгээр ..... /Энд тоо тавих/ мянган га-г хадаж ашигладаг.

#### Хот, тосгон бусад суурин газраас:

- Ашигт малтмал олборлох уул, уурхайн зориулалтаар 18,6 мянган га газарт ашиглалтын “А” лицензээр эзэмшил, ашиглалтанд олгогдсоноос 183 аж ахуйн нэгж, байгууллага 31.5 мянган га газрыг ашиглаж байна. 2005-2006 оны байдлаар 522.6 га газарт нөхөн сэргээлт хийгдсэн.
- 1182 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 1270 га барилга, байгууламжийн зориулалтаар, 113 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 330 га-г үйлдвэрийн зориулалтаар, 17397 иргэн 4428 га гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар, үүнээс 8896 иргэн 2504,69 га буюу 39413,9 сая төгрөгийн үнэ бүхий газрыг нэг удаа үнэгүй, аж ахуйн зориулалтын 0,3 га газрыг 1 иргэн 2448 мянган төгрөгөөр худалдаж өмчлөхөөр авсан байна.

### **Хөгжлийн Нэгдүгээр үе шат (2007-2012 он)**

**Тэргүүлэх зорилт 1.** Аймаг, бүс, сумын түвшинд газрын эзэмшил, ашиглалт, хамгаалалт, эрх зүйн мэдээллийн санг бий болгож, харьцааны асуудлыг төрийн зохицуулалтаар хөтлөнө.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах.
- Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг хөгжлийн үндсэн чиглэлтэй уялдуулан газрын эрэлт хэрэгцээнд тулгуурлан боловсруулж, хэрэгжүүлэх
- Газрын нөөцийн менежментийг сайжруулж Газрын албыг орчин үеийн багаж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж мэргэжилтэнгүүдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх
- Сумын төв, томоохон суурин газарт оршин суугч иргэдэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг нь өмчлүүлэн тэдэнд газраа арилжаалах, барьцаалах, бэлэглэх, өв залгамжлуулах, түрээслүүлэх эрх зүйн баталгаагаар ханган эд хөрөнгийн эрхийн гэрчилгээ олгох асуудлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх
- Иргэдийн аж ахуйн зориулалтаар эзэмшиж буй газрыг давуу эрхээр худалдаж өмчлөх нөхцөл боломжийг бүрдүүлэх

- Тариалан болон суурин газарт кадастрын зураглал хийж эрх зүйн баталгаагаар ханган улсын бүртгэлд бүртгэж “Үндэсний газрын мэдээллийн сан”-гийн эх суурийг тавих
- Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусган бэлчээрийн газрыг малчин өрх, хот айлаар нь хуваарилан гэрээгээр ашиглуулах
- Эрчимжсэн мал аж ахуйн бүсийг тогтоож, фермерийн аж ахуйг эрхлэгчдэд газрыг нь эзэмшүүлэх

**Хүрэх үр дүн:** Сумын Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө бодитой төлөвлөгдөж газар ашиглалт хамгаалалтын түвшин сайжирч орчин үеийн багаж техникээр хангагдан “Үндэсний газрын мэдээллийн сан”-гийн сүлжээнд холбогдоно.

**Тэргүүлэх зорилт-2.** Бэлчээрийн талхагдал, хөрсний элэгдэл, эвдрэлд орсон талбайн ашиглалт, сайжруулалтыг төрийн хяналтад байлгаж зохицуулна.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Бэлчээр ашиглалтын одоогийн байдлыг харуулсан зураг хийж талхлагдсан бэлчээрийг чөлөөлөх, сайжруулах арга механизмыг оновчтой төлөвлөх нөхцлийг бүрдүүлэх
- Элэгдэл, эвдрэлд орсон тариалангийн талбай болон атаржсан газрыг нэрвэгдэлтийн зэргээр нь ялгаварлан тогтоож, шатлан сайжруулж, хөрсжүүлэх, олон наст тариалах төлөвлөгөөг бүс, сум, газар эзэмшигч байгууллага, иргэдийн хүчээр хийлгэж тогтмолжуулах.
- Тариаланд ашиглах боломжгүй талбайн үндэслэлийг тодорхойлон эргэлтийн талбайгаас хасч, олон наст ургамалын үр тарих, бэлчээрийн нөөцөд оруулах болон бусад ангиллын газарт шилжүүлэх
- Тариалангийн газрын хөрсийг салхины элэгдэл, эвдрэлээс хамгаалж зурваслан тариалалтыг нийт эргэлтийн талбайн 70%-д хүртэл хамруулах.
- Тариалангийн талбайн чийгийн алдагдлыг багасгах, салхины элэгдэл, эвдрэлээс хамгаалж сүрлийг хэрчиж хучих арга хэмжээг авч хэрэгжүүлэн нийт эргэлтийн талбайн 60%-д хүртэл хамгаалах
- Ашигт малтмалын олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг хийх зардлын 50%-ийг сум, орон нутгийн төсвийн “тусгай сан”-д хадгалуулдаг журмыг хэвшүүлэх
- Хот суурин газарт газар эзэмшигчдийн эзэмшил газрын 10%-иас доошгүйг ногоон байгууламжтай болгох арга хэмжээг газар эзэмших гэрээнд тусгаж жил бүр дүгнэж хариуцлага тооцох
- Хортон мэрэгчид, хөнөөлт шавьжны тархалтыг зогсоох, хор хөнөөлийг багасгах арга хэмжээг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоотойгоор зохион байгуулах арга хэмжээ авах.

**Хүрэх үр дүн:** Хөрсийг салхины элэгдэл эвдрэлээс хамгаалах, зардал бага шаардах арга хэмжээнүүд хэрэгжиж нөхөн сэргээлтийн ажил тогтмолжин, үржил шимтэй хөрсний алдагдал харьцангуй багасна.

**Хөгжлийн Хоёрдугаар үе шат (2013-2021 он)**

**Тэргүүлэх зорилт -1**

Газрын үржил шимт чанарын эдийн засгийн үнэлгээг бодитойгоор тооцож, түүний үр өгөөжийг үнэн зөв тодорхойлно.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- “Үндэсний газрын мэдээллийн сан”-гийн сүлжээнд бүс, сумдыг холбож мэдээллийн сангийн сүлжээ үүсгэх
- ХАА-н эдэлбэр газрын ашиглалтын төрөл тус бүрээр экологи-эдийн засгийн үнэлгээг хийж газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах
- Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдыг кадастрын зурагт бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах
- Хөрсний үржил шимийг дээшлүүлж, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх
- Экологийн гаралтай бордоогоор хангаж, хэрэглэж сургах

**Хүрэх үр дүн:**Газартай харилцагчид кадастрын зургааг бүрэн хангагдаж хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд экологи эдийн засгийн үнэлгээг тооцож, экспортлолт нэмэгдэж ажилгүйдэл ядуурлын түвшин багасна.

**Тэргүүлэх зорилт 2:**Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдыг эдийн засгийн харилцаанд оролцуулж, эрх зүйн орчинг сайжруулна .

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Газрын рентийг тодорхойлж, иргэдэд мэдээллээр нээлттэй үйлчилэх.
- Газар түрээслүүлэгч, түрээслэгчдийн хоорондын харилцааны эрх зүйг боловсронгуй болгох.
- Газрын биржийн үйл ажиллагааны эх суурийг бий болгох.
- Төрийн санд төвлөрүүлэх татварын орлогыг нэмэгдүүлэх.
- Газрын далд арилжаа, наймаа хязгаарлах.

**Хүрэх үр дүн:**Газрын рентийг тодорхойлдог болж, татварын уян хатан бодлого хэрэгжиж, газрын харилцааны эрх зүйн орчин сайжирч эдийн засагт таатай нөлөө үзүүлнэ.

### **3.3. Усны нөөцийн ашиглалт, хамгаалал**

**Өнөөгийн байдал:** Сэлэнгэ аймаг 2.9 млрд м<sup>3</sup> усны нөөцтэй. Үүнээс газрын доорхи усны нөөц 0.4 млрд м<sup>3</sup> гадаргын усны нөөц 2.5 млрд м<sup>3</sup> гэж тогтоогдсон байна. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдийн хэт дулаарал бусад хүчин зүйлсийн нөлөөгөөр олон арван гол горхи, булаг шанд, ширгэж алга болсон байна. Аймгийн Байгаль орчны шинжилгээний лабораторид томоохон 11 гол мөрний гадаргын усанд хийсэн гидрохимийн шинжилгээний дүнгээр, Хиагтын гол маш их бохирдолтой, Алтны уурхай бүхий сумдын нутаг дахь Хүдэр, Хараа, Тариат, Туул, Ерөө, Бэрлэг, Ялбаг зэрэг голуудын ус аммоны азот, нитрит, нитрат, фосфор г м элементүүдээр бохирдож байна.

1990 онд бэлчээр усжуулалтанд 698 худаг ашиглагдаж байжээ. 2003 оны гадаргын усны тооллогоор гол горхи 596, булаг шанд 208, рашаан ус 28, нуур цөөрөм 46 тоологдсон бөгөөд 2006 онд бэлчээр усжуулалтанд инженерийн хийцтэй нийт 357 худаг бүртгэлтэй байна. Иймээс 2007онд бэлчээр усны тооллогоор инженерийн хийцтэй худгийг нарийвчлан тоолох шаардлага гарч байна. Аймгийн газрын нэгдмэл сангийн тайлангаар бэлчээрт ашиглагдах цэвэр талбай 1648,0 мянган га, ойн сангаас бэлчээрт ашиглагдах талбай 160,7 мянган га, хилийн зурвас, шугам сүлжээ, хадлан, авто зам, атаржсан газраас бэлчээрт ашиглагдах талбай 102.1 мянган га, бэлчээрт ашиглагдах боломжтой нийт талбай 1831.0 мянган га байгаагаас усан хангамжийн асуудлыг шийдвэрлэсэн талбай буюу усжуулалтын түвшин 54,7 хувийг эзэлж байна.

Усжуулагдаагүй байгаа бэлчээр нутгийн ихэнх нь Орхонтуул, Сайхан, Хушаат, Цагааннуур, Ерөө, Жавхлант сумдын нутагт байна. Сүүлийн жилүүдэд манай аймагт худаг шинээр гаргах, засварлах ажил эрчимтэй явагдаж инженерийн хийцтэй 100 гаруй худаг шинээр гаргаж 80 гаруй худагт их засвар шинэчлэлт хийсэн байна.

Цаашид Хараа, Ерөө, Орхон, Сэлэнгэ мөрний усны нөөц болон аймгийн нутаг илрүүлсэн газрын доорхи усны ордуудыг түшиглэн усалгаатай газар тариаланг хөгжүүлэх, бэлчээр усжуулах ажлыг үе шаттай, тодорхой төлөвлөгөөний дагуу явуулбал, мал аж ахуй, түүний дотроос эрчимжсэн үхэр, хонины аж ахуйг хөгжүүлэх бүрэн боломжтой байна.

#### **Хөгжлийн Нэгдүгээр үе шат (2007-2012 он)**

**Тэргүүлэх зорилт :** Усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах үйл ажиллагааг оновчтой үр ашигтай зохион байгуулах, усны нөөцийг бохирдох хомсдохоос хамгаалах

**Хэрэгжүүлэх стратеги**

- Аймгийн түвшинд гадаргын болон газрын доорхи усны нөөцийг зохистой ашиглах, бохирдлыг бууруулах бодлого боловсруулах
- Аймгийн нутаг дэвсгэрт усны эх үүсвэрийн тооллого явуулж, ус ашиглалтын бэлэн байдлын түвшинг тогтоож, усны мэдээллийн санг шинэчлэн баяжуулах
- Аймгийн нутаг дахь гол мөрний сав газрын зөвлөлийг байгуулж, усны менежментийн төлөвлөгөө боловсруулах

- Олон улсын хилийн усны гэрээний дагуу хил дамжсан усны бохирдолтыг хамтран хянах, мэдээллийг шуурхай солилцох талаар ОХУ-ын зэргэлдээх аймаг хотуудтай хамтран ажиллах
- Эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллаж гадаргын усны бохирдолтын түвшинг/ хүнд элементүүдийг/ тодорхойлох
- Хүн ам, Хөдөө аж ахуй, Үйлдвэрийн ус хэрэглээний хэмжээг орон нутгийн онцлогтой уялдуулан шинэчлэх
- Сумын төв, суурин газарт хүн амын ундны усны хатуулгыг зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх төхөөрөмжийг суурилуулах
- Хараа, Ерөө, Орхон, Сэлэнгэ мөрний усны нөөцөд түшиглэн, экологид халгүй услалтын систем барих, шинэчлэх замаар усалгаатай газар тариаланг хөгжүүлэх
- Инженерийн хийцтэй уст цэгийг сэргээн засах шинээр гаргах замаар бэлчээр усжуулах ажлыг үе шаттайгаар явуулна. Инженерийн хийцтэй уст цэгийг сэргээн засах шинээр гаргах замаар бэлчээр усжуулах ажлыг үе шаттайгаар явуулах

**Хүрэх үр дүн:** Хүн ам, хөдөө аж ахуй, үйлдвэрт усыг зохистойгоор ашиглаж, хүн амын амьдрах нөхцөл дээшлэх, бэлчээр усжуулалтын үр дүнд нутгийн болон цэвэр эрлийз үүлдрийн эрчимжсэн мал ахуй өсч усалгаатай газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдэж, хүн амын амьжиргаа дээшилнэ. Ус хэрэглээний хэмжээг шинэчилж тогтоосноор усны нөөцийг зохистой ашиглах усны чанарыг хамгаалах, удирдлага зохион байгуулалтын үйл ажиллагаа сайжирч сав нутгийн усны нөөцийг зохистой ашиглаж, усны бохирдолт буурна.

#### **Хөгжлийн Хоёрдугаар үе шат (2013-2021 он)**

**Тэргүүлэх зорилт:** Ус ашиглалтын болон түүнд нөлөөлөх байгалийн бусад сөрөг нөлөөллийг бууруулах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалан хамгаална.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Усны нөөцийг зохистой ашиглаж, хамгаалах хяналт зохион байгуулалтын бүтцийг бий болгож сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх
- Рашааны усны үр ашгийг нэмэгдүүлж, экологийн ач холбогдол бүхий усны эх үүсвэрийг хамгаалалтад авах
- Аймгийн төвийн цэвэр усны эх үүсвэрийн өргөх, шахах станц, шугам сүлжээг шинэчлэх ажлыг үе шаттайгаар явуулах
- Гол усны байгалийн тогтсон горимыг эвдрэх, өөрчлөхөөс хамгаалах арга хэмжээг үе шаттай явуулах
- Бугант, Сүхбаатар, Баянгол, Мандал, Сайхан сумын ус цэвэрлэх байгууламжийн хэвийн ажиллагааг хангах хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг гадаад, дотоодын төслийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх арга хэмжээ авах
- Орон нутгийн нөөц бололцоонд тулгуурлан хур тунадас, үерийн усыг хуримтлуулж газар тариаланд ашиглах төслийг гадаад дотоодын төслөөр хэрэгжүүлэх арга хэмжээ авах

**Хүрэх үр дүн:** Усны нөөцийг байгалийн аясаар нөхөн сэргэх нөхцлийг бүрдүүлнэ. Ус ашиглалтын барилга байгууламжид шинэ техник технологи нэвтэрнэ.

#### **3.4. Ойн нөөцийн ашиглалт, хамгаалалт**

**Өнөөгийн байдал:** Сэлэнгэ аймгийн ойн сан нь Хэнтийн нурууны салбар уулс, Зүүн Сибирийн Их тайга, Хангайн нурууны салбар уулсын зааг дээр Орхон Сэлэнгэ мөрний ай савын хагалбарыг дагаж ургасан, гол мөрний усыг зохицуулах, цуглуулах, хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаалах, уур амьсгалыг зөөлрүүлэх, хүлэмжийн хийг шингээх, амьтан ургамал, бичил биетний амьдрах тааламжтай орчныг бүрдүүлэх, мөнх цэвдгийг тогтоон барих зэрэг байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах өндөр ач холбогдол зүй тогтоцтой билээ.

Тус аймгийн ойн сан нь ..... сая га буюу аймгийн газар нутгийн 54,2 хувь, үүний дотор шинэсэн ой 34,0 хувь, нарсан ой 24,6 хувь үлдсэн хувийг хуш, гацуур, жодоо, болон хус, улиангар, улиас бутлаг модод эзэлж байна. / хавсралт зураг №8/

1990 он хүртэл улсын хэмжээний мод бэлтгэлийн үйлдвэрлэлийн 70 гаруй хувь нь тус аймгийн нутаг дэвсгэр дээр төвлөрч жилдээ 300-400 мянган шоо метр мод бэлтгэж байсан байна. Аймгийн хэмжээнд сүүлийн долоон жилийн турш жилдээ 1000-1500 га-д ойжуулалт хийж байсан боловч удаа дараагийн ойн түймэр хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс болж ойн сан үлэмж багасаад байна.

Иймд ойг хамгаалах, ашиглалтад нь тавих хяналтыг сайжруулах, нөхөн сэргээх, ухаалаг хэрэглээг, төлөвшүүлэх шаардлага улам бүр нэмэгдсээр байна.

### **Хөгжлийн Нэгдүгээр үе шат (2007-2012 он)**

**Тэргүүлэх зорилт 1.** Ойг хамгаалах, ашиглах эрх зүйн орчинг боловсронгуй болгож, ойн нөөцийн нөхөн сэргээлтийг сайжруулна.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Ойг хамгаалах, ашиглахтай холбоотой хууль, тогтоомж, журмыг боловсронгуй болгох талаар санал боловсруулах
- Ой мод ашигласны төлбөрийн тодорхой хэсгийг ойг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах
- Жил бүр ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг зохион байгуулж, ойн хортон шавьжтай тэмцэх, устгах ажлыг өргөтгөх.
- Нарс, бургас, гацуур, жодоон ойг хамгаалах, нөхөн сэргээх ажилд нутгийн иргэдийг өргөнөөр татан оролцуулах, гэрээгээр эзэмших, хамгаалах, нөхөн сэргээх ажилд дэмжлэг үзүүлэх
- Хууль бус модон материал бэлтгэх, тээвэрлэхийг бүрэн зогсоох

**Хүрэх үр дүн:** Ойн нөөцийн ашиглалт, хамгаалал хөгжилтэй орнуудын түвшинд ойртож, оновчтой тогтолцоо бүрдэнэ.

**Тэргүүлэх зорилт 2.** Ойн нөөцийн тогтвортой ашиглалтын менежментийг бүрдүүлэх замаар ойг хамгаалах, нөхөн сэргээх, экологийн тэнцлийг хадгалах нөхцлийг хангана.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Аймгийн нийт ойн санд шинээр сансрын мэдээ ашиглаж зайнаас тандан судлах аргаар хайгуул, судалгаа хийж тархалт, бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоон ойн зураглал, ойн тогтвортой менежментийн хөтөлбөр боловсруулж, газар зүйн мэдээллийн системд суурилсан ойн мэдээллийн сан байгуулах
  - Стратегийн дунд хугацааны зорилтын хүрээнд уур амьсгалыг зөөлрүүлж, цөлжилт, хөрсний эвдрэл, элсний нүүлттэй тэмцэх зорилгоор ойг нөхөн сэргээх, элсжсэн хээрийн бүсэд мод тарих замаар ногоон зурвас байгуулах
  - Ойг хамгаалах ажилд дэвшилтэт менежментийн арга хэлбэрийг нэвтрүүлж, ойн сангийн 30 хүртэлх хувийг нутгийн иргэд, нөхөрлөлд гэрээгээр эзэмшүүлэх замаар ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх
  - Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчдын чадавхийг дээшлүүлэх, шаардлагатай техник, хэрэгсэлээр хангах
  - Жил бүр нийтээр мод тарих өдрийг тогтоож, хот суурин газрыг цэцэрлэгжүүлэх, гол усны эх, тариалангийн талбай, авто замын дагуу ойн зурвас байгуулах арга хэмжээ авах
- "Ногоон хэрэм" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд олон нийтийг оролцуулж, бүс нутгийн байгаль цаг уурын нөхцөлд зохицон ургадаг тарьц суулгацыг нийлүүлэх
- Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, байнгын эргүүл ажиллуулах, түймэр унтраах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах
  - Ойн хортон шавьж, өвчинтэй биологийн болон байгальд халгүй бусад аргаар тэмцэх ажлыг өргөжүүлэх.

**Хүрэх үр дүн:** Ойн нөөцийн ашиглалт хамгаалалт сайжирч зохистой хэрэглээг бий болгоно.

### **Хөгжлийн Хоёрдугаар үе шат (2013-2021 он)**

**Тэргүүлэх зорилт:** Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх менежментийг шинэ түвшинд гаргана.

### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Ойг түймэр, хөнөөлт шавьжийн аюулаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх чадавхийг бэхжүүлэх, хангах, ойг байгалийн жамаар ургах нөхцлийг бүрдүүлэх
- Ойг түймрээс хамгаалах эрх зүй, эдийн засгийн үндсийг боловсронгуй болгох
- Ойн экологийн тэнцвэрт байдал, нөхөн ургах нөхцөлд сөрөг нөлөө үзүүлэхгүй мод бэлтгэлийн шинэ технологийг ой, ургамалжилтын онцлогт тохируулан боловсруулж нэвтрүүлэх
- Ой нөхөн сэргээлтийн ажлыг дэмжин эдийн засгийн хөшүүрэг хэрэглэн урамшуулж энэ талын сургалт, сурталчилгааны ажлыг сайжруулна.
- Ойн нөөцийн ашиглалтыг сайжруулан, дотоодын мод, модон бүтээгдэхүүний хэрэгцээг хангах
- Элсний нүүлт, цөлжилтийг сааруулах, гол, горхи, булаг шандны эхийг хамгаалах, төв, суурин газрын орчны бохирдлыг бууруулах зорилгоор ойжуулах ажлыг эрчимжүүлэх

**Хүрэх үр дүн:** Ойн нөөцийн хэвийн ургах нөхцөл бүрэлдэж экологийн тэнцэлд нөлөөлөх нөлөө нэмэгдэнэ.

### **3.5.Биологийн төрөл зүйлийг хамгаалал, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн.**

**Өнөөгийн байдал:** Өнгөрсөн зуунд 70-аад жилийн туршид Ерөө, Хараа, Шарын голын савд мод бэлтгэл, барилгын материалын үйлдвэрлэлийг эрхэлэний үр дүнд шилмүүст ой ихэд сүйтгэгдэж амьтны аймгийн биологийн төрөл зүйл нь ой ба өвслөг ургамлын бүрхэвчтэйгээ уялдаатайгаар ихээхэн өөрчлөлтөд орсон билээ. Үүнээс үүдэж ой хөвчийн том хөхтөн, жигүүрийн шувуу, ан амьтны байршилд нь өөрчлөлт орсоноор ихээхэн цөөрч алс бөглүү ойруу, зарим тохиолдолд хил амжин дайжиж байна.

#### **Хөгжлийн Нэгдүгээр үе шат (2007-2012 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Амьтаны аймгийн нөөцийн хомсдолыг хязгаарлаж, тэдгээрийг хамгаалах, нөхөн үржих, зүй зохистой ашиглах нөхцлийг бүрдүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Ховор, нэн ховор, амьтны тогтвортой байдал, хэвийн өсөлтийг хангахтай холбогдсон бодлогыг шинэчлэн боловсруулна.
- Ан амьтныг хамгаалах хууль, эрх зүйн хүрээнд тодорхой хугацаанд агнахыг хориглосон ан амьтадын нэрс, байршлыг заасан орон нутгийн тогтоол шийдвэрийг гаргах.
- Эдийн засгийн таатай орчныг бүрдүүлж нэн ховор, ховор ан амьтадын тархац нутаг, нөөцийн судалгаа хийж зориудн аргаар үржүүлэх талаар Шинжлэх ухааны байгууллагууд болон гадаад дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах арга хэмжээг зохион байгуулна.
- Орон нутгийн байгаль хамгаалах төрийн бус байгууллагуудын чадавхийг дээшлүүлнэ.
- **Байнгийн хорооны найруулга.....**Баавгай, Хүдэр болон үслэг ховордсон тоо толгойтой амьтныг агнах ажлыг аймгийн нутаг дэвсгэр дээр хориглох.
- **Байнгийн хорооны найруулга .....**Хонин нуга дахь МУИС-ийн биологийн судалгааны төвийн үйл ажиллагааг аймаг, орон нутгийн төсвөөс дэмжлэгэ үзүүлж биологийн элдэв янз хэлбэрийг хамгаалах улс, улс аймгийн хэмжээний тусгай хамгаалалттай төв болгох.
- Хуш, Жодоо, гацуур зэрэг хөвч ой үүсгэхэд чухал үүрэгтэй модыг үржүүлэх, шилжүүлэх суулгах арга хэмжээг зохион байгуулах.

**Хүрэх үр дүн:** Устах аюулд орсон, болон аж ахуйн ач холбогдол бүхий амьтадыг зориудаар өсгөн үржүүлэх ажилд ахиц гарна.

**Тэргүүлэх зорилт 2.** Ургамлын аймгийн нөөцийн хомсдолыг хязгаарлаж, тэдгээрийн байгалийн жамаар нөхөн сэргэх, тогтвортой ашиглах нөхцлийг бүрдүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Нэн ховор, ховор ургамлыг хамгаалах, нөхөн сэргэх, зохистой ашиглахтай холбогдсон бодлого боловсруулна.



- Ургамлын аймгийг хамгаалах хууль, эрх зүйн хүрээнд тодорхой хугацаанд бэлтгэж түүхийг хориглох нэн ховор, ховор ургамлын төрөл зүйлийн жагсаалтыг батлана.
- Аймгийн ургамалын аймгийн нөөц, байршил нутгийг тогтоон тэдгээрийг хамгаалахад зориулагдсан дотоод, гадаадын хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхүйц олон улсын байгууллага, хандивлагч орон, хувь хүний урт, богино хугацааны төслийг үр ашигтай хэрэгжүүлэх дэмжлэг үзүүлнэ.
- Орон нутгийн байгаль хамгаалах төрийн бус байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх

**Хүрэх үр дүн:** Ховордсон болон ашигт ургамлыг тарьж ургуулах ажилд ахиц гарна.

### **Хоёрдугаар үе шат (2013-2021 он )**

**Тэргүүлэх зорилт.** Аймгийн биологийн төрөлийн зүйлийн ашиглалт, хамгаалалыг сайжруулж, тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг өргөтгөнө.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийн хөгжлийн горим, зүй тогтлыг танин мэдэх, байгалийн нөөц, баялгийг үнэлж тодорхойлох, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээрх судалгааг өргөтгөж, мэдээллийн сан бүрдүүлнэ.
- Байгаль орчны доройтол, биологийн төрөл зүйлийн хомсдлыг хязгаарлан зогсоох, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх ач холбогдол бүхий газар нутгийг УТХГН-ийн сүлжээнд хамруулна.
- Байгаль экологийн өвөрмөц тогтоцтой, ховор амьтан, ургамлын нөөцтэй Хонин нуга, Онги шарланга, Бүтээлийн нуруу зэрэг газруудыг улсын болон орон нутгийн хамгаалалтанд оруулах ажлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- Аймгийн ургамалын аймгийн нөөц, байршил нутгийг тогтоон тэдгээрийг хамгаалахад зориулагдсан дотоод, гадаадын хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхүйц олон улсын байгууллага, хандивлагч орон, хувь, хүний урт, богино хугацааны төслийг үр ашигтай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Орон нутгийн байгаль хамгаалах төрийн бус байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх.
- Тайга, ойн жижиг хөхтөн, үслэг анг хамгаалах, өсж үржих чөлөөт орчныг бүрдүүлэхэд анхаарах.
- Аймгийн нутаг дэвсгэрт сүүлийн үед ховордож байгаа ан амьтны тооллогыг зохион байгуулж тэдгээрийг агнахыг хориглож шинэжилэх ухааны үндэслэлтэй өсгөн үржүүлэх бодлого баримтлах
- Ойн хортонтой тэмцэх, ойн хулсан бүрхэвчийг сайжруулах зорилгоор ойн шоргоолжны үүрийг хамгаалах, олшруулах.
- Самар цохих түүх ажлыг 4 жилийн хугацаагаар хориглож, хуш модыг хамгаалах арга хэмжээ авах.
- Ойн дагалт баялаг болох жимс жимсгэнэ, мөөг, эмийн түгээмэл тархсан ургамлыг түүх, ашиглах ажлыг сум, орон нутагт журамлах зорилгоор хяналт тавих ажлыг эрчимжүүлэх.
- Хонин нугын МУИС-ийн судалгааны төвийг аймгийн дэмжлэг тусламжтайгаар “Хөвч ойн экосистемийн биологийн эрдэм шинжилгээ, сургалт сурталчилгааны олон улсын төв” болгох асуудлыг хамтран боловсруулах, Засгийн газрын дэмжлэг авах санал оруулах.
- Аймгийн байгалийн унаган төрх, үзэсгэлэнт тогтцуудыг түшиглэн байгалийн хүрээлэн байгуулах ажилтай нягт уялдуулна.
- Биологийн төрөлд зүйлийн холбогдлын талаарх хүн амын мэдлэг, мэдээллийг сайжруулахад чиглэсэн сургалт, сурталчилгааг өргөтгөнө.
- Тусгай хамгаалалттай газар нутаг дахь ховор ан амьтан, ургамлын судалгаа гаргаж, хэвийн өсч үржих нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээг өргөтгөнө.

**Хүрэх үр дүн:** Аймгийн хэмжээнд тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ бүрэлдэн биологийн төрөл зүйлийн ашиглалт хамгаалт эрс сайжирна.

### **3.6. Байгалийн гамшгаас сэргийлэх, хохирлыг бууруулах талаар**

**Өнөөгийн байдал:** Зуд, хүчтэй салхи, цасан болон шороон шуурга, мөндөр, хүйтэн бороо орох, үер, ган, хүн мал ургамал, амьтны гоц халдварт өвчин, ой хээрийн түймэр зэрэг байгалийн гэнэтийн үзэгдэл, гамшиг үе үе тохиолдож мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл болон эдийн засаг, байгаль орчинд багагүй хохирол учруулсаар байна.

Байгалийн гамшгийг судлах, урьдчилан сэргийлэх, нэгэнт тохиолдсон гамшигтай тэмцэх, учирсан хохиролыг нь багасгах чиглэлээр зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээ авдаг боловч гамшгийн хохирлын хэмжээ тууштай буурахгүй байна.

#### **Хөгжлийн Нэгдүгээр үе шат (2007-2012 он)**

**Тэргүүлэх зорилт.** Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг арилгах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох эрх зүй, эдийн засаг, удирдлагын бүтцийн шинэчлэлийг хийж, чадавхийг бэхжүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Монгол орны уур амьсгалын өөрчлөлтийн өнөөгийн болон ирээдүйн төлөв байдал, түүнээс эдийн засаг, нийгэм, байгаль орчинд нөлөөлөх байдлыг тодорхойлж бодлого боловсруулан хэрэгжүүлэх
- Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг нэмэгдүүлэх
- Цаг уур, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны төлөв байдал, байгалийн гамшгийн мэдээллийн төвийг байгуулан чадавхийг бэхжүүлэх
- Аюулт үзэгдлийг урьдчилан тооцоолох, олон нийтэд мэдээлэх чиглэлээр аймаг, сумын түвшинд цаг уурын албадын чадавхийг дээшлүүлэх
- Ой, ургамлын хортон шавьжийн голомт, нүүдэл, хүн, мал амьтны гоц халдварт өвчний аюул гамшгаас урьдчилан сэргийлэх, тэдгээртэй тэмцэх хор уршгийг арилгах, ургамал, хорио цээр, хүн, мал эмнэлгийн албаны чадавхийг дээшлүүлэх
- Байгалийн гамшиг тохиолдсон үед хохирлыг зохих хэмжээгээр нөхөх зорилгоор байгууллага, иргэдийг эд хөрөнгийн болон бусад, амь насны даатгалд хамруулах ажлыг сайжруулах
- Нутгийн иргэдэд түшиглэсэн гамшгийн менежментийг боловсронгуй болгох, ард иргэдийг аюулгүй амьдрах арга ухаанд сургаж дадлагажуулах, эрсдлийг бууруулах
- Гамшгийг урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх тогтолцоог бий болгох хиймэл дагуулын сүлжээтэй шууд холбогдох

**Хүрэх үр дүн:** Аймгийн хэмжээнд байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хохирлыг бууруулах, шуурхай арилгах чадавхи дээшилнэ.

#### **Хөгжлийн Хоёрдугаар үе шат (2013-2021 он)**

**Тэргүүлэх зорилт.** Байгаль, цаг уурын онц аюултай үзэгдэгдлээс урьдчилан сэргийлэх оновчтой тогтолцоо бүрдүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг өмнөх жилүүдээс тодорхой хувиар нэмэгдүүлэх
- Гамшгаас сэргийлэх, хор хөнөөлийг бууруулах, гамшигтай тэмцэх талаарх менежментийг сайжруулах
- Байгалийн гамшигтай тэмцэх өвс тэжээл, хүнс, эмнэлгийн анхны тусламжийн байнгын нөөцтэй болох
- Байгалийн гамшгийн талаарх хун амын мэдлэгийг байнга дээшлүүлэх зорилгоор жил бүр тусгай сургалт зохион байгуулах, эн түрүүнд шаардлагатай багаж хэрэгслээр хангах ажлыг тогтмолжуулах
- Байгаль цаг уурын гамшгийн аюулыг бууруулах, болзошгүй гамшиг ослын аюулаас урьдчилан сэргийлэх нөөц бололцоо техникийн хүчин чадлыг бий болгох

- Мэргэжлийн байгууллагын ур чавдар, техник хэрэгсэлийг сайжруулах

**Хүрэх үр дүн:** Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хохирлыг бууруулах, шуурхай арилгах бүсийн хэмжээний оновчтой тогтолцоо бүрдсэн байна.

**Дөрөв.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нээлттэй засаглалын бодлого**

**Өнөөгийн байдал:** Хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалыг Сэлэнгэ аймагт Засаг захиргааны нэгж 17 сум, 49 баг дахь нутгийн захиргааны байгууллага хэрэгжүүлэн ажиллаж байна.

Бүсчилсэн хөгжлийн төрийн бодлого, Монгол Улсын “Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийг иш үндэс болгон аймгийн төр захиргааны байгууллага дээрхи засаг захиргааны нэгжүүдийг бүсчилэн хөгжүүлэх бодлого баримталдаг. Энэхүү бодлогын хүрээнд сумдыг нутаг дэвсгэрийн байршил, хүн ам, байгалийн баялаг, эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдал, хэтийн төлвийг харгалзан дараах 5 бүсэд хуваан бүс тус бүрийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тогтоосон. / хавсралт зураг №9/Үүнд:

Бүсийн нэр	Бүсийн сумд	Бүсийн төв	Хөгжлийн тэргүүлэх чиглэл
Билчирийн бүс	1.Сүхбаатар	Сүхбаатар	Аж үйлдвэр, дэд бүтэц, худалдаа үйлчилгээ, эдийн засгийн чөлөөт бүс, бөөний худалдааны сүлжээ, эрчимжсэн мал аж ахуй, усалгаатай газар тариалан, ногооны аж ахуй, аялал жуулчлал, загасны аж ахуй, дээд болон мэргэжлийн тусгай дунд боловсрол олгох сургуулиуд, арилжааны банкууд болон банк бус санхүүгийн байгууллагуудыг хөгжүүлэх
	2.Алтанбулаг		
	3.Шаамар		
Ерөөгийн бүс	1.Ерөө	Ерөө	Уул уурхайн олборлох боловсруулах үйлдвэр, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, усалгаатай газар тариалан, үр тарианы аж ахуй, модон эдлэлийн үйлдвэрлэл, бөөний худалдааны сүлжээ, байгалийн дагалт баялаг ашиглах, аялал жуулчлалыг хөгжүүлэх
	2.Хүдэр		
	3.Жавхлант		
Сэлэнгийн бүс	1.Цагааннуур	Цагааннуур	Усалгаатай газар тариалан, Үр тарианы аж ахуй, эрчимжсэн мал аж ахуй, уул уурхайн үйлдвэрлэл, байгалийн аялал жуулчлал, амралт сувилал, малын үржлийн генофондын аж ахуй, уул уурхайн олборлох боловсруулах үйлдвэр, байгалийн дагалдах баялаг ашиглах,
	2.Түшиг		
	3.Зүүнбүрэн		
Орхоны бүс	1.Сайхан	Сайхан	Барилга, барилгын материалын үйлдвэрлэл, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, усалгаатай газар тариалан, генофондын аж ахуй, уул уурхайн олборлох боловсруулах үйлдвэр, байгалийн дагалт баялаг ашиглах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, бөөний худалдааны сүлжээ, тусгай мэргэжлийн боловсрол олгох
	2.Орхон		
	3.Баруунбүрэн		
	4.Сант 5.Хушаат		
Хараагийн бүс	1.Мандал	Зүүнхараа	Эрчимжсэн мал аж ахуй, усалгаатай газар тариалан, ногооны аж ахуй, уул уурхайн

	2.Баянгол		олборлох боловсруулах үйлдвэр, гэр ахуйн модон эдлэлийн үйлдвэрлэл, байгалийн дагалт баялаг ашиглах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, бөөний худалдааны сүлжээ, арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллагуудыг хөгжүүлэх, тусгай мэргэжлийн боловсрол олгох
--	-----------	--	---

Засаглалын орон нутаг дахь бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэгч дээрхи засаг захиргааны нэгжүүдэд 3.9 мянга орчим төрийн албан хаагчид ажиллаж аймгийн 100-гаад мянган иргэдэд 144 багцийн 230 төрлийн төрийн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Сумдыг бүсчлэн хөгжүүлэх аймгийн төр, захиргааны бодлого, шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллага, төрийн албан хаагчдын үйл ажиллагааны хүртээмжтэй, тогтвортой мэргэшсэн, тасралтгүй залгамж чанар зэрэг өнөөгийн байдал нь дэлхий дахины хөгжлийн чиг хандлагад тэр бүр зохицож чадахгүй байгаа нь амьдралаас тодорхой болж байна. Ийнхүү мэдлэгт суурилсан хүрэх үр дүнг баримжаалсан үр нөлөө бүхий захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх дэлхий дахины хөгжлийн хандлагатай уялдуулсан аймаг, орон нутгийн засаглалын хэтийн бодлого төлөвлөлт зүй ёсоор шаардагдаж байгаа юм.

### **Хөгжлийн Нэгдүгээр үе шат (2007-2012 он)**

**Тэргүүлэх зорилт 1:**Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийг иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах, хялбаршуулах чиглэлээр бэхжүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэдэг төрийн захиргааны анхан шатны нэгж баг, тосгоныг бэхжүүлэх
- Сумдыг бүсчлэн хөгжүүлж, бүлэг суурингийн тогтолцоог бүрдүүлэн зах зээлийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх
- Сумдын бүсчлэлийн өнөөгийн бүтцэд дараах зарим өөрчлөлт оруулж мөрдөх  
Үүнд:

1. Сүхбаатарын бүсийг Бэлчирийн бүс
- 2.Ерөөгийн бүсийг Ерөө голын бүс
- 3.Цагааннуурын бүсийг Сэлэнгийн бүс
- 4.Сайханы бүсийг Орхоны бүс
- 5.Мандалын бүсийг Хараагийн бүс

Б.Газар нутгийн байршил бүсүүдийн үйл ажиллагаанд оролцох боломжийг харгалзан Хушаат сумыг Орхон голын сав нутгийн бүсэд хамруулах.

- Хүний нөөцийн бодлого төлөвлөлт хэрэгжилтийг засаг захиргааны анхан шатны нэгжид төвлөрүүлэх чиглэл барих
- Төсвийн бүрдүүлэлт, зарцуулалтын эрх мэдэл, хуваарилалтыг оновчтой болгож түүнд тохирсон хариуцлагын механизмыг бий болгох

**Хүрэх үр дүн:** Засаг захиргааны нэгж сум, багаас иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ хүнд суртал чирэгдэлгүй болно.

**Тэргүүлэх зорилт 2:** Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд үр дүнг баримжаалсан удирдлагыг нэвтрүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх стратеги:**

- Нутгийн захиргааны бүх шатны байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг аймаг, орон нутаг, хөгжлийн үе шатны онцлогтой уялдуулан боловсронгуй болгох
- Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг ил тод, хяналттай байлгах чиглэл баримтлах
- Засаглалын бодлого, шийдвэрийн хэрэгжилтэнд тавих хяналтыг сайжруулах
- Шийдвэр боловсруулах үйл явцад иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх
- Иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж төр, иргэний нийгмийн түншлэлийг бэхжүүлэх

- Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд мэдээллийн технологийг бүрэн нэвтрүүлэх

**Хүрэх үр дүн:**Нутгийн захиргааны байгууллагуудын чадавхи дээшилж төрийн үйлчилгээний үр нөлөө сайжирна.

**Тэргүүлэх зорилт 3:**Төрийн албан хаагчдын мэргэшил, ур чадвар, ажиллах нөхцлийг сайжруулна.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Мэдлэгт суурилсан мэргэшлийг төрийн албан хаагчдад эзэмшүүлэх
- Төрийн албаны нөөцийн нөхөн бүрдүүлэлт төлөвлөлтийг аймаг, сум, багаар төлөвлөж хэрэгжүүлэх
- Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг цаг үе, нийгмийн эрэлт шаардлагад нийцүүлэх
- Төрийн албан хаагчдын ажиллах нөхцлийг нийгмийн хөгжилтэй уялдуулан сайжруулах

**Хүрэх үр дүн:**Төрийн албан хаагчдын мэргэшил, ур чадвар дээшилж төрийн үйлчилгээний үр нөлөө сайжирна.

**Тэргүүлэх зорилт 4:** Гэмт хэрэг зөрчлийг бууруулах, иргэдийн амар тайван амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор иргэдийн хууль, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлыг тогмолжуулна.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг өргөжүүлж, үр нөлөөг дээшлүүлэх
- Хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг хүний эрх, эрх чөлөөг хангахад чиглүүлэн үр дүнтэй зохион байгуулах
- Нийгмийн дэг журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх цагдаагийн ажилтны ажиллах, амьдрах нөхцлийг сайжруулах зорилгоор кабоны системийг бүрэн нэвтрүүлэх
- Өмчийн эсрэг гэмт үйлдэл, түүний дотор малын хулгайн эсрэг нутгийн захиргаа, хууль хяналтын байгууллагууд, иргэдийн хамтын үйл ажиллагааг идэвхжүүлэх

**Хүрэх үр дүн:** Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дээшилж гэмт хэрэг, зөрчил буурна.

### **Хөгжлийн Хоёрдугаар үе шат (2013-2021 он)**

**Тэргүүлэх зорилт 1:** Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн бие даасан хөгжлийг хангана.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг иргэдийн санал, газар зүйн байршил, хүн амын тоо, эдийн засгийн чадавхийг харгалзан боловсронгуй болгоно.
- Өөрийгөө тэтгэх эдийн засаг, нийгмийн үйлчилгээний стандартыг тогтоох замаар улсын загвар аймаг, сум, баг болох хөдөлгөөнийг өрнүүлж үр дүнд хүрэх
- Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг орон нутгийн хөгжлийн асуудлыг бие даан шийдвэрлэх чадвартай болгож хөгжүүлэх
- Иргэн бүрт төр, бизнесийн үйлчилгээг эрх тэгш, энгийн хялбар шуурхай байдлаар хүргэх
- Орон нутгийн төсөв, санхүүгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх
- Байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах талларх орон нутгийн эрх мэдэл, үүрэг хариуцлагыг бэхжүүлж тодорхой болгон хэрэгжүүлэх

**Хүрэх үр дүн:** Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн бие даан хөгжих боломж бүрдэж эдийн засгийн чадавхи сайжирна.

**Тэргүүлэх зорилт 2:** Нутгийн захиргааны байгууллагыг суралцагч байгууллага болгон хөгжүүлж мэдлэгт суурилсан мэргэшсэн захиргааны байгууллага болгон бэхжүүлнэ.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Аймгийн хөгжлийн бодлогыг аймаг, орон нутгийн онцлог, дэлхий нийтийн хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлэх
- Хүний хөгжлийн хангах, гэр бүл, айл өрхийн амьдралын таатай орчинг бүрдүүлэхэд нутгийн захиргааны байгууллагын бодлого, үйл ажиллагааг чиглүүлэх
- Нутгийн захиргаа, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхийг хангах зарчмыг баримтлах
- Мэдээлэл харилцаа холбооны технологид суурилсан захиргааны удирдлагын “Сэлэнгэ загвар” бий болгох
- Нутгийн захиргааны байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээг боловсронгуй болгож төрийн үйлчилгээний 70-аас доошгүй хувийг онлайн хэлбэрт шилжүүлэх
- Нутгийн захиргааны болон өөрөө удирдах ёсны байгууллагуудын өөрчлөлт, шинэчлэлтийг эрчимжүүлж, менежментийг сайжруулах

**Хүрэх үр дүн:** Нутгийн захиргааны бүх шатны байгууллагууд мэдлэг, хүрэх үр дүнд суурилсан мэргэшсэн захиргааны байгууллага болж бэхжинэ.

**Тэргүүлэх зорилт 3:** Иргэдийг орон нутаг, гэр бүл, ажлын байр, нийгэм, хамт олны дунд амар тайван байх нийгмийн орчинг бүрдүүлнэ.

**Хэрэгжүүлэх стратеги:**

- Хууль, эрх зүйн хүссэн мэдээлэл, мэдлэгийг шаардлагатай цаг үед шуурхай авдаг арга хэлбэрийг нэвтрүүлэх
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх
- Хүний эрх зөрчигдөх шалтгаан нөхцлийг судалж арилгах арга хэмжээ авах
- Нийгмийн дэг журам сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд цахим мэдээллийн сүлжээ бий болгох

#### **4.2. Гадаад харилцааны хөгжлийн үндсэн чиглэл, хүрэх үр дүн**

**Өнөөгийн байдал:** Аймгийн Засаг дарга үйл ажиллагааны хөтөлбөртөө “Аймгийн нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн гадаад, харилцаа, хамтын ажиллагааны бодлогыг хэрэгжүүлнэ” гэсэн зорилт тавин ажиллаж байна. Энэ зорилтоо ханган биелүүлэх үүднээс дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээд байна. Үүнд:

-Аймаг, орон нутгаа сурталчлах, гадаад харилцаагаа өргөтгөх үүднээс “Сэлэнгэ аймаг” вэб хуудсыг нээн ажиллуулж аймгийн танилцуулгыг англи, монгол хэл дээр байршуулан жил бүр шинэ мэдээ, мэдээллээр баяжуулан ажиллаж байна.

-Зүүн Хойд Азийн бүс нутгийн Засаг захиргааны холбооны гишүүн байгууллагын хувьд үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, холбооноос зохион байгуулагддаг уулзалт, ярилцлага, семинар, сургалт зөвлөлгөөнд нийт 12 удаагийн ажил, арга хэмжээнд 47 хүн хамруулсан нь үр дүнгээ өгч бизнесийн хүрээ тэлж, төрийн албан хаагчийн мэдлэг, дадлага, туршлагыг арвижуулсан чухал арга хэмжээ болсоор ирлээ.

Түүнчлэн тус холбооноос эрхлэн гаргадаг “NEAR News” сэтгүүл, мөн гишүүн 40 мужийн 6 орны хэл дээр гаргасан вэб сайтанд аймгийнхаа танилцуулга, түүх, соёл, эдийн засгийн үзүүлэлт, зурагт хуудас болон холбогдох мэдээ, мэдээллийг байнга тавьж сурталчилж байна.

-ОХУ-ын Буриад улстай байгуулсан гэрээг шинэ ажил, арга хэмжээгээр баяжуулан тус улсын зарим яамд, аймгуудтай хамтын ажиллагаа, хил орчмын худалдаа, бараа солилцох шинэчилсэн гэрээ байгуулж ажилласны зэрэгцээ хамтарсан уулзалт, зөвлөлгөөн, онол, практикийн бага хурлыг зохион байгуулах, харилцан туршлага солилцох зэрэг ажлуудыг тогтмол хийж хэвшээд байна. Тухайлбал Улаан-Үд хотын Сүрьеэгийн эмнэлэгийн өндөр мэргэжлийн эмч нар оношлох, эмчлэх үзлэгийг бүх суманд хийх, манай аймгаас 10 оюутанг Буриадын их, дээд сургуульд суралцуулах, хаврын тариалалтын үрийн буудай, жимсний модны суулгац, тарьц нийлүүлэх зэрэг ажлуудыг дурдаж болох юм.

-Монгол-ОХУ-ын Засгийн газар хоорондын комиссын Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны дэд комиссын хуралдаанд тогтмол оролцож хуралдаанаас гарсан шийдвэрийг өөрийн аймагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ирлээ.

-ОХУ-ын Буриад улстай хамтран “Эв мод”-ны наадмыг жил бүр 2 талын нутаг дэвсгэрт ээлжлэн зохион байгуулж байна.

-Япон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА-ийн сайн дурын гишүүн ажиллуулах хүсэлт гаргасны тодорхой салбаруудад мэргэжилтэнг урьж ажиллуулж байна.

**Тэргүүлэх зорилт:** Монгол улсын олон улсын хамтын нийгэмлэгт эзлэх байр суурийг бэхжүүлнэ гэсэн Засгийн газрын зорилтыг үндэс суурь болгон Сэлэнгэ аймаг нь улс орнуудтай гадаад харилцааны бодлогын уламжлал болон залгамж чанарыг хадгалан түншлэлийн харилцааг бүх талаар хөгжүүлэн бэхжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар аймгийн эдийн засгийн өсөлтийг тогтвортой болгож, орон нутгаа хөгжүүлнэ.

**Хэрэгжүүлэх стратеги:**

**Төрийн байгууллагын бодлогын түвшинд:**

- Аймгийн түүх соёл, өнөөгийн байдал, нийгэм, эдийн засгийн давуу тал, онцлог, нөөц, боломжийн талаар гадаад ертөнцөд сурталчлах ажлыг зохион байгуулах, энэ талаар хэтийн бодлого, чиглэл барьж ажиллах
- Оюуны гадаад хөрөнгө оруулалтыг дэмжиж, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг өргөн ашиглах үүднээс төрийн албан хаагч, бизнес эрхлэгчдийг гадаад орнуудад сургах, мэргэшүүлэх, шаардлагатай гадаад мэргэжилтэнг авч ажиллуулах замаар орон нутгаа хөгжүүлэх бодлогыг баримтлах
- Хоёр талын харилцааг худалдаа, эдийн засаг, бизнес хөрөнгө, оруулалтын агуулгаар баяжуулж тодорхой улс, орнуудтай шинээр харилцаа тогтоох, богино болон урт хугацаагаар гэрээ байгуулах, харилцах хөтөлбөр боловсруулан ажиллах арга хэмжээг шат дараатай авах
- Бүс нутаг, хил орчмын худалдаа, эдийн засаг, шинжлэх ухааны хамтын ажиллагааны комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд өөрийн орон нутгийн байр суурийг илэрхийлж оролцож байх
- Зүүн хойд Азийн бүс нутгийн Засаг захиргаадын холбооны гишүүн орнуудад өөрийн аймгийн төлөөлөгч ажиллуулах
- Хоёр талын хилийг хялбаршуулах зорилгоор “Алтанбулаг-Хиагт”-ын шалган нэвтрүүлэх боомтын үйл ажиллагааг 24 цагаар ажиллуулдаг болгох
- Хоёр улсын харилцааг өргөжүүлэх зорилгоор 1994 онд ОХУ, Монгол улсын Засгийн газрын хооронд байгуулсан гэрээнд “хилийн бүсийн статусыг хилийн субъектын нийт нутаг дэвсгэрт хамруулах” гэсэн асуудлыг нэмэлт өөрчлөлтөөр тусгуулах асуудлыг эрх бүхий байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх

**Нийгмийн бодлогын түвшинд :**

- Хөрш болон бусад орны төрийн болон хувийн хэвшлийн бага, дунд, их, дээд сургууль, лицей сургууль хамтран байгуулах санал санаачилгыг дэмжих
- Гадаадын их, дээд сургуулиудад боловсон хүчнийг бэлтгэх, багш, арга зүйчдийг мэргэжил дээшлүүлэх талаар хамтран ажиллах
- Тодорхой салбаруудаар судалгаа, эрдэм шинжилгээний хамтарсан экспедици байгуулах
- Гадаадад ажиллах хүч гаргах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр бодлого боловсруулан ажиллах
- Нийгмийн хамгааллын чиглэлээр гадаад орнуудын төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх
- Шууд харилцаатай улсын хот, мужуудтай соёл, урлаг, спортын хамтын ажиллагааг өргөжүүлэх

**Эдийн засгийн бодлогын түвшинд:**

- Гадаадын хөрөнгө оруулалтаар малын болон ургамлын гаралтай түүхий эд боловсруулах жижиг дунд үйлдвэр байгуулах, бүс нутагт худалдааны төвүүдийг нээх, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг нийлүүлэх байгууллагуудтай хамтран ажиллах

- ОХУ, Буриад улсын банк, санхүүгийн байгууллагуудын хооронд шууд харилцаа тогтоох, байгууллага, аж ахуйн нэгж, бизнесменүүдийн худалдааны болон бусад төлбөр тооцоог шууд хийдэг механизмыг бүрдүүлэх
- Улаан-Овоогийн нүүрсний уурхайг ашиглалтанд оруулах замаар Зэлтэр хилийн боомтыг нээн байнгын ажиллагаатай болгох
- Ашигт малтмалын хайгуул олборолтыг гадаадын хөрөнгө оруулагчтай хамтран ашиглах
- Шууд харилцаат муж, хотуудын үйлдвэрлэл үйлчилгээний салбартай хамтран ажиллах гэрээ хэлцэл хийж хөрөнгө оруулах, техник технологийн дэмжлэг авч үйлдвэрлэл үйлчилгээний салбарыг орон нутагтаа ажилуулах, өөрийн бүтээгдэхүүний борлуулах цэг, салбарыг тухайн хот, мужид ажиллуулах
- Үржлийн сайн үүлдрийн мал, амьтан импортлох, экспортлох
- Үрийн болон хүнсний улаан буудайн хамтарсан аж ахуй байгуулах
- Хамтарсан аялал жуулчлалыг хөгжүүлэх үүднээс нэгдсэн сүлжээнд хамрагдах, харилцан мэдээлэл солилцож байх

#### **4.3.Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын үндсэн чиглэл**

Энэхүү хөтөлбөрийг сүүлийн 16 жилийн аймгийн эдийн засаг нийгмийн хөгжлийн судалгаан дээр үндэслэн боловсруулав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа орон нутгийн сонгуулийн 4 удаагийн бүрэн эрхийн хугацаанд үргэлжилнэ гэж үзсэн бөгөөд аймаг, сумдын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрүүд болон аймаг сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж санхүүгийн эх үүсвэр, хөрөнгө оруулалтын тооцоотой нь уялдуулж хөтөлбөрийн хэрэгжилтийг баталгаажуулж байнгын удирдлага, зохион байгуулалтаар хангах, түүний хэрэгжих дотоод, гадаад таатай орчныг бүрдүүлэх, олон нийтийн оролцоог өргөтгөх нь Сэлэнгэ аймгийн хөгжлийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх үндсэн нөхцөл мөн. Үүнд:

- Бүсийн зөвлөл, аймгийн ИТХ, Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааг хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр оновчтой уялдуулах;
- Засгийн газрын түвшинд яамд, агентлагуудын энэ талын хамтын ажиллагааг оновчтой уялдуулан зохицуулах;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар аймгийн Засаг даргын Тамгын газар, бүсийн зөвлөл, хувийн хэвшил, төрийн бус байгууллагууд, иргэдийн оролцоог хөхүүлэн дэмжих оновчтой арга хэрэгсэл, механизмыг бий болгох;
- Улсын жил жилийн төсөв, дунд хугацааны төлөвлөлтийн бусад баримт бичгүүд, эдийн засаг, нийгмийн салбар бүрээр боловсруулан хэрэгжүүлэх хөтөлбөр, төслүүдийг аймгийн хөгжлийн энэхүү хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтууд, хэрэгжүүлэх үйл ажиллагаатай нягт уялдуулах;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр харьцангуй богино хугацааны төрөлжсөн хөтөлбөр, мастер төлөвлөгөө төслүүдийг боловсруулан хэрэгжүүлэх;
- Макро түвшний нэгжүүдийн үйл ажиллагааг энэхүү хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх чиглэлтэй оновчтой уялдуулах;
- Хувийн хэвшлийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд эдийн засгийн таатай орчин бий болгох;
- Статистикийн бүртгэл, мэдээллийн үзүүлэлтийг хөтөлбөр тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөхөд нийцэх чиглэлээр боловсронгуй болгох
- Хөтөлбөрт дэвшүүлсэн тэргүүлэх зорилтууд, тэдгээрийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл стратегийг улс төрийн намууд сонгуулийн мөрийн хөтөлбөртөө тусган хэрэгжүүлж байх;
- Хөтөлбөрт дэвшүүлсэн тэргүүлэх зорилтуудын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж, давуу талуудаа бататган, сул талуудаа саармагжуулан, алдаа дутагдлаа засч байх;



#### **4.4. Эдийн засгийн өсөлтийг хангах үндсэн арга, хэрэгсэл**

- Аймгийн санхүү эдийн засгийн нөөц боломжид тулгуулсан эх орны зах зээлийн дутууг нөхөх, экспортын чиглэлтэй үйлдвэрлэлийг түлхүү дэмжих;
- Хүн ардынхаа хөдөлмөрч зан чанар, оюуны чадавхид тулгуурлан хөгжих бодлого баримталж, боловсролын салбарт тэргүүлэх ач холбогдол өгч өндөр мэргэжлийн боловсон хүчин, инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх нөхцлийг бүрдүүлэх
- Эдийн засгийн өсөлтийг өндөр технологид суурилсан уул уурхайн болон боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын эрчимтэй өсөлтөөр хангах чиглэл баримтлах;
- Алтанбулагийн худалдааны чөлөөт бүсийн үйл ажиллагааг жигдэрүүлж гадаад хөрөнгө оруулалтыг татсан олон улсын худалдааны томоохон төв болгон хөгжих нөхцөл бүрдүүлэх
- Гадаад хөрөнгө оруулалт өндөр технологи нутагшуулахыг бүх талаар дэмжих
- Үр ашигтай хөрөнгө оруулалт хийж эдийн засгийн өсөлтөнд хувь нэмэр оруулахыг хөхүүлэн дэмжиж дотоодын хуримтлалыг нэмэгдүүлж түүнийг оновчтой төвлөрүүлэн ашиглах механизмыг бий болгох;
- Санхүү, үнэт цаас, даатгал, хөдөлмөрийн зах зээлийг хөгжүүлэх;

#### **4.5. Олон нийтийн оролцоо**

- Шийдвэр гаргах бүх түвшинд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ил тод нээлттэй засаглалын бодлогыг хэвшүүлэн төрийн үйлчилгээг сайжруулах;
- Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, иргэдийг өөрсөдтэй нь холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэхэд өргөнөөр оролцуулж тэдгээрийн эрх ашгийг тууштай хамгаалах;
- Аймгийн хүн амын 50 гаруй хувийг эзэлдэг эмэгтэйчүүдийн нийгмийн идэвхи, хөгжилд оролцох хүсэл эрмэллэлийг идэвхтэй дэмжих;
- Аймгийнхаа тулгамдсан асуудал, нийгэм эдийн засгийн хөгжлийн зорилтуудыг шийдвэрлэхэд залуучуудыг өргөн оролцуулах оновчтой хөшүүрэг бий болгох;
- Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх асуудлаар бодлого боловсруулах, шийдвэр гаргахад бизнес эрхлэгчдийг өргөнөөр оролцуулах нөхцлийг бүрдүүлэх;
- Төрийн бус байгууллагуудын гүйцэтгэж чадах олон чиг үүргийг тэдэнд шилжүүлэх замаар төрийн байгууллагуудын орон тоо, төсөв зардлыг бууруулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагааг өргөтгөх зэрэг болно.
- Төрийн бус байгууллагын олон нийттэй харилцах давуу талыг түшиглэн нийгмийн сэтгэлгээ, эрэлт хэрэгцээг судалдаг, дүгнэлт шинжилгээ хийдэг чиг үүрэг бүхий бүтэц орон тоог бий болгох;
- Хууль тогтоомж сурталчлах, эрх зүйн сургалт явуулахад шаардагдах зардлыг нутгийн захиргааны байгууллагын жил бүрийн төсөв төлөвлөгөөнд тусгаж үр ашигтай зарцуулан сургалтын үр нөлөөг хянаж, мэдээлдэг тогтолцоог бий болгох;
- Төрийн байгууллагын боломжтой салбарт нэг цэгийн үйлчилгээ нэвтрүүлэх
- Төрийн үйлчилгээг иргэдийн хүсэлт шаардлагад нийцүүлэн явуулах зорилгоор нээлттэй хэлэлцүүлэг явуулж хэвшүүлэх;
- Төрийн байгууллагуудыг вэб хуудастай болгон, нутгийн захиргааны болон төсөвт байгууллагуудыг мэдээллийн нэгдсэн цахим сүлжээнд холбож, төрийн зарим гол үйлчилгээг электрон хэлбэрээр үзүүлж энэ хуудасаар иргэдийн санал хүсэлтийг авдаг болгох;
- Багийн ажлын албыг компьютержуулах;

- Аймгийн эдийн засаг нийгмийн гол асуудлыг аймгийн ИТХ-аар хэлэлцэхийн өмнө ард иргэдийн дунд хэлэлцүүлэг, санал асуулга явуулж, тэдний санал бодлыг өргөн тусгаж хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тэдний оролцоог нэмэгдүүлэх;
- Бүх шатны иргэдийн хурлын үйл ажиллагаанд иргэдийн оролцох боломж нөхцлийг хангах;
- Шүүх, прокурор, цагдаагийн болон мэргэжлийн хяналтын байгууллага, хамт олны үйл ажиллагааг иргэдэд ил тод, нээлттэй болгох.
- Хууль хяналт, цагдаагийн байгууллагуудын ард иргэдийн амгалан тайван амьдрах орчинг бүрдүүлэх нөхцлийг хангах.
- Хариуцлагын зарчмыг бүх шатанд өндөржүүлэх;
- Иргэн орлого олж татвар төлдөг зах зээлийн хуулийг амьдралд хэрэгжүүлэхийг иргэн бүрт хэвшүүлэх

## **Тав.Хөтөлбөрийн санхүүжилт, үр дүн, хяналт шинжилгээ үнэлгээ**

### **5.1.Эдийн засаг, нийгмийн эцсийн үндсэн үр дүн**

Сэлэнгэ аймгийн 2021 он хүртэлх хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд тус аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн тогтвортой, даац бүхий өндөр хурдацтай болсон байх бөгөөд 2021 он гэхэд 2000 оны зэрэгцүүлсэн үнээр тооцсон ДНБ 2006 оныхоос 80 гаруй хувиар өсч, боловсруулах үйлдвэрийн жин нэмэгдсэн байна. Нэг хүнд ногдох ДНБ 3,0 мянган ам доллар болж 2006 оныхоос 4,8 дахин өснө.

**Аймгийн 2006 оны ДНБ үйлдвэрлэлийг эдийн засгийн бүтцийг салбараар авч үзвэл 40.5 хувийг нь ХАА, 25 хувийг уул уурхай, аж үйлдвэр, барилга, 13 хувийг түлш эрчим хүчний, тээвэр, холбооны салбар, 21.5 хувийг худалдаа, үйлчилгээний салбар тус тус үйлдвэрлэн гаргаж байна. 2020 гэхэд уул уурхай, аж үйлдвэр, барилгын салбарын ДНБ үйлдвэрлэлд эзлэх хувийг 40 хувьд хүргэнэ.**

Аймгийн хүн ам 2021 он гэхэд 2006 оныхоос 51.3 хувь өссөн байх бөгөөд хүн амын дундаж наслалт 71.6 - д хүрч, хүний амьдралын үзүүлэлтүүд чанаржин хүний хөгжлийн индекс улсын дундаж түвшинд хүрнэ. Аймгийн 18 хүртэлх насны бүх хүмүүс 10-12 жилийн боловсролтой болсон байна.

### **5.2. Шаардагдах хөрөнгө, санхүүжүүлэх эх үүсвэр**

Сэлэнгэ аймгийн хөгжлийн хөтөлбөр нь 5 ерөнхий бүлэг, 35 дэд бүлэг буюу салбарын хөгжил, тэргүүлэх зорилт 119, тэдгээрийг хэрэгжүүлэх 817 стратеги буюу үйл ажиллагааы чиглэлээс бүрдсэн байна.

Аймгийн хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан хэрэгжүүлэх стратегийн 27.8 хувь буюу 137 үйл ажиллагааны чиглэлийг нэгдүгээр үе шат болох 2007-2012 онд улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр, 72.2 буюу 355 үйл ажиллагааны чиглэлийн аж ахуй нэгж, байгууллага, иргэд, гадаад дотоодын төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр, хоёрдугаар үе шат болох 2013-2021 онд төлөвлөгдсөн үйл ажиллагааны чиглэлийн 79 нь буюу 30.5 хувийг улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр, үлдсэн 69.5 хувь буюу 180 үйл ажиллагааны чиглэлийг ААНБ, иргэд, гадаад дотоод төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр тус тус шийдвэрлэхээр тооцсон болно.

Сүүлийн 10 жилд аймгийн төсвийн зарлага жил тутам дунджаар 8 хувиар өссөнийг харгалзан үзвэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх 14 жилийн хугацаанд улс аймгийн төсөвөөс 353.1 тэрбум төгрөгийг зарцуулахаар тооцоо гарч байна.

Хөтөлбөрт тусгагдсан ДНБ-ний өсөлтийг хангахад НҮБ-ын аргачиллаар 2007 – 2021 онд 245.1 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалт хийх тооцоо гарч байна. Үүнд томоохон орд газрыг ашиглах, төмөр зам тавих зэрэг гадаадын хөрөнгө оруулалт ороогүй болно.

Шаардлагатай хөрөнгийг санхүүжүүлэхэд дор дурдсан эх үүсвэрийг ашиглах чиглэлийг баримтлана. Үүнд:

- Дотоодын банк, санхүүгийн эх үүсвэрийг бүрэн ашиглах;
- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжих;
- Хуримтлал бий болгох хүн амын сонирхлыг хөхүүлэн дэмжих, бэлэн мөнгийг төвлөрүүлэн ашиглах механизм, эдийн загийн урамшууллын тогтолцоог бий болгох,

- Дотоодын хөрөнгө оруулалтыг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн ашиглах оновчтой арга механизм, хөшүүргийг бий болгох;
- Үл хөдлөх хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулах хөшүүргийг боловсронгуй болгох;
- Бага хүүтэй, урт хугацаатай зээлийн хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Бүсийн эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөө бүхий төслүүдийг санхүүжүүлэх зориулалттай "Бүс нутгийн хөгжлийн сан" байгуулж ажиллахыг идэвхтэй дэмжих,
- Гадаадын улс орон, олон улсын байгууллагаас хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор хөнгөлттэй зээл, буцалтгүй тусламж авах;
- Гадаадын хөрөнгө оруулалтыг татах таатай орчин бүрдүүлэн хамтарсан үйлдвэрүүдийг байгуулан ажиллуулах

### **5.3.Хөтөлбөрийн эдийн засгийн гол үр дүн**

Хөтөлбөрийг хэрэгжүүрсний үр дүнд 2021 он буюу Ардын хувьсгалын 100 жилийн ойгоор Сэлэнгэ аймаг төвийн бүсийн аж үйлдвэр, ХАА, олон улсын худалдаа үйлчилгээний томоохон төв болж өөрийгөө бүрэн нөхөх эдийн засагтай болно.

Эдийн засгийн бодит өсөлт 15-20 хувьд хүрч 2012он гэхэд зэрэгцүүлэх үнээр бодсон дотоодын нийт бүтээгдэхүүн 2006 онтой харьцуулахад 2.3 дахин өсөж боловсруулах үйлдвэрлэлийн хувийн жин нэмэгдэнэ. Мөн хөдөлмөрийн бүтээмж 4 дахин өсөж хүмүүсийн бодит орлого тэр хэмжээгээр нэмэгдэх юм. 2021 он гэхэд 1 хүнд ноогдох ДНБ 3000 ам долпарт хүрч улсын дундаж түвшин хүрч хүмүүсийн аж амьдрал сайжрах боломжтой болно.

### **5.4. Хөтөлбөрийн хяналт шинжилгээ үнэлгээ**

Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилт, гарч буй үр дүнд үнэлгээ өгч, хүндрэл, бэрхшээл тасалдлыг арилгаж хэрэгжих таатай нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Хяналт-шинжилгээ, үнэлгээг хөтөлбөрийн бүлэг, дэд бүлэг бүрт багтсан тэргүүлэх зорилтуудын хүрээнд тусгасан үзүүлэлтүүдийг үндэслэн хийнэ.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн эхний үе шатны хяналт-шинжилгээ, үнэлгээг 2012 онд, хоёрдугаар үе шатны хөтөлбөрийн хэрэгжилтийн дүнг 2021 онд тус тус гаргана.